



**Залуучуудын дундах
хүчирхийллийг урьдчилан
сэргийлэх нь**

НОТЛОХ БАРИМТЫН ТОЙМ



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**Залуучуудын дундах
хүчирхийллийг урьдчилан
сэргийлэх нь:
нотлох баримтын тойм**

2017 он

ДАА - 611
ННА - 51
3-233

Анхны хэвлэл “Preventing youth violence: an overview of the evidence” (англи хэл дээр) нэрээр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2015 онд хэвлэв.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага нь уг бүтээгдэхүүнийг монгол хэл дээр орчуулан хэвлэх эрхийг Нээлттэй Нийгэм Форум байгууллагад олгосон ба уг байгууллага нь монгол хэл дээрх бүтээгдэхүүний чанар, үнэн зөв байдлыг бүрэн хариуцна. Англи, монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарах юм бол англи хэл дээрх эхийг эцсийн бөгөөд үнэн зөв хувилбар гэж тооцно.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: Нотлох баримтын тойм

© Нээлттэй Нийгэм Форум 2017

ISBN 978-99978-59-12-9

Орчуулсан: Н. Энхтуяа

Хянан тохиолдуулсан: Н.Оюут-Эрдэнэ
А.Гэрэлмаа

“BCI” ХХК-д хэвлэв.

Энэхүү номын хавтас болон бүлгүүдийн эхэнд орсон зургийг хэвлэх зөвшөөрөл олгосон www.yolo.mn болон www.gogo.mn сайтын ажилтнуудад талархал илэрхийлье.

Агуулга

Агуулга	iii
Талархал	vi
Өмнөх үг	vii
Хураангуй.....	ix
Удиртгал	1
Энэ гарын авлагыг хэн унших ёстой вэ?	1
Энэхүү гарын авлагыг хэрхэн боловсруулсан бэ?	1
Агуулгын тойм	2

Бүлэг 1. Залуучуудын дундах хүчирхийлэл: тодорхойлолт, хувь хэмжээ, үр дагавар..... 3

Тодорхойлолт: залуучуудын дундах хүчирхийллийн нөхцөл байдал	4
Залуучуудын дундах хүчирхийлэл: цар хүрээ, хувь хэмжээ, үр дагавар.....	5
Хүн амины хэрэг	6
Хүний амь насанд хүрээгүй хүчирхийлэл.....	7
Хүчирхийллээс үүдсэн гэмтлийн улмаас эмнэлгийн яаралтай тусламж авсан залуучууд	7
Өөрөө мэдүүлсэн хэрэг ба хохирол.....	8
Болзооны үеийн хүчирхийллийн тархалт.....	9
Бэлгийн хүчирхийллийн тархалт	9
Хүний амь насанд хүрээгүй хүчирхийллийн үр дагавар.....	10
Нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй үр дагаврууд	12

Бүлэг 2. Залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлс.. 13

Залуучуудын хүчирхийлэлд хамгийн их хамааралтай эрсдэлт хүчин зүйлс.....	15
Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан байдал.....	15
Нийгмийн эсрэг зан үйлтэй найз нөхөд ба нийгмийн сул холбоо харилцаа	15
Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ	17
Хүйс	17
Өрхийн нийгэм, эдийн засгийн байдал.....	17
Эцэг, эх нь нийгмийн эсрэг зан үйл, гэмт хэрэгт холбогдож байсан байдал.....	18
Түрэмгий зан авир, хүчирхийлэлд холбогдож байсан байдал.....	18

Хүүхэдтэй зүй бус харьцах нь.....	18
Хүүхэд хүмүүжүүлэх ур чадвар ба эцэг эх, хүүхдийн харилцаа: хараа хяналт, хүмүүжлийн арга барил, дотно харилцаа.....	19
Сургуульд хандах хандлага/сурлага	19
Сэтгэл зүйн төлөв байдал	19
Залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой бусад эрсдэлт хүчин зүйлс	19
Хувь хүний түвшний эрсдэлт хүчин зүйлс.....	20
Гэр бүл, ойрын хүрээллийн түвшний эрсдэлт хүчин зүйлс.....	20
Орон нутгийн түвшний эрсдэлт хүчин зүйлс.....	20
Нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлс.....	20
Эрсдэлт хүчин зүйлсийн тухай мэдлэгийг хөтөлбөр, арга хэмжээ боловсруулах, төлөвлөхөд ашиглах нь.....	22

Бүлэг 3. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхтэй холбоотой ямар баримт нотолгоо бүрдээд байна вэ? 23

Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратегиуд.....	25
Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр.....	25
Эцэг эхийн боловсролын хөтөлбөр.....	28
Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр.....	32
Сургуульд түшиглэсэн сурлагын амжилтыг ахиулах, нийгмийн харилцааны чадвар хөгжүүлэх стратеги.....	36
Амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх нь	36
Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр	38
Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөр.....	41
Болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр.....	43
Өсвөр насныхны хичээлийн ирцийг дэмжих санхүүгийн урамшууллын хөтөлбөр	45
Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад үйл ажиллагаа.....	49
Хүчирхийлэлд холбогдох өндөр эрсдэлтэй, эсвэл хүчирхийлэл үйлдэж байсан залуучуудад чиглэсэн стратеги	52
Мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр.....	55
Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр.....	57
Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллээс сэргийлэх хөтөлбөр	60
Орон нутаг болон нийгмийн түвшний бодлого, хөтөлбөр.....	63
Олон нийтийн ба тодорхой асуудлаарх цагдан сэргийлэх үйл ажиллагаа.....	67
Согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах нь.....	69
Хар тамхи, мансууруулах бодисын хяналтын хөтөлбөр	72
Хот төлөвлөлт, орчны тохижилт	78
Ядуурлын төвлөрлийг сааруулах нь	81

Бүлэг 4. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх стратегиудын үр нөлөө85

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр засаг, иргэний нийгэм юу хийж чадах вэ?.....	87
1. Урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь.....	90
Эрүүл мэндийн салбарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь.....	90
Бусад салбарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь.....	90
Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь	91
2. Салбар хоорондын түншлэлийг хөгжүүлэх нь	93
Бусад салбаруудтай зөвлөлдөх нь.....	93
3. Залуучуудын дундах хүний амь хохироосон болон хүний аминд хүрээгүй хүчирхийллийн талаарх өгөгдөл, эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийн тухай мэдээлэл цуглуулах хэрэгцээ, ач холбогдлыг таниулах нь.....	94
Залуучуудын дундах хүчирхийллийн талаарх мэдээллийн эх сурвалжууд ..	95
Мэдээлэл бүрдүүлэлтэд Эрүүл мэндийн яамны үүрэг роль	95
Хүчирхийлэл, гэмтлийн талаарх мэдээллийн систем бий болгох нь	97
Залуучуудын дундах хүчирхийллийн талаар судалгаа яагаад чухал вэ?	97
Бэлэн байгаа мэдээллийг судалгаагаар баяжуулах нь	98
Мэдээллийг нэгтгэх, түгээх нь.....	98
4. Одоо хэрэгжиж байгаа урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг үнэлэх чадавхыг нэмэгдүүлэх.....	99
Залуучуудын дундах хүчирхийлэлд хүн амын түвшний мониторинг хийх нь.....	99
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилго бүхий тодорхой хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ.....	100
5. Бодлогын хүрээг тодорхойлох нь.....	101
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь	102
Салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө.....	102
Эрх зүйн арга хэмжээ.....	103
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд онцгой чухал хуулиуд	103
6. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх нь.....	104
Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх нь	104
Үр нөлөөтэй сүлжээний үйл ажиллагааг дэмжих нь	105

Дүгнэлт106

Ном зүй.....108

Талархал

Энэхүү гарын авлагыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нэгжийн Халдварт бус өвчин, хөгжлийн бэрхшээл, хүчирхийлэл, осол гэмтлийн урьдчилан сэргийлэлтийн удирдлагын хэлтсийн Берит Кисельбах, Александ Бутчарт нар бичиж боловсруулан, Франциска Мейнк хянан тохиолдууллаа. Мөн ДЭМБ-ын Халдварт бус өвчин, хөгжлийн бэрхшээл, хүчирхийлэл, осол гэмтлийн урьдчилан сэргийлэлтийн удирдлагын хэлтсийн Кристофер Миктон нь тайлангийн концепцийг гаргах, эхийг хянахад үнэтэй хувь нэмэр оруулав. Анжела Бартон техникийн хяналтыг хариуцаж ажиллав.

Дебора Фрай, Габриэлл Инглис, Тали Киссиди, Ричард Мацопуолос нар хэд хэдэн асуудлаар судалгааны тойм бэлдэж өгсөн бол Наоми Переда Белтран, Жудит Абад Гил нар испани хэл дээрх, Лила Каземиан нь франц хэл дээрх мэдээллийн боловсруулалтад тусалсан юм.

Энэхүү гарын авлагыг гаргахад залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлаар шинжлэх ухааны үндлэлтэй баримт, нотолгоог тоймлон бэлдэж өгсөн гадны шинжээчдийн томоохон хувь нэмрийг дурдалгүй өнгөрч болохгүй. Марк Беллис, Динеш Сети нарын удирдсан шинжээчдийн багт Анна Альвацци дел Фрате, Патрик Бартон, Линда Далберг, Мануэль Эйснер, Дебора Фрай, Жоанн-Саскиа Гей, Жан Оле Хаагенсен, Тулио Кан, Анна Рау, Екатерина Романова, Маргарет Шоу, Беттина Силбернагль, Гари Слуткин, Катерин Ворд, Элизабет Ворд нар гишүүнээр ажилласан юм.

Маргит Авердик, Марк Беллис, Жованна Кампелло, Линда Дальберг, Иоханнес де Хаан, Жозеф Мюррей, Динеш Сетхи, Маргарет Шоу, Катерин Ворд нарын өгсөн шүүмж үнэтэй хувь нэмэр болсон юм.

Жакобс сан, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, АНУ-ын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн төвийн өгөөмөр дэмжлэгээр энэхүү баримт бичгийг боловсруулж, хэвлэв.

Өмнөх үг

Дэлхий даяар нэг жилд л 10-29 насны 200,000 хүүхэд, залуус амь насаа алдаж байна. Хүн амины хэрэг нь хүүхэд, залуучуудын нас баралтын дөрөв дэх тэргүүлэх шалтгаан болоод байгаа ба үүнээс гадна хүчирхийлэлд өртсөн сая сая хүүхэд, залуус яаралтай эмнэлгийн тусламж шаардсан гэмтэл, бэртэл авч, үүнээс ч олон залуус хүчирхийллийн улмаас сэтгэцийн эрүүл мэндээрээ хохирч, архи, тамхи, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэх, аюултай бэлгийн харилцаанд орох зэрэг эрсдэлт зан үйлтэй болж байна. Хүүхэд, залуучуудын дундах хүчирхийлэл нь өртсөн хүн, тэдний хайртай дотнын хүмүүс, найз нөхдөд сэтгэл санааны асар их хор хохирол учруулж, амьдралыг нь сүйтгэдэг. Хүчирхийллээс үүдэлтэй эдгээр үр дагавар нь нийгэмд ч тэр, хохирогчдын ар гэрт ч тэр эдийн засгийн хүнд дарамт болдог.

Залуучуудын дундах хүчирхийлэл бол “гэнэт л гараад ирдэг” зүйл биш юм. Харин ч эсрэгээрээ сургууль дээрх дарамт дээрэлхэлт, цэнгээний газар, клуб, орон гэрт архитай холбоотой гардаг хүчирхийлэл, гэмт бүлэглэл юмуу хууль бус мансууруулах бодисын наймаатай холбоотой хүчирхийлэл гээд ямар хэлбэрээр илрэхээс үл хамааран залуучуудын хүчирхийлэл нь урьдчилан таамаглаж болох, тиймээс урьдчилан сэргийлж болох үзэгдэл юм. Сүүлийн арван жилд залуучуудын дундах хүчирхийлэлд хөтөлдөг эрсдэлт хүчин зүйлсийг багасгах, хүчирхийллээс хамгаалах нөлөөтэй хүчин зүйлийг дэмжих зорилготой төрөл бүрийн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлснээр хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх хүмүүсийн тоо буурч байгааг харуулсан олон судалгаа хэвлэгдэн гарч байна. Эдгээр судалгааны ихэнх нь хүн амины хэрэг, залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой бусад үзүүлэлтээ сүүлийн 10 жилийн дотор огцом бууруулж чадсан Австрали, Канад, Их Британи, АНУ зэрэг өндөр орлоготой улс оронд хийгджээ. Нөгөөтэйгүүр, залуучуудын хүчирхийллийн асуудал хурцадмал хэвээр байгаа дунд орлоготой орнуудад ч сайн туршлага бий болж, нэмэгдсээр байгаагийн заримыг уг гарын авлагад багтаалаа. Мөн уг гарын авлагад залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой хөтөлбөр, арга хэмжээг дэмжсэн бодлогын орчин бий болгохтой холбоотой тодорхой саналуудыг тусгалаа.

Энэхүү гарын авлага нь бодлогын хүмүүс, ялангуяа хүн хүч, санхүүгийн хязгаарлагдмал нөхцөлд ажиллаж буй бодлого, хөтөлбөр боловсруулагчдад залуучуудын дундах хүчирхийллийн асуудалд баримт, нотолгоотой хандахад туслах зорилготой. Уг гарын авлага нь зарим хүүхэд, залуус яагаад бусдаас илүүтэйгээр хүчирхийлэлд холбогдоод байдаг, энэ төрлийн хүчирхийлэл тодорхой хүн амын бүлэг, тодорхой орон нутагт яагаад бусад газраас илүүтэй төвлөрөх хандлагатай байдгийг ойлгоход тус болох шинжлэх ухааны суурьтай арга зүйг санал болгож байгаа юм. Энэхүү арга зүй нь хүний өнөөдөр гаргаж буй зан үйл нь хөгжлийн өмнөх үе

шатууддаа туулсан амьдралын туршлагаас нь үүдэлтэй гэж үздэг амьдралын үе шатны онолд түшиглэсэн юм. Мөн уг арга зүй нь залуучуудын дундах хүчирхийлэлд хувь хүний зан чанар, тэдний гэр бүл, үе тэнгийнхэнтэйгээ тогтоосон холбоо харилцаа, амьдарч буй орон нутаг, нийгмийнх нь эдийн засгийн тэгш бус байдал, архи, согтууруулах ундааны хэрэглээ зэрэг нөхцөл байдал нөлөөлж байдаг гэж үздэг.

Зөвхөн залуучууд гэлтгүй ер нь л хувь хүмүүсийн хооронд гардаг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн салбар чухал үүрэгтэй тул ДЭМБ энэ асуудлаар ажилладаг. Тухайлбал, эрүүл мэндийн салбар нь хүчирхийллийн хохирогчдод эмчилгээ, үйлчилгээ үзүүлж, энэ явцдаа санхүүгийн ихээхэн ачааллыг үүрдэг. Цагдаа юмуу захиргааны байгууллагад мэдээлснээс хэд дахин их тооны хүчирхийллийн хохирогч эрүүл мэндийн байгууллагад ханддаг тул эрүүл мэндийн салбар нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг илүү бүрэн дүүрэн мэдээллээр хангаж, гарсан үр дүнг нь илүү бодитойгоор үнэлэх боломжтой. Түүнчлэн эрүүл мэндийн салбар нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилго агуулсан архины зохисгүй хэрэглээг бууруулах гэх мэт тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг.

Гэвч эрүүл мэндийн салбар бол энэ хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, үр дүнг нь урт хугацаанд хадгалахад оролцох ёстой олон салбарын ердөө нэг нь билээ. Тиймээс энэхүү гарын авлага нь олон салбар, юуны түрүүнд энэ төрлийн хүчирхийлэлд хүргэдэг эрсдэлүүдийг бууруулж, түүнээс хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй эрүүгийн эрх зүйн салбар (эрүүл мэндийн салбарын хамтаар залуучуудын дундах хүчирхийллийн шууд нөлөөг үүрч явдаг), боловсрол, нийгмийн хөгжил, нийгмийн хамгааллын салбаруудыг хамтран ажиллахад уриалж байна.

Хураангуй

Хүчирхийлэл бол “бусад хүн, бүлэг хүний эсрэг амь насыг нь хохироох, хэвийн хөгжилд нь саад болох, бие махбод, сэтгэл санааны гэмтэл учруулах эрсдэлтэй байдлаар биеийн хүч юмуу эрх мэдлийг санаатайгаар ашиглах юмуу ашиглахаар заналхийлэх үйлдэл” (1) гэж тодорхойлдог. Залуу хүмүүсийн дундах хүчирхийллийн асуудлаарх судалгаа, хөтөлбөрүүд нь голдуу 10–29 насныхныг хамардаг ч энэ төрлийн хүчирхийлэл бүр бага наснаас илрэх нь бий.

Дэлхийн хэмжээнд 10-29 насны хүүхэд, залуучуудын дунд жил бүр 200,000 хүн амины хэрэг гардаг ба энэ нь насны бүлгийн хүн амын дундах нас баралтын зонхилох дөрөв дэх шалтгаан болоод байна. Амь насаа бусдын гарт алдсан уг насны хүмүүсийн 83 хувь нь эрэгтэйчүүд ба хүн амины хэргүүд бүгд шахам бага болон дунд орлоготой улс орнуудад гарчээ (2). Бусдын гарт амиа алдсан нэг залуу хүний цаана эмнэлэгт хандах хэмжээний гэмтэл авсан олон арван залуус байгаа. Үхэл, гэмтэл авчрахаас гадна залуу хүмүүсийн дундах хүчирхийлэл нь сэтгэцийн эрүүл мэндийн доройтох, архи, тамхи, хар тамхины хэрэглээ, хамгаалалтгүй бэлгийн харилцаа зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй зан үйл нэмэгдэх үр дагаварт хүргэх магадлалтай. Залуу хүмүүсийн дундах хүчирхийлэл нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, эрүүгийн эрх зүйн салбарын зардлыг үлэмж нэмэгдүүлж, бүтээмжийг бууруулан, хүчирхийлэл гарсан орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн үнэ унахад хүргэн, нийгмийн харилцааг муутгах сөрөг нөлөө үзүүлдэг. Улмаар залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх сайн хөтөлбөр нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хөгжлийн олон үзүүлэлт сайжрахад нөлөөлж, эдийн засгийн багагүй хэмнэлт авчирдаг байна.

Залуучуудын дундах хүчирхийлэл нь янз бүрийн түвшний хүчин зүйлстэй холбоотой бөгөөд хүний амьдралын янз бүрийн үе шатанд илэрч болно. Хувь хүний түвшний эрсдэлт хүчин зүйлсэд өмнө нь гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан юмуу түрэмгий зан гаргаж байсан түүх; хэт хөдөлгөөншил, зан төлөвийн өөрчлөлт зэрэг сэтгэлзүйн байдал; согтууруулах ундаа, хар тамхины хэрэглээ багтана. Ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлсэд эцэг эхийн анхаарал дутмаг нөхцөлд өсөх; эцэг эх нь хатуу ширүүн, тууштай бус хүмүүжлийн арга хэмжээ хэрэглэж ирсэн; эцэг эх нь гэмт хэрэгт холбогдож байсан; хэрэг зөрчил гаргадаг залуустай найзлах зэрэг багтана. Орон нутгийн түвшний эрсдэлт хүчин зүйлсэд тухайн орон нутгийн гэмт хэргийн түвшин; гэмт бүлэглэл; галт зэвсэг, хууль бус бодис, хар тамхи, согтууруулах ундааны хялбар олдоц; ажилгүйдэл; орлогын ялгаа, ядуурал төвлөрсөн байх зэрэг багтана. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь хүчирхийлэлд хүргэдэг эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, эсвэл өөр бусад арга замаар хувь хүн, орон нутгийн түвшний эрсдэлт хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөс залуу хүмүүсийг хамгаалах зорилго агуулдаг.

Хэдийгээр залуучуудын үйлдсэн хүчирхийллээс үүдэлтэй дарамт ачааллыг бага, дунд орлоготой улс орнуудад илүүтэй үүрдэг ч урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг судалсан судалгаа, үнэлгээнүүд бараг бүгд Австрали, Их Британи, Баруун Европын хэдэн улс, АНУ зэрэг өндөр орлоготой улс оронд хийгдсэн байна. Хувь хүн, ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлсэд анхаарсан бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлсэн судалгаанууд цөөнгүй байдаг бол орон нутгийн ба нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлсэд нөлөөлөх бодлого, стратегийн үр нөлөөг судалсан нь бага байна. Урьдчилан сэргийлэх стратегиуд нь бага наснаас анхаарч эхэлж байгаа нь сайшаалтай ч бага насанд үзүүлсэн үйлчилгээ, дэмжлэг нь өсөж том болохын хэрээр өсвөр болон залуу насанд хүчирхийллээс хамгаалж чадаж байгаа эсэхийг авч үзсэн урт хугацааны судалгаа цөөн байна. Өнөөгийн судалгааны баазын ийм хязгаарлагдмал байдлыг харгалзан байж доорх Хүснэгтийг боловсруулсан ба уг Хүснэгтээс гарын авлагад багтсан залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх стратеги, тэдгээрийн үр нөлөөний талаарх тойм мэдээллийг үзэх боломжтой. Стратегиудыг ямар орчин нөхцөлд ашиглаж байгаагаас хамааруулан 4 бүлэгт багцлан харууллаа.

Хүснэгтээс харахад хэрэгжилтийн тодорхой орчин нөхцөл бүрт үр нөлөөтэй байх өндөр магадлалтай урьдчилан сэргийлэх ядаж нэг стратеги байгаагийн хажуугаар баримт нотолгоо дутагдалтай тул үр нөлөөтэй эсэх нь тодорхойгүй өөр олон стратеги байна. Бага насны хүүхдийн асуудлаар хүүхэд хүмүүжүүлэх ур чадварт сургах эцэг эхийн хөтөлбөр, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь үр нөлөөтэй байх өндөр магадлалтай байгаа бол гэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээ нь хүүхэд өсөж өсвөр насанд хүрсэн хойно хүчирхийллээс үр дүнтэй хамгаалж чадаж байгаа эсэхийг нэмж судлах шаардлагатай байна.

Сургуульд түшиглэсэн бодлого, хөтөлбөрийн дотроос амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөр, үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр үр нөлөөтэй байх өндөр магадлалтай гэж үнэлэгдсэн бол сурлагын амжилтыг ахиулах хөтөлбөр, хичээл таслахгүй нөхцөлтэйгээр өсвөр насныханд санхүүгийн урамшуулал олгох хөтөлбөр, хичээлийн бус цагийн болон чөлөөт цагийн бусад арга хэмжээ зэргийг үргэлжлүүлэг судалж, үр нөлөөтэй эсэхийг нь тогтоох шаардлагатай байна. Болзооны үеийн хүчирхийллийг сэргийлэх хөтөлбөр, үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр нь холимог үр дүнтэй байгаа ба ялангуяа үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр зарим тохиолдолд хүчирхийллийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй байна гэж зарим судалгааны дүгнэлтэд дурджээ.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх стратегиудын үр нөлөө, хэрэгжүүлэх орчин нөхцөлөөр бүлэглэсэн байдал

Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратегиуд	Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр	?
	Эцэг эхийн боловсролын хөтөлбөр	+
	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	+
Сургуульд түшиглэсэн сурлагын амжилтыг ахиулах, нийгмийн харилцааны чадвар хөгжүүлэх стратегиуд	Амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх	+
	Үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	+
	Сурлагын амжилтыг ахиулах хөтөлбөр	?
	Болзооны үеийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр	+/-
	Хичээл таслахгүй нөхцөлөөр өсвөр насныханд санхүүгийн урамшуулал олгох хөтөлбөр	?
	Үе тэнгийн зөвлөх	+/-
	Хичээлийн бус цагийн ба чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад арга хэмжээ	?
Хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй болон өмнө нь хүчирхийлэлд холбогдож байсан залуучуудад чиглэсэн стратегиуд	Эмчилгээ заслын арга хэмжээ	+
	Мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр	?
	Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр	?
	Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр	?
Орон нутаг болон нийгмийн түвшний стратегиуд	Гэмт хэрэг, хүчирхийлэл гардаг цэгүүдэд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа	+
	Олон нийт, мөн тодорхой асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа	+
	Архи, согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах	+
	Хар тамхины хяналт	+
	Галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг бууруулах	+
	Хот төлөвлөлт, орчны тохижилт	+
	Ядуурлын төвлөрлийг сааруулах	+

Тайлбар

- +** үр нөлөөтэй байх өндөр магадлалтай (хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөхөөс залуучуудыг хамгаалж байгаа нь наад зах нь нэг судалгаагаар нотлогдсон, эсвэл эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсэд эергээр нөлөөлж байгаа нь наад зах нь хоёр судалгаагаар нотлогдсон нэг болон түүнээс олон хөтөлбөрийг багтаасан стратеги)
- ?** нотлох баримт дутагдалтай учраас үр нөлөөтэй эсэх нь тодорхойгүй (үр нөлөө нь тодорхойгүй нэг юмуу хэд хэдэн хөтөлбөр багтаасан стратеги)
- +/-** холимог үр дүнтэй тул үр нөлөө нь тодорхойгүй (судалгаагаар зарим хөтөлбөр нь эерэг, зарим нь сөрөг нөлөөтэй гарсан тул стратеги бүхэлдээ холимог үзүүлэлттэй үнэлэгдсэн)

Хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй бүлэгт чиглэсэн стратегиудын аваад үзвэл түрэмгий зан гаргадаг залуучуудад чиглэсэн эмчилгээ заслын (танин мэдэхүй, зан үйлийн эмчилгээ) үйлчилгээ хүчирхийлэл үйлдэхээс сэргийлж чадаж байгаа нь нотлогдсон бол мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөн дэмжих менторын үйлчилгээ, гэмт бүлэглэл болон гудамжны хүчирхийллээс сэргийлэх хөтөлбөрүүдийн хувьд үр нөлөөг нь нотлох баримт хангалтгүй байна.

Орон нутаг, нийгмийн түвшинд бол гэмт хэрэг их гардаг цэгүүдэд чиглэсэн, мөн олон нийт болон тодорхой асуудалд төвлөрсөн цагдаан сэргийлэх үйл ажиллагаа, архи, согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах хөтөлбөр, хар тамхины хяналт, галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг бууруулах хөтөлбөр, орчны тохижилт, ядуурлын төвлөрлийг бууруулах арга хэмжээ нь залуучуудыг хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөхөөс хамгаалах үр нөлөө үзүүлж чадаж байна гэж үнэлэгджээ.

Хязгаарлагдмал нөөцтэй орон нутагт урьдчилан сэргийлэх стратеги хэрэгжүүлэх гэж байгаа бол наад зах нь үйл ажиллагаа жигдэрсэн анхан шатны эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ болон хууль ёсны цагдаа, шүүхийн тогтоолцоо бий болсон байх шаардлагатай. Ийм нөхцөл бүрдээгүй орон нутагт эдгээр институцид түшиглэн хэрэгждэг урьдчилан сэргийлэх зарим стратеги үр нөлөөтэй байж чадахгүй. Иймээс залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд орлогын түвшин их ялгаатай, нийгмийн хамгаалал сул зэрэг хүчирхийлэл гарахад нөлөөлдөг нийгмийн хүчин зүйлсийг харгалзахын зэрэгцээ хуулийн шударга, үр нөлөөтэй, хариуцлагатай хэрэгжүүлэлтийг дэмжих институц, санхүүгийн болон хүний нөөцийг бэхжүүлэх цогц хандлагаар ажиллах шаардлагатай юм.

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн хандлагаар залуучуудын хүчирхийллийн хэлбэр, тархалтын талаар мэдээлэл тогтмол цуглуулж байх нь чухал бөгөөд энэ мэдээллийг хөтөлбөр, арга хэмжээ боловсруулан, хэрэгжүүлэхдээ ашиглаж байх ёстой юм. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөний тухай мэдээллийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч бүтцүүдэд дамжуулан тасралтгүй мониторинг, явцын сайжруулалт хийх боломжийг хангахад анхаарах хэрэгтэй. Нийгмийн эрүүл мэндийн хандлага нь салбар дундын мөн чанартай бөгөөд боловсрол, эрүүл мэнд, хууль зүй, нийгмийн хамгаалал, худалдаа, үйлдвэрлэлийн салбартай түншлэн хэрэгжүүлдэг. Энэхүү арга хандлага нь 4 алхмаас бүрдэнэ:

1. Тогтмол ашиглаж болох мэдээллийн эх сурвалж, судалгааны мэдээ статистикт үндэслэн энэ төрлийн хүчирхийллийн цар хүрээ, тархац, мөн чанар, үр дагаврыг тодорхойлох
2. Залуучуудын дундах хүчирхийллийг нэмэгдүүлэх юмуу бууруулах нөлөө үзүүлдэг эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлох, үүнд арга хэмжээ, хөтөлбөрийн үр дүнд өөрчлөн хувиргаж болох хүчин зүйлсийг мөн багтаана.

3. Хөтөлбөрт хамрагдах бүлгүүдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулж, үнэлгээ хийх замаар залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд үр дүнгээ өгч байгаа зүйлсийг олж илрүүлэх
4. Үрнөлөөтэй болон үрнөлөө өндөртэй байх магадлалтай арга хэмжээ, хөтөлбөрүүдийг янз бүрийн орчин нөхцөл хэрэгжүүлж, шийдвэрлэх асуудал, эрсдэлт хүчин зүйлд үзүүлж буй нөлөөг нь тогтмол ажиглан мониторинг хийх замаар эдгээр хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөө, өртөг зардлыг үнэлж байх зэрэг болно.

Нийгмийн эрүүл мэндийн хандлага нь залуу хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах ажлыг зохион байгуулахад ашиглах энгийн, ойлгомжтой аргачлал болж чадах ч төр засаг, урьдчилан сэргийлэх асуудалд хамааралтай бусад оролцогч талуудаар энэ аргачлалыг хүлээн зөвшөөрүүлэх, ашиглах дээр санал нэгдэх нь амар биш байдаг. Ер нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлж болно гэдэг нь шинэ санаа байх тохиолдол их гардаг тул асуудлыг нийгмийн эрүүл мэндийн арга хандлагаар шийдэж эхлэхээсээ өмнө шаардлагатай хүний нөөц, институцийн суурийг бий болгох нь чухал. Үүнийг системтэйгээр хийхийн тулд дараах асуудалд анхаарах хэрэгтэй:

- урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх;
- салбар хоорондын түншлэлийг бэхжүүлэх;
- залуучуудын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах магадлалтай хүчирхийлэл, түүнд нөлөөлдөг эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсийн талаарх мэдээлэл цуглуулахын ач холбогдлыг сурталчлан таниулах;
- одоо хэрэгжиж байгаа урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг үнэлэх чадавхыг нэмэгдүүлэх;
- эрх зүйн орчин бий болгох;
- залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чадавхыг хөгжүүлэх зэрэг болно.

Залуучуудын дундах хүчирхийлэл бол хялбар шийдэлтэй энгийн асуудал биш. Гэхдээ урьдчилан сэргийлэх чиглэлээр, ялангуяа хязгаарлагдмал нөөцтэй улс оронд урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлснээр ахиц дэвшил гаргах боломж бий. Энэ асуудлыг шийдвэрлэж эхлэхийг хүсэж байгаа аль ч улс орон аваад ашиглах хангалттай хэмжээний мэдлэг, туршлага дэлхийн хэмжээнд хуримтлагдаад байна.

Удиртгал

Энэхүү гарын авлагад залуучуудын дундах хүчирхийллийн тархалт, үр дагавар, түүнд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлсийн тухай мэдлэг, хүчирхийллийг гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн үр дүнг үнэлсэн судалгааны ажлын дүгнэлтийг нэгтгэн танилцуулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой саналуудыг тусгав. Судлагдсан урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг 21 стратеги болгон бүлэглээд, стратеги тус бүрт багтах тодорхой хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг нотлох баримтын хамтаар судлав. Стратеги бүрийг залуучуудын хүчирхийлэл ихтэй бага, дунд орлоготой орнуудад хэр тохирох талаас нь харж зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, институцийн механизмыг нь тайлбарлав.

Энэхүү гарын авлага нь хүчирхийлэл, дарамт үйлдэх, үүнд өртөх залуучуудын тоог бууруулахад тус болох зорилготой. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрүүд шаардлагатай. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй зэрэгцээд үр нөлөө, ахиц, дэвшлийг нь харуулан баримт нотолгоо бүрдүүлэх замаар хэрэгжилтийг улам түргэтгэх боломжтой болно.

Энэ гарын авлагыг хэн унших ёстой вэ?

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлого, хөтөлбөрийн нотолгоог тоймлон хүргэж буй энэхүү гарын авлагыг уг асуудлаар ажиллаж байгаа, ажиллахыг хүсэж байгаа бодлого боловсруулагч, иргэний нийгэм, бусад талуудад зориуллаа.

Гарын авлагын агуулга нь эрүүл мэнд, эрх зүй, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээ хариуцсан яам, эрүүгийн эрх зүй, дотоод хэргийн яамнаас гадна согтууруулах ундаа, зэвсгийн хяналт, нийгмийн хамгааллын хүртээмж зэрэг асуудлаар ажилладаг олон салбарт хамаатай. Залуучуудыг хүчирхийллээс хамгаалах ажилд санхүү, техникийн дэмжлэг үзүүлдэг олон улсын хөгжлийн агентлаг, сангууд, мөн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх талаар ойлгож мэдэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ үр дүнг үнэлж дүгнэхээр төлөвлөж буй хүмүүстэй хамтран ажилладаг судлаачдад энэ гарын авлага хэрэгтэй мэдээлэл болно.

Энэхүү гарын авлагыг хэрхэн боловсруулсан бэ?

Уг гарын авлагын хамрах хүрээ, агуулга ямар байх талаар залуучуудыг хүчирхийллээс хамгаалах асуудлаар ажилладаг дэлхийн 50 гаруй шинжээч, зөвлөхүүд 2002 оноос зөвлөлдөж эхэлсэн юм. Ийнхүү зөвлөлдөх явцдаа залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой, тогтмол хэрэгждэг 21 стратегийг тодорхойлж, 1998-2013 онд хэвлэгдэн гарсан (англи, франц, испани хэл дээр) урьдчилан сэргийлэх

стратегииуд, тэдгээрт багтах арга хэмжээний үр дүнгийн тайлан, мэдээг цуглуулж, шинжиллээ. Бодлого, хөтөлбөрийн тайлангуудын мэдээллийг анхлан тоймлохдоо ДЭМБ-аас нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж гаргахдаа ашигладаг Зөвлөмжийн үнэлгээ, боловсруулалт, үнэлгээний шаталбар аргачлал (Grading of Recommendations Assessment, Development and Evaluation буюу GRADE)-ын шалгууруудыг ашиглав (3).

Тодорхой хөтөлбөрийн нэг удаагийн үнэлгээнд хөтлөгдөн алдаатай дүгнэлт хийхээс хамгаалдаг дээрх аргачлал нь өргөн хүрээтэй өгөгдөлд мета түвшний дүн шинжилгээ хийх, эсвэл хараат бус хэд хэдэн үнэлгээний дүнг нэгтгэх системтэй тойм судалгаанд голдуу ашигладаг арга зүй юм. ДЭМБ-ын энэ аргачлалаар нотлох баримтыг тоймлох явцад залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх 21 стратегид багтсан арга хэмжээний үр дүнг нь баталгаажуулсан мета түвшний анализ, системтэй үнэлгээ маш цөөн, эсвэл мета-анализ, системтэй үнэлгээ хийгдсэн боловч мэдээлэл дутуу, дотоод зөрчилтэй зэргээс болж дүгнэлтүүдийг нэгтгэх, харьцуулах боломжгүй байдал нийтлэг байв. Тухайлбал, хөтөлбөрийн үзүүлэлтүүд, зорилтот бүлгийг тодорхой тайлбарлаагүй, тайлангуудад нэг хөтөлбөрийн өөр өөр үр дүн туссан, гарсан үр дүнг арга хэмжээний давтамжтай уялдуулж тайлбарлаагүй зэрэг асуудал түгээмэл байлаа.

Анхдагч тойм судалгааны үр дүнг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлаар мэргэшсэн, дэлхийн янз бүрийн бүсийг төлөөлөх 15 эксперт багаар судалж, судалгааны дүгнэлтүүд өөрсдийнх нь улс орон, бүс нутагт хэр хамаарах, хэрэгжүүлэх явцад ямар бэрхшээл тулгарах, хязгаарлагдмал нөөцтэй оронд авч хэрэгжүүлэх боломжтой эсэх талаас нь харж шинжилсэн юм. Шинжээчдийн баг тодорхой нэг стратегийг дэмжих, эсвэл татгалзах зөвлөмж өгөх боломжгүй гэж үзжээ. Харин нийгмийн эрүүл мэндийн салбарын бусад асуудлаар ч мэдээлэл дутмаг, тууштай бус байгаа өнөөгийн нөхцөлд тойм судалгааны үр дүнг лавлагаа ном хэлбэрээр хэвлэх, ингэхдээ уг номд багтах стратеги бүрийг стандарт бүтэцтэй загварын дагуу тайлбарлан нийтийн хүртээл болгох хэрэгтэй гэдэг дээр санал нэгджээ. Энэ багийн уулзалт хэлэлцүүлэгт тулгуурлан энэхүү гарын авлагын эхийг боловсруулаад, дараа нь мэргэжлийн хүмүүсээр хянуулж, эцэслэв.


Агуулгын тойм

1 дүгээр бүлэгт залуучуудын дундах хүчирхийллийн цар хүрээ, тархалт, үр дагавруудыг танилцуулав.

2 дугаар бүлэгт залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт ба хамгаалагч хүчин зүйлсийг тоймлон танилцуулаад, хүчирхийллийг урьдчилан сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр нь эдгээр хүчин зүйлсэд чиглэх ёстойг тайлбарлав.

3 дугаар бүлэгт залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх 21 стратегийн үр нөлөөний нотолгоог танилцуулаад, бага, дунд орлоготой орнуудад тэдгээрийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлсийг онцлов.

4 дүгээр бүлэгт залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилгод олон салбарын хамтын ажиллагааг хэрхэн дайчлах, энэ хамтын ажиллагааг хүний нөөц, институцийн ямар механизмуудаар дэмжих талаар санал бодлоо тусгав.



1

**Залуучуудын дундах
хүчирхийлэл: тодорхойлолт,
хувь хэмжээ, үр дагавар**

Тодорхойлолт: залуучуудын дундах хүчирхийллийн нөхцөл байдал


Хүчирхийлэл ба эрүүл мэндийн дэлхийн тайланд (1) “бусад хүн, бүлэг хүний эсрэг амь насыг нь хохироох, хэвийн хөгжилд нь саад болох, бие махбод, сэтгэл санааны гэмтэл учруулах эрсдэлтэй байдлаар биеийн хүч юмуу эрх мэдлийг санаатайгаар ашиглах юмуу ашиглахаар заналхийлэх үйлдэл” гэж тодорхойлжээ (х.5). Уг тайланд залуучуудын дундах хүчирхийлэл ихэнхдээ гэрээс гадуур орчинд, хамаатан садан бус, танил болон танил бус 10-29 насны хүмүүсийн хооронд үйлдэгддэг хэмээн дэлгэрүүлэн тайлбарлажээ. Дарамт дээрэлхэлт, зэвсэгтэй болон зэвсэггүй халдлага, гэмт бүлэглэлд нэгдэн хүчирхийлэл үйлдэх зэрэг нь залуучуудын дундах хүчирхийллийн зарим жишээ юм. Гэхдээ хүчирхийлэл үйлдэгч, хохирогчдын дотор 30-35 хүртэлх насныхан багагүй хувийг эзэлдэг тул хүчирхийллийг ойлгон, урьдчилан сэргийлэхэд насанд хүрэгчдийн энэ бүлгийг бас батгааж үзэх нь зүйтэй (4).

Залуучуудын дундах хүчирхийлэл нь хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн хамтрагчийн болон өөрийн эсрэг хүчирхийлэл зэрэг хүчирхийллийн бусад хэлбэртэй нягт холбоотой. Учир нь хүчирхийллийн эдгээр төрөл нь ижил эрсдэлт хүчин зүйлстэй байхаас гадна нэг нь нөгөөдөө эрсдэлт хүчин зүйл болж үйлчилдэг байна (жишээлбэл, зүй бус харьцааны хохирогч хүүхэд өсвөр насандаа үе тэнгийнхний эсрэг хүчирхийлэл үйлдэх магадлалтай). Иймд залуучуудын дундах хүчирхийллийг нийгэмдэх хүчирхийлэл гэсэн ерөнхий утгаар нь авч үзэх хэрэгтэй. **“Хүчирхийлэл ба эрүүл мэндийн дэлхийн тайлан”-д (1)** үйлдэгдсэн нөхцөл байдлаас нь хамааруулан хүчирхийллийг дараах 3 бүлэгт хувааж үзжээ:

- Өөрийн эсрэг хүчирхийллийг амиа хорлох, өөрийгөө гэмтээх гэж хоёр хувааж үздэг. “Амиа хорлох” ангилалд амиа хорлох бодол, оролдлого, үйлдлийг багтааж байгаа бол “өөрийгөө гэмтээх” гэсэн ангилалд өөрийн бие махбодыг зэрэмдэглэх зэрэг үйлдэл багтана.
- Хүмүүс хоорондын хүчирхийлэл гэж хувь хүмүүсийн хооронд хүчирхийлэл гарахыг хэлнэ. Дотор нь гэр бүлийн, бэлгийн хамтрагчийн, нийтийн гудамж талбайд гарах хүчирхийлэл зэрэг багтдаг байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл, ахмад настны эсрэг хүчирхийлэл зэргийг багтаасан ойлголт юм. Нийтийн орчин дахь хүчирхийллийг танил ба танихгүй хүмүүс үйлдсэн гэж 2 хувааж үздэг ба дотор нь залуучуудын дундах хүчирхийлэл, танихгүй хүний халдлагад өртөх, өмчийн эсрэг гэмт хэрэгтэй холбоотой хүчирхийлэл, ажлын байр болон бусад байгууллагад гарах дарамт, хүчирхийлэл зэргийг багтааж ойлгодог.
- Бүлгээр үйлдэх хүчирхийлэл гэж олон хүн нийлж үйлдэх хүчирхийллийг хэлэх бөгөөд дотор нь нийгэм, улс төр, эдийн засгийн гэж ангилж болно.

Эдгээр бүлэг, дэд бүлгийг нэгтгэж байгаа зүйл нь хүчирхийлэх үйлдлийн мөн чанар юм. Үйлдэл нь бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн ба үл хайхрах мөн чанартай байдаг. Хүчирхийллийг төрөл ба үйлдлийн мөн чанараар ангилж харвал (Зураг 1) нийгэмд байгаа хүчирхийлэл гэх өргөн хүрээт асуудал дунд залуучуудын хүчирхийлэл ямар орон зайг эзэлж байгааг ойлгоход тус болно.

ЗУРАГ 1.

Хүчирхийллийн төрөл хэлбэр

Эх сурвалж (1)

Залуучуудын дундах хүчирхийлэл нь өөр төрлийн хүчирхийлэлтэй давхцах нь элбэг байдаг. Жишээлбэл, багадаа зүй бус харьцааны хохирогч болж байсан хүүхэд хожим амиа хорлох, бэлгийн болон залуучуудын дундах хүчирхийлэл, бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл зэрэг өөр олон төрлийн хүчирхийллийн хохирогч, эсвэл үйлдэгч болох магадлал өндөр байдаг ажээ. Хүчирхийллийн хэд хэдэн төрөл хэлбэр нь архины зүй бус хэрэглээ, гэр бүл болон нийгмээс тусгаарлагдах, өндөр хувьтай ажилгүйдэл ба эдийн засгийн тэгш бус байдал зэрэг ижил хүчин зүйлсээр өдөөгдөж байгаа нь батлагдаад байна. Тиймээс хүчирхийллийн нэг төрлийг урьдчилан сэргийлэх зорилготой ч нийтлэг суурь хүчин зүйлсийг онилсон бодлого, стратеги нь хүчирхийллийн хэд хэдэн төрөл хэлбэрийг нэгэн зэрэг бууруулах боломжийг агуулж байдаг (5).

Залуучуудын дундах хүчирхийлэл: цар хүрээ, хувь хэмжээ, үр дагавар

Залуучуудын дундах хүчирхийлэл, түүний цар хүрээний талаарх мэдээллийн олдцыг пирамид хэлбэрээр илэрхийлбэл зохимжтой. Албан ёсны статистик мэдээнд хүчирхийллээс үүдсэн нас баралт хамгийн ихээр тусдаг ч энэ бол пирамидын зөвхөн оргил хэсэг юм. Үүний араас яаралтай эмнэлгийн тусламж, эмнэлэг-хууль зүйн үйлчилгээ юмуу бусад төрлийн

ХҮСНЭГТ 1

Дэлхийн хэмжээнд 10-29 насны залуучуудын нас баралтын тэргүүлэх 10 шалтгаан (2012)

Замын ослоос үүдсэн гэмтэл 3615151^a
ХДХВ / ДОХ 293920^a
Амиа хорлолт 256180^a
Хүн амины хэрэг 2053032^b
Эхийн эрүүл мэнд 151036^a
Амьсгалын доод замын халдвар 138151^b
Суулгалт 123236^a
Усанд живж осолдох 105576^a
Менингит 82032^a
Зүрхний ишеми 72038^a

Эх сурвалж:

^a Дэлхийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд: нас баралтын мэдээ; шалтгаан, нас, хүйс, улс орноор, 2002-2012. Женев; ДЭМБ

^b Дэлхийн эрүүл мэндийн ажиглалтын мэдээллийн сан: Хүн амины хэрэг, хүчирхийллийн урьдчилан сэргийлэлт, 2012 (<http://www.who.int/gho/violence/en/>)

үйлчилгээ авсан хүчирхийллийн хохирогч залуучуудын тухай мэдээлэл байрлана. Харин пирамидын доод хэсэг болох өргөн суурийг эрүүл мэндийн болон төрийн бусад байгууллагад мэдээлэгдэхгүй өнгөрсөн хүчирхийлэл (жишээлбэл, үе тэнгийнхний нэгнээ дээрэлхэх, дарамтлах үйлдэл) бүрдүүлнэ. Ийм л учраас залуучуудын дундах хүчирхийллийн гаралт, үр дагаврын ерөнхий нөхцөл байдлыг баримтжуулах чухал арга хэрэгсэл бол хүн амын асуулга юм. Гэвч сургууль дээрээ зодоон, дээрэлхэлтэд оролцсон тухайгаа өөрөө мэдээлэхээс өөр аргачлалтай судалгаа ихэнх улс, бүс нутагт ховор хийгддэг. Хүчирхийллийн хохирогчид мэдээллийн нууцыг чанд хадгалах нөхцөлтэй ганцаарчилсан ярилцлагын үеэр ч хүчирхийлэлд өртсөн талаараа тэр бүр ярихыг хүсдэггүй бөгөөд хүчирхийлэлд өртөн чимээгүй шаналж яваа ийм залуус мэдээллийн пирамидын суурь хэсэгт багтана. Жишээлбэл, сургууль дээрээ хүчирхийлэлд өртсөн хүүхдийн 30 хувь нь энэ талаараа хэнд ч хэлээгүй гэсэн судалгаа байдаг (6).

Хүний амь насанд хүрсэн болон хүрэлгүй өнгөрсөн хүчирхийллийн тухай өгүүлэх доорх хэсгээс харахад хүчирхийллийн төрөл хэлбэр, үр дагавар нь улс орон, бүс нутаг, хүйсээр ялгаатай тархалттай байна. Хүний амь насанд хүрсэн, мөн эмнэлэгт яаралтай хандахуйц ноцтой гэмтэл учруулсан хүчирхийллийн хохирогч нь дийлэнхдээ эрэгтэйчүүд байхад болзооны үеийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч нь дийлэнхдээ эмэгтэйчүүд байна. Хүчирхийллийн эрэгтэй, эмэгтэй хохирогчид бие махбод, сэтгэл санааны уршигт олон үр дагаврыг насан туршдаа амссаар байдаг хэрнээ ийм явдал болсон нь албан ёсны мэдээ статистикт тусахгүй өнгөрч байна.


Хүн амины хэрэг

Дэлхийн даяар жил бүр 10-29 насны 200,000 гаруй залуу хүн бусдын гарт амь насаа алддаг гэсэн мэдээ бий. Хүн амины эдгээр хэргийн дийлэнх нь бага, дунд орлоготой улс оронд гарсан байх ба хохирогчдын 83 хувийг эрэгтэйчүүд эзэлж байв. Хүн амины хэрэг нь дэлхийд залуучуудын нас баралтын тэргүүлэх дөрвөн шалтгааны нэг болоод байна (Хүснэгт 1-ийг үз).

Залуучуудын хүчирхийллээс үүдэлтэй нас баралтын хувь хэмжээ улс орон, бүс нутгуудад маш их ялгаатай байна. Залуучуудын амь насаа алдсан үзүүлэлт хамгийн багатай Баруун Европ, Номхон далайн баруун хэсгийн орнуудтай харьцуулахад Латин Америк, Карибын тэнгис, Африкийн Сахар орчмын зарим оронд энэ тоо хэдэн зуу гаруй дахин их байна.

Зураг 2-т 2012 оны байдлаарх дэлхийн хүн амины хэргийн гаралтыг нас, хүйсээр ялгаж харууллаа. 0-4, 5-9 насны бүлэгт хүн амины хэргийн хохирогчдын дунд хүйсийн ялгаа бараг байхгүй ч 0-4 насны бүлэг дэх нийт тоо 5-9 насны бүлгийнхээс даруй хоёр дахин их байна.

ЗУРАГ 2.

Дэлхий даяар 2012 онд 100,000 хүн тутамд гарсан хүн амины хэрэг (нас, хүйсээр)

Эх сурвалж: ДЭМБ. Дэлхийн эрүүл мэндийн ажиглалтын мэдээллийн сан: Хүн амины хэрэг, хүчирхийллийн урьдчилан сэргийлэлт, 2012 (<http://www.who.int/gho/violence/en/>)

10-29 насны залуучуудын бүлэгт амиа алдсан эрэгтэйчүүдийн тоо 5-9 насныхнаас 6 дахин их, эмэгтэйчүүдийнх 2 гаруй дахин их байна. 30-49 насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундах хүн амины хэргийн тоо 10-29 насны бүлгийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 50 ба түүнээс дээш насны бүлэгт эрэгтэйчүүдийн үзүүлэлт ихээхэн буурсан, эмэгтэйчүүдийнх өөрчлөлтгүй шахам байна.

Хүний амь насанд хүрээгүй хүчирхийлэл

Залуучуудын дундах хүний аминд хүрээгүй хүчирхийллийн хувь хэмжээг хүчирхийллээс үүдсэн гэмтлийн улмаас эмнэлгийн яаралтай тусламж авсан залуу хүний тоо, мөн хүчирхийлэлд оролцсон тухай өөрөө мэдээлсэн асуулгын дүнгээр гаргаж авах нь хамгийн найдвартай арга болно. Цагдаа, эрүүгийн шүүхийн салбарын мэдээлэл нь тухайн тогтолцоонд хандсан тохиолдлыг тооцоход тустай. Гэхдээ цагдаад мэдэгдсэн залуучуудын хүчирхийллийн нэг тохиолдол бүрийн цаана эмнэлгийн тусламж авсан боловч цагдаад бүртгэгдээгүй хэд хэдэн тохиолдол байдгийг судалгаа харуулсаар байна (7, 8). Иймд зөвхөн цагдаагийн мэдээлэлд найдах нь асуудлын бодит цар хүрээг дутуу үнэлэхэд хүргэх магадлалтай.

Хүчирхийллээс үүдсэн гэмтлийн улмаас эмнэлгийн яаралтай тусламж авсан залуучууд

Хүчирхийллийн улмаас гэмтэл авсан залуу хүмүүс эмнэлгийн салбарын зардал, үйлчилгээний томоохон хэсгийг эзэлдэг. Жишээлбэл, Бразил Улсад хийсэн үндэсний хэмжээний судалгаагаар нэг сарын хугацаанд хүчирхийллээс үүдэлтэй гэмтлийн улмаас эмнэлгийн яаралтай тусламж авахаар 4835 хүн хандсанаас 91 хувь нь бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийн хохирогчид байжээ. Хохирогчдын талаас илүү буюу 55 хувь нь 10-29 насныхан байжээ (9). АНУ-д 2013 онд халдлагын улмаас гэмтэл авч эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт эмчлүүлсэн 1,643,801 хүн байгаагийн 50 хувь нь 10-29 насныхан байжээ (10). Өмнөд Африкийн Кейптаун хотод 2010 оны 10 сараас 2011

оны 9 сар хүртэлх хугацаанд гэмтлийн төвд хандсан 9236 тохиолдлыг судлахад хүйтэн зэвсэг (21 хувь), мохоо зүйл (17 хувь) ашиглан гэмтэл учруулах нь их байсан бөгөөд нийт хохирогчдын 70 хувь нь эрэгтэйчүүд, тэдний 42 хувь нь 18-30 насныхан байжээ.

Өөрөө мэдүүлсэн хэрэг ба хохирол

Сургуульд түшиглэсэн сурагчдын эрүүл мэндийн дэлхийн судалгаа (The Global School-based Student Health survey буюу GSHS) нь хүчирхийлэлд оролцсон тухай өөрөө мэдээлэх асуулга бөгөөд энэ нь улс орнуудыг харьцуулж болох мэдээллийн цөөн эх сурвалжийн нэг болж байна. 13-15 настнуудаас бүрдсэн үндэсний төлөөллийн түүврээс асуулга авах аргачлалтай энэ судалгааг 100 гаруй оронд хийдэг (12). Хүснэгт 2-оос бага болон дунд орлоготой зарим оронд 2003-2013 онд судалгааны өмнөх 12 сарын хугацаанд зодоонд оролцсон (хохирогч эсвэл үйлдэгч), 30 хоногийн хугацаанд дарамт дээрэлхэлтэд өртсөн сурагчдын эзлэх жинг өөрийн мэдээлснээр гаргаж харууллаа.

ХҮСНЭГТ 2

Өөрийн мэдээлснээр зодоонд оролцсон, дарамт дээрэлхэлтэд өртсөн 13-15 настнуудын эзлэх хувийн жин (хүйс, улс орноор), 2003-2013

	Зодоонд оролцсон (сүүлийн 12 сард)		Дарамт дээрэлхэлтэд өртсөн (сүүлийн 30 хоногт)	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Африкийн бүс				
Бенин	35	27	43	41
Ботсвана	54	42	53	52
Малави	24	21	43	47
Свазиленд	27	14	33	3
Америкийн бүс				
Болив	45	21	32	28
Доминикан	48	30	29	26
Гондурас	36	21	32	28
Ямайка	61	39	40	39
Газрын дундад тэнгисийн зүүн бүс				
Египет	62	29	70	70
Ирак	50	22	32	22
Марокко	57	26	17	21
Катар	63	38	49	35
Зүүн Өмнөд Азийн бүс				
Индонез	48	20	55	45
Мальдив	45	17	45	39
Мьянмар	21	8	23	16
Тайланд	47	21	32	23
Номхон Далайн баруун бүс				
Малайз	45	17	45	39
Монгол	63	19	37	20
Филиппин	44	32	47	48
Самоа	73	62	79	69
Бүс нутгуудын дундаж				
	47	26	42	37

Эх сурвалж: ДЭМБ. Сургуульд түшиглэсэн сурагчдын эрүүл мэндийн дэлхийн судалгаа (<http://www.who.int/chp/gshs/en/>).

Сурагчдын дунд зодолдох, нэгнийгээ дээрэлхэж дарамтлах явдал их байгааг Хүснэгт 2 харуулж байна. Бүх оронд эрэгтэй хоёр сурагчийн нэг нь, эмэгтэй дөрвөн сурагчийн нэг нь судалгаа авахаас өмнөх 12 сарын хугацаанд зодоонд оролцсон гэж мэдээлжээ. Улс орноор задалж харвал, зодолдох явдал Мьянмарт 21 хувь байгаа нь хамгийн бага, Самоад 73 хувь байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа ба эмэгтэй сурагчдын хувьд Мьянмарт 8 хувь байгаа нь хамгийн бага үзүүлэлт, Самоад 62 хувь байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлт бүх орны дунджаар хөвгүүдийн дунд 42 хувь, охидын дунд 37 хувийн үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн хүчирхийлэлд хүйсийн ялгаа харьцангуй бага байгааг илтгэнэ. Үе тэнгийн дээрэлхэлтээр судалгааны өмнөх нэг сард эрэгтэй, эмэгтэй сурагчдын 70 хувь нь өртсөн үзүүлэлтээр Египет толгой цохиж байгаа бол хамгийн бага үзүүлэлттэй нь Марокко Улс байв (хөвгүүдийн 17 хувь, охидын 21 хувь).

Өөрөө мэдээлэх арга зүйг ашигласан Зөрчлийн олон улсын хоёрдугаар судалгаагаар голдуу Европ, Америк тивийн 31 орны 63 хотын 12-15 настай сурагчдын хүчирхийлэл үйлдсэн талаарх мэдээллийг бүрдүүлжээ (13). Өмнөх жилийн байдлаар ноцтой хүчирхийллийн хэмжээ улс орон, хотуудад 1.5-аас 8 хувийн хооронд байна. Харамсалтай нь, ДЭМБ-ын бусад бүс нутгаас харьцуулж болохуйц мэдээлэл олдсонгүй.

Болзооны үеийн хүчирхийллийн тархалт

Болзооны үеийн хүчирхийлэл бол бэлгийн хамтрагчийн хүчирхийллийн эхэн хэлбэр бөгөөд дийлэнхдээ өсвөр болон идэр насанд үйлдэгддэг. Хойд Америк, Европ тивийг хамруулсан болзооны үеийн хүчирхийллийн талаарх судалгаануудын системтэй тойм дүгнэлтээс харахад охидын 4.2-46 хувь, хөвгүүдийн 2.6-33 хувь нь өсвөр насандаа болзож байгаа хүний зүгээс бие махбодын хүчирхийлэлд өртөж байжээ. Судалгаанууд болзооны үеийн хүчирхийллийн янз бүрийн тодорхойлолт, тархалтыг хэмжих өөр өөр шалгуур үзүүлэлтүүд ашигласан явдал нь нарийн харьцуулалт хийх боломжгүй байдалд хүргэв. Африк тивийн хувьд, Өмнөд Африкт 13-23 насны 928 хүнийг хамруулсан судалгаагаар (15) эмэгтэйчүүдийн 42 хувь, эрэгтэйчүүдийн 38 хувь нь өсвөр болон идэр насандаа болзож байгаа хүнийхээ үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртөж байсан дүн гарчээ. Этиоп Улсад коллежийн 1378 оюутны 16 хувь нь бэлгийн хамтрагч ба хамтрагч бус хүний эсрэг бие махбодын хүчирхийлэл, 16.9 хувь нь бэлгийн хүчирхийлэл үйлдэж байсан гэж мэдээлжээ (16).

Бэлгийн хүчирхийллийн тархалт

Европ, Хойд Америкт болзох харилцаатай залуучуудын дунд бэлгийн хүчирхийллийн тархалт эмэгтэйчүүдийн хувьд 1.2-32.9 хувь, эрэгтэйчүүдийн хувьд 1-19 хувь байна (14). Бага болон дунд орлоготой зарим орны хүн амзүй, эрүүл мэндийн мэдээллээр (17) 15-19 насны охидыг хүч хэрэглэн бэлгийн хавьталд оруулсан тохиолдол Киргиз Улсад хамгийн бага буюу 0 хувь, Камерун Улсад хамгийн их буюу 22 хувь байна. 15-49 насны охид, эмэгтэйчүүдийн дунд хүч хэрэглэн анхны бэлгийн харьцаанд оруулсан тохиолдол Зүүн Тиморт 1 хувь, Балбад 29 хувь байжээ.

Хүний амь насанд хүрээгүй хүчирхийллийн үр дагавар

Залуучуудын өөрсдийнх нь мэдээлснээр, хүний амь насанд хүрээгүй хүчирхийлэл залуу хүмүүсийн дунд маш өргөн тархалттай байгаа бөгөөд энэ нөхцөлд хүчирхийлэлтэй холбоотой хүн амины хэргийн тоог хэд дахин нугалах тооны гэмтэл, сэтгэцийн эрүүл мэндийн доройтол, зан үйлийн сөрөг үр дагаврууд үүсэж байдаг байна. Хүн амины нэг хэргийн цаана дээрэм, танхайн халдлагын үеэр авсан ноцтой гэмтлээ эмчлүүлэхээр эмнэлэгт хандсан 20-40 тохиолдол байна гэсэн тооцоо бий (4). Үе тэнгийнхний дарамт, цохих, алгадах зэрэг залуучуудын дундах хүчирхийллийн бусад хэлбэр нь бие махбодын гэхээс илүүтэй сэтгэл санааны хохирол учруулдаг нь залуучуудын дунд хийсэн судалгаанд байнга тусдаг.

Харамсалтай нь, хүүхэдтэй зүй бус харьцаа, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн харилцагчийн хүчирхийлэл зэрэгтэй харьцуулахад залуучуудын дундах хүчирхийллээс үүдсэн гэмтлийн бус нийгэм, эрүүл мэндийн үр дагаврыг судалсан нь бага байна. Энэ нь залуучуудын дундах хүчирхийлэл ихэнхдээ бие махбодын шинжтэй, богино хугацааны үр дагавартай байдаг гэсэн буруу ойлголт бий болгож, урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр шаардах ажилд саад болох нь бий. Тиймээс ойрын хэдэн жилдээ залуучуудын дундах хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх нь хүний эрсдэлт зан үйлт, мөн биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал, хожим өөрийн болон бусдын эсрэг, бүлгээр үйлдэх хүчирхийлэлд оролцох магадлал зэрэг хүчирхийллийн шууд болон урт хугацааны үр дагаврыг ойлгох, тоон үзүүлэлтээр хэмжиж хэвших зорилт дэвшүүлж ажиллах шаардлагатай. Залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой эдийн засгийн шууд ба дам зардал, ачааллын тухай чухал асуудал өнөөдрийг хүртэл сайн судлагдаагүй байгаа бөгөөд Хойд Америкт тооцож эхлээд байгаа ч дэлхийн бусад оронд ийм судалгаа сул байна.

Гэмтэл. Залуучуудын дундах хүчирхийллийн улмаас нүүр, хүзүү, толгой, гар, хөлийн гэмтэл их учирч байна. Давтамжаар нь харвал, хамгийн түгээмэл нь нээлттэй шарх, дараа нь тархины доргилт, толгой хүзүүний ясны цууралт, түлэгдэлт орж байна. Хүчирхийлэлтэй холбоотойгоор цээж, хэвлийн хэсэг, хөл, гарын гэмтэл их тохиолддог. Ямайк Улсын эмнэлгийн яаралтай тусламжийн албаны судалгаагаар хамгийн түгээмэл гэмтэл нь хутгалуулах (52.1 хувь), битүү гэмтэл (37.9 хувь), бууны шарх (7.3 хувь) байжээ (18). АНУ-д бүрдүүлсэн мэдээллийн баазаас үзэхэд, галт зэвсэг ашигласан хүчирхийллийн улмаас хүний цээж, хэвлий болон хөл, гар гэмтэл авах нь их байдаг (10) бол хутга, хурц зэвсэг ашигласан үед толгой, гар, хөлд гэмтэл учрах нь их байна. Гэмтэл нь удаан хугацааны олон үр дагавар үүсгэхээс гадна хөгжлийн бэрхшээлд ч хүргэж мэднэ. Жишээлбэл, нуруу нугасны гэмтэлд хүргэдэг гол гурван шалтгааны нэг нь хүчирхийлэл байдаг.

Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эрсдэлт зан үйл. Өсвөр насандаа хүчирхийлэлд өртсөнөөр хүний бие, сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөөллүүд үүсдэгийг олон судалгаа батлаад байна. Жишээлбэл, үе тэнгийнхний хүчирхийлэл нь тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хөдөлгөөнгүй, идэвхгүй амьдрал, стресс зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй зан үйлтэй холбоотой. Эдгээр зан үйлийн хэд хэд нь зүрх судасны өвчин зэрэг халдварт бус өвчлөлийн шалтгаан болдог. Сургуульд

түшиглэсэн эрүүл мэндийн олон улсын судалгаа (GSHS)-нд оролцсон Африкийн 8 улсын мэдээллийг харьцуулж үзэхэд үе тэнгийнхний дарамт нь архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, бэлгийн эрсдэлт зан үйл нэмэгдэхэд шууд нөлөөлж, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эрсдэлт зан үйлийн өсөлт нь дарамтлуулж дээрэлхүүлсэн өдрийн тоотой шууд холбоотой байгаа нь харагдсан байна. Эрүүл мэндийн эрсдэлт зан үйлүүд нь хүчирхийлэлд өртсөний шууд үр дагавар болох сэтгэл гутралтайгаа тэмцэх арга зам болдог ажээ (21). Эрүүл мэндийн асуудалтай өсвөр насныхан хүчирхийлэлд өртөх нь их байдаг ч нөгөө талаас хүчирхийлэл нь эрүүл мэндийн олон асуудлын шалтгаан болдог тул залуучуудын хувьд хүчирхийлэл ба эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйл нь харилцан нөлөөлөх мөн чанартай байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үр дагавар. Хүчирхийлэлд өртөх нь хүний сэтгэцийн эрүүл мэндэд насан туршид нь нөлөөлдөг. Өсвөр насандаа үе тэнгийнхний хүчирхийлэлд өртсөнөөс болж гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэл гутрал, айдсын эмгэг, сэтгэлзүйн хэвийн үйл ажиллагаа алдагдах олон үр дагавар үүсдэг. Эдгээр асуудал өсвөр насны туршид, цаашилбал, насанд хүрсэн үед ч үргэлжлэх магадлалтай. Өсвөр насандаа үе тэнгийнхэндээ дээрэлхүүлж байсан хүн хожим нь сэтгэл гутралын эмгэгтэй болох илүү өндөр магадлалтай болохыг олон судалгаа батлаад зогсохгүй сургуульд байхдаа дээрэлхүүлж, хүчирхийлэлд өртөж байсан хүмүүс 7-36 жилийн дараа сэтгэл гутралд орох магадлал бусдаас 30-50 хувиар илүү байдгийг мета түвшний шинжилгээгээр тогтоожээ (22).

Хүчирхийлэлд дахин холбогдох эрсдэл нэмэгдэх. Бага, өсвөр насандаа хүчирхийлэлтэй тулгарч байсан хүүхэд өсөж том болохын хэрээр хүчирхийллийн өөр хэлбэр болох залуучуудын дундах хүчирхийлэл, хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн харилцагчийн хүчирхийлэл зэрэгт холбогдох магадлалтай байдаг. Бага байхдаа хүчирхийлэлд өртсөн юмуу үйлдсэн бол насанд хүрсэн амьдралынхаа туршид хүчирхийлэл үйлдэх магадлал нь 3 дахин их (23) байдаг бөгөөд эцэг эх нь хүчирхийлэл үйлдэж байгааг харсан хүүхдийн өсвөр болон идэр насандаа өөрөө хүчирхийлэл үйлдэх магадлал нь бусдаас илүү байдаг байна. Англи Улсад хийсэн нэгэн судалгаагаар, ноцтой хүчирхийлэлд холбогдоод байгаа эрэгтэйчүүдийн тал нь өмнө нь өөрсдөө хүчирхийллийн хохирогч болж байсан бол 12 хувь нь л хүчирхийлэлтэй тулгарч байгаагүй залуус байжээ (25). Үе тэнгийнхнээ дээрэлхэх зан үйл нь хожим хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг 50 хувиар нэмэгдүүлдэг бол хохирогч болох нь өөрөө хүчирхийлэгч болох эрсдэлийг 10 хувиар өсгөдөг байна.

Гэр бүл, найз нөхдөд үзүүлэх нөлөө. Залуучуудын дундах хүчирхийлэл, түүний үр дагавар нь хохирогчийн амьдралыг өөрчлөөд зогсохгүй түүний гэр бүл, найз нөхдөд нөлөөлдөг. Хүчирхийллийн хохирогч болсон залуу хүний хамаатан садан, ойрын найзуудад сэтгэл гутралын шинж тэмдгүүд илрэхээс гадна дүрэм журам зөрчих, биеийн хүчээр түрэмгийлэх, нийтийн болон бусдын эд хөрөнгийг сүйтгэн танхайрах зэргээр нийгмийн хэв журмын эсрэг зан үйл гаргах, мансууруулах бодис, архи хэрэглэх нь нэмэгдэх зэрэг эрсдэл өндөр байдаг байна.

Нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй үр дагаврууд

Сурлагаар хоцрох. Залуу хүн хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх нь сурлагаар хоцрох явдалтай холбоотой байна. Хүчирхийлэлд оролцдог залуучууд хичээл сурлагаар тааруу, хичээлээ таслах, сургууль завсардах өндөр эрсдэлтэй байдаг. АНУ-д хийсэн судалгаагаар сурагчдын 6 хувь нь сургууль дээрээ, мөн сургуульд хүрэх, буцах замдаа аюулд өртөхөөс айж судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд нэг ба түүнээс олон хоногоор хичээлдээ яваагүй гэж мэдээлжээ (27). Дунд ангийн хүүхэд түрэмгий зан гаргах нь сургууль завсардахын урьтач шинж тэмдэг болдог байна (28).

Эдийн засгийн зардал. Залуучуудын дундах хүчирхийллийг эд зүйлс, дэд бүтцийг эвдэн сүйтгэх явдал дагалдах нь их байдаг бөгөөд хүчирхийллийн “халуун цэг” буюу хүчирхийлэл их гардаг газар (4) үл хөдлөх хөрөнгийн үнэ ханш буурах хамаарал байдаг. Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн хүчирхийлэл нийгэмд онцгой өндөр үнэтэй тусдаг. Хохирогчтой холбоотойгоор эмнэлгийн үйлчилгээний шууд зардал, ирээдүйн орлогын алдагдал, олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв, эд хөрөнгийн хохирол, амьдралын чанарын алдагдал зэрэг зардал гардаг. Хүчирхийлэл үйлдэгчтэй холбоотойгоор тэнсэн харгалзах, баривчлан түр хорих зардал, засан хүмүүжүүлэх хөтөлбөрийн зардал, шоронд хорих зардал, боломжит орлогын алдагдал зэрэг зардал гардаг. Залуучуудын дундах хүчирхийлэл ихтэй орон нутагт бизнес, эдийн засгийн сөрөг нөлөөлөл мэдрэгдэж, засаг захиргааны уг нэгжийн эрүүл мэнд, шүүхийн зардал нэмэгддэг. Үүнээс гадна, нийгэмд аюулгүй байдлын баталгаа алдагдах, айдас, зовлон нэмэгдэх, нийгмийн эв нэгдэл алдагдах зэрэг мөнгөн бус ачаалал учирна. АНУ-д залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотойгоор алдагдсан орлого, эмнэлгийн шууд зардал нь жил бүр 20 тэрбум доллараар хэмжигддэг байна (10).



2

Залуучуудын дундах
хүчирхийлэлтэй холбоотой
эрсдэлт хүчин зүйлс

Зарим залуус хүчирхийлэлд холбогдохгүй байхад зарим нь яагаад холбогдчихдог вэ? Яагаад зарим хүүхэд сургууль дээрээ бусадтай эв түнжинтэй байж чадаж байхад зарим нь байнга асуудалд орооцолдож байдаг юм бол? Яагаад нэг орон нутагт залуучуудын хүчирхийллийн хувь хэмжээ хажуугийн хороо, орон нутгийнхаас өөр байна вэ? Эдгээр асуултад хариулахын тулд залуучуудын дундах хүчирхийлэлд хүргэдэг шалтгаан буюу эрсдэлт хүчин зүйлс, мөн түүнээс хамгаалж чадах хүчин зүйлсийг тодорхойлох шаардлагатай. Эдгээр шалтгаан, эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг сайтар ойлгож таних нь хүчирхийллийг гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх зорилготой хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөн боловсруулахад тун хэрэгтэй. Урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа нь залуучуудын амьдралд тохиолдох эрсдэлт хүчин зүйлсийг арилгах эсвэл бууруулах, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх үр нөлөөтэй байх ёстой.

Эрсдэлт болон хамгаалах хүчин зүйл гэж залуучуудын хүчирхийлэл гарах магадлалыг ихэсгэх юмуу багасгах нөлөө бүхий хувь хүн, бүлэг, эсвэл орчин хүрээллийн тодорхой шинж, байдлыг хэлнэ. Эрсдэлт хүчин зүйл гэдэг нь хэн нэгний хүчирхийлэл үйлдэх юмуу түүнд өртөх магадлалыг нэмэгдүүлэх нөлөөтэй, эсвэл орон нутгийг хүчирхийллийн өндөр гаралттай орчин болгох нөлөө бүхий шинж чанар юм. Хэн нэгэн хүн, эсвэл тодорхой орон нутагт эрсдэлт хүчин зүйлс төвлөрч, тоо нь нэмэгдэхийн хэрээр тухайн хүн хүчирхийлэлд оролцох, эсвэл тухайн орон нутагт хүчирхийлэл гарах магадлал нэмэгдэнэ (29). Эрсдэлт хүчин зүйлс нь хувь хүний түвшинд, гэр бүл болон үе тэнгийнхний харилцааны түвшинд, орон нутаг, нийгмийн түвшинд илэрдэг. Нялх нярай үе, бага насандаа эрсдэлт хүчин зүйлстэй учирснаар өсвөр насанд, бүр насанд хүрсэн хойно хүчирхийлэлд холбогдох магадлал мэдэгдэхүйц нэмэгддэг нь анхаарах ёстой чухал асуудал юм.

Хамгаалах хүчин зүйлс

Залуучуудын хүчирхийллийн асуудлаар ажилладаг судлаач, асуудал хариуцсан албан тушаалтнууд хамгаалах хүчин зүйлсэд, үүний дотор эрсдэлээс шууд хамгаалдаг болон түүнээс тусгаарлаж өгдөг “жийрэг” хүчин зүйлсэд улам их анхаарах болжээ. Шууд хамгаалах хүчин зүйлс нь хүчирхийлэл гарах магадлал бага байгааг заадаг бол “жийрэг” хүчин зүйлс нь эрсдэлтэй үед хүчирхийлэл бага гарах магадлалыг заадаг байна. Өндөр эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдийн талаас илүү хувь нь ноцтой хүчирхийлэлд холбогддоггүй тул хамгаалагч хүчин зүйлсэд анхаарах нь чухал юм. Эрсдэлт хүчин зүйлсийн нэгэн адилаар хувь хүний, гэр бүл болон ойрын хүрээллийн, орон нутгийн, нийгмийн гэсэн түвшний хамгаалагч хүчин зүйлс байдаг бөгөөд хувь хүн, орон нутгийн түвшинд хамгаалагч хүчин зүйлс олноор төвлөрөхийн хэрээр залуучуудын дундах хүчирхийлэл гарах магадлал бага болдог байна (30).

Өнөөдрийн байдлаар дараах шууд болон “жийрэг” хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлоод байгаа ба үүнд дунджаас дээш түвшний оюуны чадамжтай, цочмог зан үйл гаргах нь бага, нийгмийн дэг журамд захирагддаг, эцэг эхтэйгээ дотно харилцаатай, эцэг эх нь хараа хяналт тогтмол тавьдаг, гэр бүлийнх нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал дундаж түвшинд, сургуульдаа дуртай, хэв журам зөрчдөг найз нөхөдгүй, мөн ядуурал багатай, хүчирхийлэлгүй орон нутагт амьдардаг (30) зэрэг багтаж байна.

Хүснэгт 3-т залуучуудын дундах хүчирхийлэлтэй хамгийн тууштай холбоо хамаарал бүхий эрсдэлт хүчин зүйлсийг хүний насны бүлэг, хүрээллийн түвшнээр тоймлон харуулав. Эрсдэлт хүчин зүйлсийн ихэнх нь Хойд Америк, Европын улс оронд хийсэн судалгаануудын үр дүн юм (31, 32). Эрсдэлт хүчин зүйлсээс олон нь улс орнуудад нийтлэгээр хамааралтай түгээмэл зүйл байж болох ч соёлын онцлогийг агуулсан эрсдэлт ба хамгаалагч хүчин зүйлс бас байдгийг мартаж болохгүй.

Хүснэгт 3-т багтсан эрсдэлт хүчин зүйлсийн зарим нь залуучуудын дундах хүчирхийлэлтэй хүчтэй, илүү тууштай холбоо хамааралтай байхад зарим нь хүчирхийллийг тууштай “таамаглаж” чадахгүй боловч зарим нөхцөлд ач холбогдолтой байх нь дамжиггүй.

Залуучуудын хүчирхийлэлд хамгийн их хамааралтай эрсдэлт хүчин зүйлс

Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан байдал

Гэмт хэрэг, зөрчилд холбогдох нь хожим хүчирхийлэл үйлдэх явдалтай хамгийн тууштай бөгөөд хамгийн хүчтэй холбоо хамааралтай эрсдэлт хүчин зүйлийн нэг юм. Урт хугацааны өгөгдөлд хийсэн нэгэн мета түвшний шинжилгээгээр (33) насанд хүрээгүй байхдаа хүчирхийллийн бус шижтэй ч байж болох ямар нэг зөрчил үйлдэх нь хожим илүү ноцтой зөрчил, хүчирхийлэл үйлдэх эрсдэл байгааг харуулсан хүчтэй дохио буюу хүчин зүйл болох нь тогтоогджээ.

Нийгмийн эсрэг зан үйлтэй найз нөхөд ба нийгмийн сул холбоо харилцаа

Нийгмийн холбоо харилцаа сул байх, нийгмийн талаар сөрөг хандлагатай хүүхдүүдтэй нийлэх нь залуучуудын дундах хүчирхийлэлтэй тун хүчтэй хамааралтай хоёр хүчин зүйл юм (33). Түрэмгий, хүчирхийллийн шинжтэй, эсвэл нийгмийн хэм хэмжээний эсрэг зан хандлагатай хүүхэдтэй найзлах нь хүчирхийлэлд оролцох эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Нийгмийн талаар сөрөг хандлагатай хүүхдүүдтэй найзлах нь хүчирхийлэлт гэмт хэрэгт холбогдох, үе тэнгийнхнээ дээрэлхэх, түрэмгий зан үйл гаргах нөхцөл болдгийг судалгаагаар тогтоожээ (34). Гэмт бүлэглэлд элсэн орсноор хүчирхийлэлт хэрэг зөрчилд холбогдох магадлал 10-21 хувиар өсдөг байна (35, 36). Залуу хүмүүсийн хувьд нийгмийн хэв журмын эсрэг зан үйл, хүчирхийлэл хоёр нь хэрхэн холбогдож, аль нь алиныхаа шалтгаан, үр дагавар болж байгааг одоогоор тогтоож чадаагүй байгаа ба зарим судалгаа (37) нийгмийн талаарх сөрөг хандлагатай найз нөхөд нь нийгмийн хэв журмын эсрэг зан үйлийг өдөөж идэвхжүүлдэг байх магадлалтай гэж үзсэн байхад өөр судалгаанууд (38) хүчирхийлэл, түрэмгийн зан үйл гаргах хандлагатай болчихсон хүүхдүүд нийгмийн талаар сөрөг хандлагатай хүүхдүүдийг найзаараа сонгодог гэж үзжээ.

ХҮСНЭГТ 3.

Залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсийг хүний хөгжлийн үе шат, орчин хүрээллийн түвшингээр тоймлох нь

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ						
Орчин хүрээллийн түвшин	УРАГ БА НЯРАЙН ҮЕ 0 – 1 НАС	Нялх ба бага нас 1 – 3 НАС	ХҮҮХЭД НАС 4 – 11 НАС	ӨСВӨР НАСНЫ ЭХЭН ҮЕ 12 – 14 НАС	ӨСВӨР НАСНЫ ХОЖУУ ҮЕ 15 – 18 НАС	НАСАНД ХҮРСЭН ЭХЭН ҮЕ 18 – 29 НАС
Хувь хүний эрсдэлт хүчин зүйлс	Анхаарал төвлөрлийн дутмагшил, хэт хөдөлгөөншлийн эмгэг, зан төлөвийн өөрчлөлт зэрэг зан үйлийн эмгэг					
	Эрэгтэй					
	Удамшлын хүчин зүйлүүд					
	Оюуны чадамж доогуур					
				Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан		
		Сурлагаар хоцрох				
	Эцэг эх нь мансууруулах бодис хэрэглэх			Мансууруулах бодис хэрэглэх		
				Архины зохисгүй хэрэглээ		
	Хүүхэдтэй зүй бус харьцах					
					Ажилгүйдэл	
Гэр бүл, ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлс	Эцэг эхийн хараа хяналт сул					
	Эцэг эх хатуу ширүүн, эсвэл тууштай бус хүмүүжлийн арга барилтай					
	Гэр бүл салалт					
	Өсвөр насны жирэмслэлт					
	Эцэг эхийн стресс, хямрал					
	Гэр бүлийн хэн нэг нь нийгмийн хэв журмын эсрэг зан үйлтэй					
	Гэр бүлийнхний ажилгүйдэл					
	Жирэмсэн үеийн архины зохисгүй хэрэглээ					
				Нийгмийн талаар сөрөг хандлагатай найз нөхөд		
				Гэмт бүлэглэлийн гишүүн байх		
			Үе тэнгийнхнийгээ дээрэлхэх, дээрэлхүүлэх			
Орон нутаг, нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлс	Согтууруулах ундааны олдоц					
	Хууль бус мансууруулах бодисын зах зээл					
			Хар тамхины хэрэглээ			
	Галт зэвсгийн олдоц					
	Ядуурал					
	Тэгш бус байдал					

Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ

Хувь хүний түвшинд авч үзэх юм бол согтууруулах ундааны хэрэглээ нь танин мэдэхүйн чадвар, бие махбодын үйл ажиллагаанд шууд нөлөөлж, өөрийгөө хянах, мэдээллийг боловсруулах, эрсдэлийг үнэлэх чадварыг бууруулдаг. Энэ нь хүний цочмог занг улам өдөөн даамжруулдаг тул зарим хүнийг хүчирхийлэл үйлдэхэд түлхэх магадлалтай. Архи, согтууруулах ундаа эрт ууж эхэлсэн, тогтмол хэрэглэдэг залуучуудын хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх эрсдэл нэмэгддэг. Орон нутаг, нийгмийн түвшинд хүн олноор цуглардаг, хяналт зохион байгуулалт муутай баар цэнгээний газрууд нь хүчирхийлэл гарах нөхцөл болдог байна (39). Согтож хөлчүүрхсэн үедээ хүмүүс зөрчил, хүчирхийлэл, түрэмгийлэл үйлдэх нь нэмэгддэг болохыг хэд хэдэн судалгаа нотлоод байна (40, 41).

14-16 насандаа мансууруулах бодисын наймаанд оролцож байсан явдал нь залуучуудын хүчирхийлэлд холбогдох эрсдэлийг гурав дахин нэмэгдүүлж болохыг нэгэн судалгаа тогтоожээ (42). Мансууруулах бодис олдоцтой байх нь нэг талаас тухайн орон нутагт гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөл байдал бүрэлдсэний тусгал, нөгөө талаас ийм нөхцөл байдлыг улам дэвэргэх хүчин зүйл болдог байна. АНУ-д хийсэн урт хугацааны судалгаагаар хүчирхийлэл үйлдэх нь согтууруулах ундаа, олсны ургамал, бусад хууль бус бодисыг тогтмол хэрэглэхтэй өндөр хамааралтай болохыг тогтоожээ (43).

Хүйс

Залуу эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад хүчирхийлэл үйлдэх, өртөх хамаагүй өндөр эрсдэлтэй. Хүний амь насыг хохироосон хүчирхийллийн 90 шахам хувийг эрэгтэй хүмүүс үйлдсэн байдаг бол залуу хүний үйлдсэн хүн амины хэргийн хохирогчдын 83 хувийг эрэгтэйчүүд эзэлдэг. Хүний аминд хүрээгүй хүчирхийлэлд залуу эмэгтэйчүүдийн оролцсон байдал олон улсад огт судлагдаагүй байна. АНУ-д ноцтой гэмт хэргийн улмаас баривчлагдаж байсан 10-29 насны хүмүүсийн 20 хувь нь эмэгтэй байжээ (44). Түүнчлэн, залуу эмэгтэйчүүдийн хувьд болзох харилцаатай хүн болон бэлгийн хамтрагчийн үйлдэх хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг.

Өрхийн нийгэм, эдийн засгийн байдал

Ядуу тарчиг амьдрал нь хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг нь тогтоогдоод байгаа ба өрхийн болон орон нутгийн түвшний ядуурал нь хүчирхийлэл гарах нөхцөл болдог байна (45). Дунд ба өндөр орлоготой өрхийн залуучуудтай харьцуулахад нийгэм, эдийн засгийн боломж муутай өрхийн өсвөр насны хүүхэд, залуусын хүчирхийлэлд оролцох эрсдэл нь хоёр дахин өндөр гарчээ (46). Эцэг эхийн нэг нь, эсвэл хоёулаа ажилгүй гэр бүлд өсөж байгаа өсвөр насныхны хүчирхийлэлд холбогдох эрсдэл нэмэгддэг ажээ (47). Эцэг, эхийн нийгэм, эдийн засгийн боломж нь үе тэнгийнхнээ дарамтлан дээрэлхэх, эсвэл өөрөө дарамтлуулж дээрэлхүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог байна (48). Ядуурал, эдийн засгийн тэгш бус байдал нь үндэсний хэмжээний хүн амины хэргийн хувь хэмжээтэй шууд хамааралтай байгаа ба 20-24 насны эрэгтэйчүүдийн хувьд энэхүү хамаарал онцгой хүчтэй байгааг зарим судалгаа нотолжээ (49).

Эцэг, эх нь нийгмийн эсрэг зан үйл, гэмт хэрэгт холбогдож байсан байдал

Нийгмийн хэв журмын эсрэг зан үйл нь гэр бүлийн хүрээнд төвлөрөх хандлага ажиглагддаг. Нийгмийн хэв журмын эсрэг зан үйл гаргадаг эцэг эхтэй хүүхэд мөн ижил зүйл хийх өндөр магадлалтай. Швед залуучуудын дунд хийсэн нэгэн судалгаа нь хүчирхийлэлт гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн хүмүүсийн гэр бүлийн харилцааг авч үзсэн (50) ба хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа хүүхдийн төрсөн ах, эгч, дүү нь хүчирхийлэл үйлдэх эрсдэл дөрөв дахин их, харин үеэлийнх нь эрсдэл хоёр дахин их байгааг тогтоожээ. Бусад бүс нутагт мөн төстэй үр дүн гарсан байна. Жишээлбэл, Их Британийн Кембрижийн Их сургуулийн судалгаагаар (51) аав нь ял эдэлж байгаа хөвгүүдийн 63 хувь нь гэмт хэрэг (үүний дотор хүчирхийлэлт гэмт хэрэг)-т холбогдсон байхад хамаатан садан нь ял эдэлж байгаагүй хөвгүүдийн 30 хувь гэмт хэрэгт холбогдсон байжээ.

Түрэмгий зан авир, хүчирхийлэлд холбогдож байсан байдал

Түрэмгий авир, хүчирхийлэлт зан үйл ихэрт буюу бага насанд хэвших хандлагатай байдаг бөгөөд хүчирхийлэлд холбогдсон өсвөр насны олон хүүхэд багадаа дуулгаваргүй, элдэв хэрэг зөрчилд орооцолддог байсан байдаг (52). Бага байхдаа түрэмгий зан гаргаж, дураар авирладаг байсан, мөн зан байдлын өөрчлөлттэй болох нь тогтоогдсон хүүхдүүд хүчирхийлэлд холбогдох эрсдэл өндөртэй байдаг. Эрэгтэй хүүхдийн хувьд 13 наснаас өмнө илэрсэн түрэмгий зан үйл нь хожим хүчирхийлэлд холбогдохын “дохио” болдог байна. Нийгмийн хэв журмын эсрэг зан үйл нь бага насандаа түрэмгий зан авир хэлбэрээр анх илэрч, хүний амьдралын дараа дараагийн үе шатанд хүчирхийлэлт гэмт хэрэг болж үргэлжлэх магадлалтай гэж олон судлаач үзэж байна (53). Нэгэн судалгаагаар 8-10 насандаа түрэмгий зан авир гаргаж байсан эрэгтэйчүүдийн 20 хувь нь 32 нас хүрэхээсээ өмнө хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдсэн байсан бол ийм зан гаргаж байгаагүй хүмүүсийн 10 хувь нь хүч хэрэглэсэн гэмт хэрэг холбогдсон байна (54). Өөр нэгэн судалгаагаар сургууль дээрээ үе тэнгийнхнээ дээрэлхдэг байсан хүүхэд 11 жилийн дараа хүчирхийлэлт гэмт хэрэгт холбогдох магадлал бусдаас хоёр дахин илүү байгааг тогтоожээ (22).

Хүүхэдтэй зүй бус харьцах нь

Хүүхэдтэй зүй бус харьцах гэдэгт хүүхдийг үл хайхрах, тэдэнд бие махбод, бэлгийн, сэтгэл санааны дарамт үзүүлэх зэрэг үйлдэл багтдаг. Зүй бус харьцааны хохирогч болж байсан хүүхэд бусад хүүхэдтэй харьцуулахад бага болон өсвөр насандаа нийгмийн эсрэг зан үйл, түрэмгийн зан авир гаргах илүү өндөр магадлалтай байдаг байна (55, 56). Бие махбодын хүчирхийлэл, үл хайхралтад өртөж байсан хүүхэд өсөж том болохын хэрээр бусдаас илүүтэйгээр хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэх магадлалтай болохыг харуулсан баримт мэдээлэл бүрдээд байна (57). 900 хүүхдийг хамруулсан судалгааны дүгнэлтээр (58) 11 нас хүрэхээсээ өмнө хүчирхийлэл, үл хайхралтад өртөж байсан хүүхдүүд өсвөр нас, насанд хүрсэн хойноо хэрэг зөрчил үйлдэн баривчлагдах, өсвөр насандаа бол хүчирхийлэлд холбогдон баривчлагдах нь их байжээ.

Хүүхэд хүмүүжүүлэх ур чадвар ба эцэг эх, хүүхдийн харилцаа: хараа хяналт, хүмүүжлийн арга барил, дотно харилцаа

Эцэг эх, хүүхдийн харилцааны зарим тал нь хүүхэд хожим хэрэг зөрчилд холбогдох эсэхийн “дохио” болдог байна. Тухайлбал, хүүхдэд тавих хараа хяналт, сахилга батын шаардлага, тэдгээрийн хэрэгжүүлэлт; сэтгэлзүйн холбоо харилцааны чанар; хүүхдийн амьдралд оролцох оролцоо зэрэг нь үүнд багтаж байна. Хүүхэд нь хаана байгааг мэддэггүй, хараа хяналтгүй орхидог эцэг эхтэй хүүхэд хэрэг зөрчил, хүчирхийлэлд холбогдох илүү өндөр магадлалтай байгааг олон судалгаа анхааруулж байна (30). АНУ-ын Кембриж, Сомервиллийн их сургуулийн хамтарсан судалгаагаар (59) эцэг эхийн хараа хяналт дутах нь 45 хүртэлх насандаа хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэх явдалтай холбоотой байгаа нь харагджээ. Мөн эцэг эх нь хэт хатуу сахилга батын шаардлага тавьж, шийтгэдэг байсан бол хожим өсвөр нас, насанд хүрсэн хойноо хүчирхийлэл үйлдэх магадлал нэмэгддэг байна (60).

Сургуульд хандах хандлага/сурлага

Сурлагаар хоцрох, сургуульдаа дургүй байх, олон сургууль солих, хичээл таслах, сургууль завсардах зэрэг нь бүгд залуу хүмүүсийг хүчирхийлэлд түлхдэг эрсдэлт хүчин зүйлс юм. Сурлагаар хоцрох нь хэрэг зөрчил үйлдэхтэй тууштай холбоотой урьдач “дохио” болж байдаг. Сургуульдаа дуртай байгаа нь хүчирхийлэл үйлдэхээс сэргийлж хамгаалах хүчин зүйл болдог ч гэлээ ерөнхийдөө сул нөлөөтэй хүчин зүйл юм. Хичээл байнга тасалдаг, сургуулиа төгсөлгүй хаяж гарсан хүүхдүүд өсвөр насандаа, мөн насанд хүрсэн хойноо хүчирхийлэлд холбогдох илүү магадлалтай ажээ (42).

Сэтгэл зүйн төлөв байдал

Цочмог зан байдалтай холбоотой хэт хөдөлгөөнтэй, анхаарал төвлөрөл сул, тогтож суухгүй байнга хөдөлгөөнтэй байдаг, эрсдэлт зүйл их хийдэг, өөрийгөө хянах чадвар сул, шинэ шинэ мэдрэмж хайх зэрэг сэтгэл зүйн төлөв байдал нь хүчирхийлэлд холбогдохын урьтал дохио болж болно. Хэт хөдөлгөөншил, анхаарал төвлөрлийн эмгэгтэй хүүхэд түрэмгий зан авир гаргах, өсвөр насандаа хүчирхийлэл үйлдэх илүү өндөр магадлалтай (61). Хувь хүний зан характер, зан үйлийн эдгээр онцлог нь төв мэдрэлийн тогтолцооны тодорхой төлөв байдал, удамшлын зарим хүчин зүйлтэй холбоотой болох нь тогтоогдоод байгаа бөгөөд энэ бүхэн нь бага насандаа туулсан амьдралын таагүй туршлага, нөхцөлтэй нийлэхээрээ хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна (62).

Залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой бусад эрсдэлт хүчин зүйлс

Залуучуудын дундах хүчирхийлэлд хүчтэй нөлөөлдөг дээрх эрсдэлт хүчин зүйлсийн зэрэгцээ өөр хэдэн асуудалд анхаарах хэрэгтэй. Одоо танилцуулах эрсдэлт хүчин зүйлс нь залуучуудын дундах хүчирхийлэлтэй сул холбоо хамааралтай харагдаж байгаа ч энэ нь судалгаа хомс, мөн хийгдсэн судалгаануудын дүгнэлт хоорондоо зөрчилдөж байгаагаар тодорхой хэмжээнд тайлбарлагдана.

Хувь хүний түвшний эрсдэлт хүчин зүйлс

Оюуны ухааны чадамж сул. Оюуны чадамж сул байх нь хэрэг зөрчил гаргах, хүчирхийлэл үйлдэх магадлалтай дунд зэргийн холбоо хамааралтай гэж хэд хэдэн судалгаа дүгнэжээ (63, 64).

Шведийн Стокгольм хотын 120 эрэгтэйг хамруулсан урт хугацааны судалгаагаар хүний нийгэм, эдийн засгийн боломж, байдлаас үл хамааран 3 насанд нь илэрсэн оюуны сул чадамж нь 30 нас хүртлээ гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй холбоо хамааралтай байгааг тогтоожээ (65). Өөр нэг судалгаа нь оюуны сул чадамж, хүчирхийллийн холбоо хамаарлыг тайлбарласан олон тайлбар, үндэслэлийг нарийвчлан шинжилсэн ба үнэнд хамгийн ойр байх магадлалтай нь сурлагын амжилттай холбоотой тайлбар гэж дүгнэжээ. Энэ таамаглалаар оюуны чадвар сул байх нь хүүхдийн сурлагын амжилт гаргах, бусадтай эн тэнцүү өрсөлдөх боломжийг бууруулж, улмаар хэрэг, зөрчлийн ертөнцтэй холбогдох эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг байна (66).

Гэр бүл, ойрын хүрээллийн түвшний эрсдэлт хүчин зүйлс

Өсвөр насны эцэг эх. Эцэг эхийгээ насанд хүрээгүй байхад төрсөн хүүхэд нийгмийн эсрэг зан үйлтэй болох, зан төлөвийн асуудалтай болох магадлал өндөр байдаг ажээ (31). Өсвөр насандаа жирэмсэлсэн залуу эмэгтэйчүүдийн дотор амьдралынхаа аль нэг үед бэлгийн юмуу бие махбодын хүчирхийлэлд өртөж байсан хүмүүс нэлээд байдаг (67).

Эцэг эхийн сэтгэцийн эрүүл мэнд, архины зохисгүй хэрэглээний асуудлууд. Эцэг эхийн сэтгэл гутрал нь хүүхэд нийгмийн эсрэг зан үйл гаргах магадлалыг нэмэгдүүлдэг байна. Энэ хамаарал нь ялангуяа ээжүүдийн дунд нэлээд судлагдсан ба хямрал, гутралтай аавуудын талаар хийсэн хэдэн судалгаа ч ижил дүгнэлтэд хүрсэн байна (68). Эцэг эхийн сэтгэл гутралыг үр дүнтэй эмчилж чадах юм бол хүүхэд нийгмийн эсрэг зан үйл гаргах нь буурах эсэхийг тогтоох судалгаа шаардлагатай байна. Архи зохисгүй хэрэглэдэг эцэг эхтэй хүүхэд нийгмийн эсрэг зан үйл гаргах өндөр эрсдэл байдгийг урт хугацааны судалгаанууд мөн тогтоожээ (69-70).

Орон нутгийн түвшний эрсдэлт хүчин зүйлс

Гэмт хэргийн гаралт ихтэй орон нутагт өсөх. Залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой өөр нэг эрсдэлт хүчин зүйл бол гэмт хэргийн гаралт ихтэй орон нутагт өсөх явдал гэж олон судалгаанд дурджээ (52). Гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа, гэмт бүлэглэл зэргийг харж, мэдэж өсөх, ядуу хорооллын орчин зэрэг нь хүчирхийлэлд хөтлөх нөхцөл болдог байна (1). Насанд хүрсэн олон гэмт хэрэгтэн таньдаг хүүхэд ийм танилгүй хүүхэдтэй харьцуулахад 18 нас хүрэхээсээ өмнө гэмт хэрэгт холбогдох илүү магадлалтай гэж нэгэн судалгаа дүгнэжээ (42).

Нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлс

Галт зэвсгийн олдоц. Голдуу өндөр хөгжилтэй улс орнуудыг хамруулсан салбар дамнасан олон улсын хэд хэдэн судалгаагаар галт зэвсэг олж авах боломж хялбар байх тусам галт зэвсгээс үүдсэн нас баралтын үзүүлэлт өндөр байгааг тогтоожээ (71-72). Түүнчлэн, гэртээ галт зэвсэг хадгалдаг өрхүүдэд галт зэвсэгтэй холбоотой нас баралт бусад өрхөөс илүү олон гарч байгааг мета түвшний шинжилгээний дүн нотолж байна

(73). Эдгээр судалгаа нь залуучуудын дундах хүн амины хэргийг тусгайлан судлаагүй ч хүн амины хэрэгт холбогдогсдын дунд залуучуудын эзлэх хувь өндөр байдаг тул эдгээр дүгнэлт нь залуучуудын дундах хүчирхийллийн асуудалд шууд хамааралтай гэж үзэж болно.

Нийгмийн хамгаалал. Нийгмийн хамгааллын механизмууд нь үндэсний хэмжээний хүн амины хэргийн гаралттай урвуу харьцаатай байна. Тиймээс нийгмийн хамгааллыг сайжруулах зорилготой эдийн засгийн бодлого, хөтөлбөр нь ядуурлын нийгэм, эдийн засгийн үр дагаврыг зөөлрүүлэх нөлөө үзүүлэхийн зэрэгцээ хүчирхийллийн эсрэг хамгаалагч хүчин зүйл болох боломжтой гэж үзэж болохоор байна (49, 74).

Нийгмийн шинжтэй тодорхойлогч хүчин зүйлс, үүн дунд хуульт ёс

Бүхий л төрлийн хүчирхийлэл нь нийгмийн тодорхой хүчин зүйлстэй шууд холбоо хамааралтай бөгөөд эдгээрт засаглал, хуульт ёсны сул дорой байдал, соёл, нийгэм ба жендерийн хэвшмэл хэм хэмжээ; ажилгүйдэл, орлогын болон жендерийн тэгш бус байдал, нийгмийн хурдацтай өөрчлөлт, боловсролын хүртээмжгүй байдал зэрэг багтдаг (2). Эдгээр хүчин зүйл нийлээд хүчирхийлэл гарах “таатай” нийгмийн уур амьсгалыг бий болгодог бөгөөд эдгээр хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авахгүй бол хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлд тогтвортой үр дүн гаргаж чадахгүй. Иймд залуучуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой аливаа цогц стратеги нь дээрх эрсдэлүүдийг бууруулах, нөлөөллөөс нь хамгаалах бодлогын болон бусад арга замыг тодорхойлсон байх шаардлагатай. Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, стратеги нь нийгмийн шинжтэй дээрх хүчин зүйлсийг “онилсон” чиглэлээ алдахгүй байхад салбар хоорондын хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд хууль зүй, аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн салбарын холбогдох институцуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэхэд анхаарах шаардлагатай (2).

Хууль ёс хэрэгждэггүй бол (энэ бол залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой нийгмийн хүчин зүйлсээс хамгийн хүчтэй нөлөөтэй нь) хүмүүсийн хооронд гарсан хүчирхийллийг мэдээлэх аюулгүй арга механизм бий болгох, хуулийн хамгаалалт, дэмжлэгийг бүх хүнд хүртээмжтэй болгоход чиглэсэн стратегиуд онцгой чухал болно (75). Хууль ёс сайтай газар эрүүгийн хариуцлага хүлээхээс айх айдас нь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, хүчирхийлэл үйлдэж ял шийтгүүлсэн хүний найз нөхдөд, эсвэл эрүүгийн хариуцлага өндөр биш ч гарцаагүй хүлээх нь тодорхой байгаа үед урьдчилан сэргийлэх нөлөө үүсдэг байна. Улмаар хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажлын нэг чухал зорилт бол нийгмийн эрүүл мэнд, эрүүгийн эрх зүйн салбар, аюулгүй байдлын асуудал хариуцсан цагдаа зэрэг гол институцууд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх замаар болзошгүй гэмт хэргийг үйлдэгдэхээс нь өмнө зогсоох (чадаагүй бол ядаж л хийсэн үйлдэлд нь хариуцлага тооцуулах) явдал юм. Шаардлагатай бол холбогдох байгууллагын санхүү, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй ба энэ нь хуулийн хэрэгжилтийг сайжруулахад оруулж буй хувь нэмэр болно.

Эрсдэлт хүчин зүйлсийн тухай мэдлэгийг хөтөлбөр, арга хэмжээ боловсруулах, төлөвлөхөд ашиглах нь

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд нөөц хөрөнгийн хомсдол тулгарах нь их. Тиймээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хүчирхийлэлд холбогдох хамгийн их эрсдэлтэй хувь хүн, гэр бүл, орон нутагт хандуулах нь чухал байдаг. Дээр дурдсанчлан, хүчирхийлэлд оролцох илүү эрсдэлтэй нийгмийн бүлэг, орон нутаг байдаг ба улмаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг юуны өмнө тэдэнд чилүүлэх ёстой. Мөн хэд хэдэн хүчин зүйл нь хүний амьдралын тодорхой үе шаттай холбоотой учраас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хүүхдийн насны онцлогт нийцүүлэхэд анхаарах шаардлагатай.

Аль эрсдэлт хүчин зүйлсийг эн түрүүн авч үзэхээ шийдэх гэж байгаа бол дараах асуултууд тус болно:

- Тухайн эрсдэлт хүчин зүйл нь хүчирхийллийн тодорхой үр дагавартай хэр хүчтэй холбоо хамааралтай байна вэ?
- Энэ эрсдэлт хүчин зүйлтэй холбоотой өгөгдөл, мэдээллийг хэрхэн цуглуулж болох вэ?
- Энэ эрсдэлт хүчин зүйл ямар давтамжтай илэрдэг вэ?
- Арга хэмжээ авснаар уг эрсдэлд өртөх байдлыг бууруулах хэр боломжтой вэ?
- Уг эрсдэлт хүчин зүйлийг бууруулах/арилгахад хэдий хэмжээний зардал гарах вэ?

Дэлхийн улс орон, бүс нутгуудад залуучуудын дундах хүчирхийлэлд түлхдэг эрсдэлт хүчин зүйлс нь өөр өөр бөгөөд дээр танилцуулсан эрсдэлт хүчин зүйлсийн ихэнх нь өндөр орлоготой улс орнуудад хийгдсэн судалгаагаар илэрсэн зүйлс юм. Гэхдээ эрсдэлт хүчин зүйлсийн дотроос цөөнгүй нь янз бүрийн нөхцөл байдалд нийтлэг илэрч байгааг судалгаанууд харуулсаар байна (76, 77). Үүний зэрэгцээ зөвхөн тодорхой нөхцөл байдлын онцлогтой холбоотой эрсдэлт хүчин зүйлс бас байдаг тул хөтөлбөр боловсруулагчид тэдгээрийг таньж, ялгаж авах нь чухал юм.

Тодорхой улс орон, нөхцөл байдалтай холбоотой эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас олж болно. Жишээлбэл:

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэдтэй зүй бус харьцах асуудлаарх өрхийн судалгаа
- Өрх толгойлсон эцэг/эхийн тухай статистик мэдээлэл
- Архи, согтууруулах ундааны хэрэглээ, худалдаа, эсвэл гэрийн аргаар нэрсэн архины хэрэглээний талаарх статистик мэдээ
- Орон нутгийн эдийн засгийн чадавх, орлогын үзүүлэлтүүд
- Ажилгүйдлийн статистик мэдээ
- Сургуулиас авсан мэдээ (жишээлбэл, сургуульд түшиглэсэн эрүүл мэндийн судалгааны үр дүн)
- Эрсдэлт хүчин зүйлсийн талаарх судалгааны тайлан, материалууд

A photograph of a man in a wheelchair on a wet, rainy street. The man is wearing a dark blue jacket, a black cap, and a white and grey patterned scarf. He is looking back over his shoulder. In the background, there is a dark car, several pedestrians, and trees. The image has a torn paper effect on the right side.

3

**Залуучуудын дундах
хүчирхийллийг урьдчилан
сэргийлэхтэй холбоотой ямар
баримт нотолгоо бүрдээд
байна вэ?**

Номын энэ бүлэгт залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд ашиглаж байгаа 21 стратегийн үр нөлөөний талаар хуримтлагдаад байгаа шинжлэх ухааны мэдлэгийг тоймлон танилцуулж байна. Энэхүү нотолгооны бааз нь өнөөдрийн байдлаар дараах сул талтай байгааг онцолъё:

- Хэдийгээр залуучуудын хүчирхийллийн гол ачаалал нь бага, дунд орлоготой улс оронд байгаа ч урьдчилан сэргийлэлтийн үр нөлөөг зөвхөн орлого өндөртэй Австрали, Канад, АНУ, Баруун Европын зарим оронд судалж баримтжуулсан байна (78).
- Судалгааны баазад багтсан нотолгоонууд нь янз бүрийн түвшний урьдчилан сэргийлэлтийг ижил хэмжээнд хамруулж чадахгүй байгаа. Хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлсэн судалгааны дийлэнх нь хувь хүний болон ойрын хүрээллийн түвшний эрсдэлт хүчин зүйлсэд чиглэсэн стратегиудыг авч үзсэн ба харин орон нутаг болон нийгмийн түвшний урьдчилан сэргийлэлтийн үнэлгээ маш цөөн байна (78).
- Ихэнх хөтөлбөр нь хувь хүний болон ойрын хүрээллийн хүчин зүйлсэд анхаарсан учраас хөтөлбөрийн үр нөлөөг ихэнхдээ залуучуудын зан үйл, хандлагын өөрчлөлтөөр хэмжжээ. Гэтэл орон нутаг болон нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлсийг онилсон стратегиудын үр нөлөөг шууд буюу залуучуудын дундах хүчирхийллийн гаралтад хэрхэн нөлөөлж байгаагаар нь хэмжиж болно. Жишээлбэл, хүн амины хэрэг ба хүний амь насанд хүрээгүй хүчирхийллийн гаралт, яаралтай эмнэлийн тусламж шаардсан хүчирхийллээс үүдэлтэй гэмтэл, хүчирхийлэл үйлдсэн ба өртсөн тухай өөрөө мэдээлсэн тохиолдол зэргийн бууралтаар хэмжиж болно (79).
- Аль болох багаас нь хүүхдийн хандлага, ойлголтыг төлөвшүүлэх зорилготой урьдчилан сэргийлэх стратеги чухал боловч бага насны хүүхдэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ нь өсвөр насанд нь хүчирхийллээс хэрхэн хамгаалж байгааг хэмжсэн урт хугацааны судалгаа цөөн байна.

Стратеги бүрт багтах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн үр нөлөөг үнэлсэн судалгаанаас гарсан нотолгооны ач холбогдлыг дараах байдлаар эрэмбэлэв. Үүнд: мета түвшний анализ ашигласан системтэй тойм бол хамгийн хүчтэй нотолгоо гэж үзсэн ба нэг шат буурахаар мета-анализ ашиглаагүй системтэй тойм судалгааны үр дүн байрлаж байна. Энэ хоёр төрлийн судалгаа байхгүй бол санамсаргүй түүвэрт суурилсан хяналтын бүлэгтэй харьцуулах загвараар хийсэн туршилтын судалгааны дүнг ашиглах ба санамсаргүй түүвэрт туршилтын судалгааны дүн олдохгүй бол хагас туршилт, цаг хугацааны цуврал зэрэг арга зүйд суурилсан нотолгоог ашиглав. Үр нөлөөний тухайд залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсэд хөтөлбөрийн үзүүлсэн үр нөлөөг хэмжсэн, мөн үр нөлөөг шууд хэмжих боломжтой шалгуур үзүүлэлтүүд ашигласан судалгаануудыг авч ашиглав. Бага ба дунд орлоготой улс орнуудад хийсэн судалгаа, мөн франц, испани хэл дээр хэвлэгдсэн тайлан материалыг олж ашиглахад ихэд анхаарч ажиллав.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой 21 стратеги нь дөрвөн чиглэлд төвлөрч байгаа ба эдгээр нь:

- Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратегиуд
- Сургуульд түшиглэсэн сурлагын амжилт, нийгмийн харилцааны чадварыг дэмжих стратегиуд
- Хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй, эсвэл өмнө нь хүчирхийлэлд холбогдож байсан залуучуудад чиглэсэн стратегиуд
- Орон нутаг болон нийгмийн түвшний стратегиуд болно.

Стратеги бүрийн хувьд эхлээд тодорхойлолтыг өгч, араас нь урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлж чадна гэж үзэж байгаагийн үндэслэл; үр нөлөөг нь харуулсан судалгааны дүгнэлтүүд (үүнд үр нөлөөгүй, эсвэл сөрөг нөлөөтэй гэсэн дүгнэлт бас багтана); боломжит өгөөж, сөрөг үр дагавар болон хүлээн зөвшөөрөгдөх магадлал; бага болон дунд орлоготой орнуудад авч ашиглах боломж зэрэг мэдээллийг хүргэж байна. Тодорхой стратегийг танилцуулахдаа эхлээд тухайн стратегийн ямар гол үр дүнгүүд үнэлэгдсэн болох, стратеги нь эдгээр үр дүнгийн хүрээнд ямар үр нөлөө үзүүлсэн, мөн боломжтой тохиолдолд залуучуудыг хүчирхийллээс хамгаалах нөлөө зэрэг мэдээллийг хураангуйлан өгөв. Мөн тухайн стратегитай холбоотой нотолгоо нь өндөр, дунд, бага орлоготой улс орнуудын алинд хамаарах, нотолгооны цаана байгаа судалгаанууд хэр сайн, баталгаатай аргачлалтай болохыг дурдав. Санамсаргүй түүврийг хяналтын бүлэгтэй харьцуулах загвартай хоёр судалгааг ашигласан тохиолдолд бид аргачлал сайтай судалгаагаар дэмжигдсэн стратеги гэж үзэж байгаа бол санамсаргүй түүвэр ашиглаагүй судалгаа, мөн хөтөлбөрийн эхэн ба эцэст асуулга авах загвартай судалгаа байгаа бол сул аргачлалтай судалгаагаар дэмжигдсэн стратеги гэж үзэж байна.

Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратегиуд

Бага насны хүүхдийг дэмжих стратегиуд нь 0-8 насны хүүхдэд чиглэх ба хоорондоо уялдаа холбоотой хоёр багц эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилготой. Хувь хүний түвшний эрсдэлт хүчин зүйлсэд анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөншил, зан төлөвийн өөрчлөлт, зан үйлийн бусад асуудлууд багтана. Гэр бүлийн түвшний эрсдэлд эцэг эх, хүүхдийн холбоо сул байх, хүүхэдтэй зүй бус харьцах, эцэг эхийн хараа хяналт сул байх, эцэг хатуу ширүүн юмуу тууштай бус хүмүүжлийн арга хэрэглэх зэрэг багтана. Оюуны болон зан үйлийн бэрхшээлтэй хүүхдэд хяналт тавих нь илүү хүндрэлтэй байдаг бөгөөд эцэг эх нь өөрсдөө асуудалтай, эсвэл туршлагагүй бол хүүхдийн эмгэг, бэрхшээл нь зүй бус харьцаа, хэт хатуу, эсвэл тууштай бус хүмүүжлийн арга барил ашиглах явдлыг улам өдөөж мэднэ.

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн сувилагч, эрүүл мэндийн ажилтан, заримдаа сайн дурынхан 0-2 (заримдаа 4 хүртэлх) насны хүүхэдтэй эмзэг бүлгийн, мөн анх удаа эцэг эх болж байгаа хүмүүсийн гэрээр очиж хүүхэд өсгөх, хүмүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, дэмжлэг үзүүлж ажилладаг. Хөтөлбөрийн зорилго нь хүүхэдтэй зүй бус харьцахаас сэргийлж, хүүхдийн эрүүл хөгжил бойжилтыг дэмжих

явдал юм. Гэрээр очиж үйлчлэх хөтөлбөрүүд нь эх, хүүхдийн хоорондын сэтгэлийн холбоо зэрэг хүүхэд өсгөхтэй холбоотой нийтлэг асуудлуудад төвлөрдөг тул ямар ч орчин нөхцөлд үр нөлөө сайтай байх магадлалтай.

ХУРААНГУЙ

- Гэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээний урт хугацааны нөлөө буюу залуучуудын гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад үзүүлж буй нөлөөг хэмжиж үнэлсэн нь бага байна.
- Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харьцах явдал (залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой нэг эрсдэлт хүчин зүйл)-ыг илэрхий бууруулах нөлөөтэй байгаа ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах магадлалтай.
- Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр нь өсвөр нас, насанд хүрсэн үед нь хүүхдийн хүчирхийллээс хамгаалах нөлөө үзүүлж байгаа эсэхийг харуулах хангалттай хэмжээний нотолгоо алга.
- Хөтөлбөрийн үр нөлөөтэй холбоотой нотолгоо нь зөвхөн өндөр орлоготой улс орнуудад хамаарна.
- Ихэнх судалгаа нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдож байгаа нь

Эцэг эх, хүүхдийн хоорондын холбоо нь хүүхдийн хөгжилд шууд нөлөөлдөг. Нялх, бага насанд учирсан зүй бус харьцаа нь өсвөр болон залуу насандаа хүчирхийлэлд холбогдох эрсдэлийг шууд нэмэгдүүлэхээс гадна архи, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг хүчирхийлэлтэй холбоотой зан үйлд хүргэдэг байна (55, 56). Гэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээ нь хүүхэдтэй зүй бус харьцах, архи, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах нөлөөтэй болох нь батлагдаад байгаа тул залуучуудыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөтэй гэж хэлж болохоор байна.

Нотолгоо

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрүүд нь хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн эсрэг бусад үйлдэл, үр дагаврыг үр дүнтэй урьдчилан сэргийлж чадаж байгааг баталсан өндөр орлоготой улс орнуудад хамаатай хүчтэй нотолгооны бааз бүрдээд байна (80, 81). Гэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээний урт хугацааны үр дүнг үнэлсэн дөрвөн судалгаа (82)-нд орлого багатай орчин нөхцөлд өрх толгойлон амьдарч байгаа эхийн хүүхдүүд гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрт хамрагдаж байсан бол өсвөр насандаа хэрэг, зөрчил, хүчирхийлэлд холбогдох нь буурсан буюу баривчлагдах (-52,8%) ял авах (-63%) магадлал нь мэдэгдэхүйц багассан гэж дүгнэжээ. Сувилагч нар залуу ээжүүдэд гэрээр зөвлөх хөтөлбөрийн урт хугацааны үр нөлөөг хэмжсэн өөр нэг судалгаагаар хөтөлбөрт хамрагдаж байсан хүүхдүүдийн гэмт хэрэгт холбогдсон байдлыг 19 жилийн дараа эргэж судлахад (83) энэ хугацаанд саатуулагдаж, баривчлагдах тохиолдол охидын хувьд багассан ч хөвгүүдийн хувьд өөрчлөгдөөгүй гэсэн үр дүн харагджээ.

Гэрээр үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр нь хүүхдийн эсрэг зүй бус харьцааг сэргийлэхийн зэрэгцээ эх, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн сэтгэл хөдлөлийн болон оюуны хөгжлийг дэмжин сайжруулах нөлөөтэй байгаа нь нотлогдоод байна (84). Бага, дунд орлоготой улс орнуудад хамаарах эерэг үр дүнгийн нотолгоо бүрдэж эхлээд байна. Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр нь хөрөнгө, нөөц хомс нөхцөлд хэрэгжүүлэх боломжтой, эцэг эх, хүүхдийн хоорондын холбоо харилцааны чанарыг сайжруулах нөлөөтэй байна гэсэн эхний нотолгоонууд бий болжээ (85). Гэсэн хэдий ч хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг бууруулахад гэрээр зөвлөх хөтөлбөрүүдийн үзүүлсэн үр нөлөө янз бүр, хэрэгжүүлсэн бүх хөтөлбөр үр дүнтэй байгаагүйг нэмж хэлэх хэрэгтэй.

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрийн хэрэгжилт

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрүүд нь хүүхэдтэй зүй бус харьцах өндөр эрсдэлтэй гэр бүлүүдэд (маш залуу ээжтэй, эсвэл нэн ядуу гэр бүл) чиглэдэг ба бие даасан хөтөлбөр хэлбэрээр, эсвэл эрүүл мэндийн ердийн үйлчилгээний хүрээнд нэг арга хэмжээ хэлбэрээр мэргэжлийн сувилагч, асрагч, эрүүл мэндийн ажилтнууд, бэлтгэгдсэн мэргэжлийн бус хүмүүс хэрэгжүүлдэг. Хүүхэд төрөхөөс өмнө л гэрээр очиж зөвлөх ажил эхлэх ба хүүхдийн хөгжил, асаргаа, хүүхэд хүмүүжүүлэх арга барилын талаар сувилагч зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж ажилладаг. Гэрээр зөвлөгөө өгөх үйлчилгээ нь сард наад зах нь нэг удаа, зарим хөтөлбөрт долоо хоногт хоёр удаа үйлчлүүлэгчийн гэрт очих хуваарьтай байдаг. Нэг хөтөлбөр 6 сараас 3 жилийн хугацаатай.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харьцах явдал багасах, эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжрах, хүүхдийн бага насны өсөлт, хөгжил эрчимжих зэрэг шууд өгөөж нэлээд ихтэйн дээр өсвөр насандаа гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэлд холбогдохоос хамгаалах гэх мэт 10-15 жилийн дараа мэдрэгдэх урт хугацааны үр нөлөөтэй. Улмаар гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр нь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үр нөлөө үзүүлдэг гэсэн үндэслэлийг нөлөөлөл, сурталчилгаандаа ашиглахаар төлөвлөж байгаа бол уг хөтөлбөрийн шууд ба урт хугацааны боломжит үр нөлөөг заавал дурдах хэрэгтэй.

Зардал

Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрийн зардал нь сувилагчийн цалин, сувилагчийн сургалт, хөтөлбөрийн захиргааны зардал, хяналт, орон нутгийн тээврийн зардал зэргээс бүрдэнэ. Эдгээр нь хөтөлбөрийн төрөл, үйлчилгээний давтамжаас хамааран ялгаатай байна. Жишээлбэл, АНУ-д гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөрүүд нэг гэр бүлд нэг жилд 1000- 5000 гаруй ам. доллар зарцуулсан байна. 2005 онд РАНД Корпораци хоёр хөтөлбөрийн зардал, үр ашгийн үнэлгээг хийхэд хөтөлбөрөөс зарцуулсан нэг доллар тутамд 1.80- 5.70 ам. долларын үр ашиг эргэж ирж байгаа тооцоо гарчээ (86).

Гэрээр зөвлөгөө өгөх сувилагчийн хөтөлбөр**АНУ, Их Британи, Нидерланд улсад**

“Сувилагч, гэр бүлийн түншлэл” хөтөлбөр бол анхны хүүхдээ төрүүлсэн, голдуу бага орлоготой болон гэрлээгүй эхчүүдэд жирэмсэн ба нярай үеийн үйлчилгээг сувилагч гэрээр үзүүлэх хөтөлбөр юм. АНУ-аас эхтэй уг хөтөлбөр өдгөө Нидерланд, Их Британи зэрэг өндөр орлоготой орнуудад хэрэгжиж байна.

Хөтөлбөрт өмнө нь төрж байгаагүй, голдуу бага орлоготой, гэрлээгүй, өсвөр насны жирэмсэн эмэгтэйчүүдийг хамруулж, сувилагчийн үйлчилгээг гэрээр үзүүлдэг байна. Сувилагч нь жирэмсний үеэс эхлэн хүүхдийг 2 нас хүртэл сард нэг удаа гэрээр нь очно. Сувилагч эрүүл мэндийн эерэг зан үйл, хүүхэд асрах чадвар, эхчүүдийн хувийн хөгжил (гэр бүл төлөвлөлт, боловсрол сурлагын амжилт, ажил эрхлэлт)-д хувь нэмэр болох зүйлсийг зааж сургадаг байна. Жирэмсний сүүлийн гурван сараас эхлэн хүүхэд 2 нас хүртэл үргэлжлэх хөтөлбөр нь нэг эмэгтэйд 12500 орчим ам. доллар зарцуулдаг.

“Сувилагч, гэр бүлийн түншлэл” хөтөлбөрийг санамсаргүй түүврийн загвартай, өөр өөр орон нутаг, хүн амыг хамруулсан 3 судалгаагаар үнэлжээ. Хүүхэдтэй зүй бус харьцах явдал, гэмтэл 20-50 хувиар буурч, өсвөр ба 20 гаруй насандаа дахин төрөх хувь хэмжээ 10-20 хувиар буурч, боловсрол багатай эсвэл сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай эхчүүдийн хүүхдүүдийн танин мэдэхүй, боловсролын үр дүн сайжирсан (55) эерэг дүн гарчээ.

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь хүүхдийн хөгжлийн талаар эцэг эхийн мэдлэгийг нэмэгдүүлж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэхтэй холбоотой тэдний чадварыг дээшлүүлэх, эцэг эх, хүүхдийн холбоог сайжруулах, хүүхдийн зан үйлийг эерэг, нийгмийн харилцаанд нь тустай байдлаар хянан шийдэх аргуудад эцэг эхийг сургах зорилготой. Хөтөлбөр нь түрэмгий зан ааш, эсэргүүцэл зэрэг хүүхдийн хүмүүжлийн асуудлуудыг багасгах чиглэл (87)-ийн зэрэгцээ эцэг эх, хүүхдийн харилцааны үндсэн асуудлуудад анхаардаг тул эдгээр хөтөлбөр нь ямар ч орчин нөхцөлд нийцтэй, хэрэгжих өндөр боломжтой. Эцэг эхийн боловсролын хөтөлбөрүүд голдуу 0-3 насны хүүхэдтэй эцэг, эхэд чиглэгддэг ба сургуулийн насны, өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан хэд хэдэн хөтөлбөр бий.

ХУРААНГУЙ

- Хүүхдийн сахилга бат, залуучуудын хэрэг, зөрчилд үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь гэмт хэрэг, зөрчилд холбогдох, сахилга батын асуудал гаргах зэрэг залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой хэд хэдэн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулдаг.
- Янз бүрийн орчин нөхцөл, үүн дундаа бага орлоготой зарим оронд хамааралтай нотолгоо бий.
- Ихэнх судалгаа нь аргачлал сайтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харьцах явдал, хүүхдийн хүмүүжлийн зөрчлийг бууруулдаг. Хүүхэдтэй зүй бус харьцах нь өсвөр болон залуу насандаа хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүчирхийлэлтэй холбоотой өндөр эрсдэлтэй зан үйл (архи, мансууруулах бодис хэрэглэх гэм мэт)-тэй болоход нөлөөлдөг (55, 56). Зан үйлийн зөрчил, түрэмгий зан ааш гаргадаг, эсэргүүцэл байнга үзүүлдэг хүүхэд өсвөр болон идэр насандаа хүчирхийлэлд холбогдох илүү өндөр магадлалтай (88).

0-3 насны хүүхэдтэй эцэг, эхийг хамруулдаг боловсролын хөтөлбөр нь хүүхдийн хөгжлийн талаар мэдлэг олгох, ур чадварууд эзэмшихэд нь хүүхдэдээ туслах аргуудад эцэг эхийг сургах зорилготой бол 3-аас дээш болон өсвөр насны хүүхэдтэй эцэг эхэд чиглэсэн хөтөлбөр нь зан үйлээ хянан зохицуулж сурахад нь хүүхдэдээ хэрхэн туслах талаар эцэг эхийн чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

Нотолгоо

0-3 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хандсан хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг бууруулж байгааг харуулсан өндөр орлоготой улс орнуудад хамаарах нотолгоо бүрдээд байна (55). Бага насны хүүхэдтэй эцэг эхэд үзүүлсэн боловсролын үйлчилгээ нь хүүхдийг өсвөр насандаа хэрэг, зөрчилд холбогдох, нийгмийн эсрэг зан үйл гаргах, мөн баривчлагдах, ял авахаас хамгаалах урт хугацааны нөлөө үзүүлж байгаа эсэхийг үнэлсэн судалгаа дутмаг байна (89).

Түүнчлэн, эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь 3-аас дээш насны хүүхдийн зан үйлийн зөрчлийг мэдэгдэхүйц бууруулах нөлөөтэй байгааг эцэг эхийн асуулга, хараат бус судалгааны дүн харуулж байна (90). Залуучуудын зан үйлд эцэг эхийн боловсролын хөтөлбөрүүд хэрхэн нөлөөлснийг үнэлсэн 46 судалгаанд системтэй тойм дүгнэлт хийхэд хөтөлбөрүүд нь хэрэг зөрчил, зан үйлийн доголдол, архи, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж байгаа дүгнэлт гарчээ (91). Мөн өөр нэг системчилсэн тойм судалгаагаар (92) 8-17 насны хүүхэдтэй эцэг эхийг хамруулсан хөтөлбөрүүд нь хэрэг зөрчил, зан үйлийн доголдол, баривчлагдан саатуулагдах тохиолдлын тоо, хорих газарт өнгөрүүлсэн хугацаа зэргийг бууруулсан дүн гарчээ.

Зарим тойм судалгаа нь эцэг эхийн боловсролын хөтөлбөрийн үр дүнд нөлөөлж байгаа шинж чанаруудыг тодорхойлохыг зорьжээ. Эцэг эх, хүүхдийн хоорондын эерэг холбоо, сэтгэл хөдлөлийн эерэг харилцааг дэмжих; асуудал гарсан үед хүүхдээ “завсарлуулах” шийтгэлийн аргыг ашиглах, хүмүүжлийн аргуудаа тууштай ашиглах, мөн шинээр сурсан ур чадвараа сургалтын үеэр хүүхэдтэйгээ шууд хэрэглэхийг шаардах зэрэг нь хөтөлбөрийн амжилтын суурь болж байгааг тогтоожээ (93).

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь хөгжиж буй орнуудад үр дүнтэй хэрэгжих боломжтойг харуулсан туршлага бий болж байна. Хөгжиж буй 9 оронд хийсэн 12 судалгааны тоймд (85) эцэг эхийн боловсролыг дэмжсэн янз бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээг агуулсан стратегиуд үр дүн сайтай байх магадлалтай гэж дүгнэжээ. Уг тоймд багтсан хамгийн том, чанарын өндөр түвшинд хийгдсэн хоёр судалгааны дүнгээр хөгжиж буй орнуудад эцэг эхийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой бөгөөд эдгээр нь эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа, хүүхдийн хөгжлийн талаарх эцэг эхийн мэдлэгийг сайжруулахад өндөр үр нөлөөтэй байх магадлалтай гэжээ.

Эцэг эхийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт

Эцэг эхийн боловсролын хөтөлбөрийг ихэвчлэн нийгмийн ажилтан, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эсвэл бэлтгэгдсэн мэргэжлийн бус хүний удирдлага дор голдуу бүлгээр, эрчимтэй дэмжлэг, туслалцаа шаардлагатай гэр бүлд ганцаарчилсан хэлбэрээр хэрэгжүүлдэг. Эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь богино буюу 3 сар хүртэлх хугацаатай, долоо хоногт нэг удаагийн давтамжтай үйлчилгээ хүргэдэг. Хөтөлбөрүүд дотроо хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг ба бүх эцэг эхийг хамруулсан үйл ажиллагаанаас гадна илүү дэмжлэг шаардах бүлэг эцэг эхийг тусгайлан хамруулсан үйл ажиллагааг багтаана.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр эхэн үедээ эцэг эх, хүүхдийн харилцаа сайжрах, хүүхдийн хөгжилд илүү анхаарах зэрэг хүүхдэд шууд нөлөөлөх эерэг өөрчлөлтүүд харагдах ч энэ дэмжлэг нь өсвөр насны хүүхэд, залуучуудыг хүчирхийллээс хамгаалж чадаж байгаа эсэхийг харахын тулд дахиад 5-10 жил хүлээх хэрэгтэй болно. Тиймээс эцэг эхийн боловсролын хөтөлбөрөөс богино хугацаандаа гарах эхийн эрүүл мэнд, хүүхдийн оюун ухааны хөгжил, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх ур чадварын хөгжил зэрэг эерэг үр дүнг онцолж байх хэрэгтэй. Одоо хэрэгжиж буй эцэг эхийн боловсролын хөтөлбөрүүд залуучуудыг хүчирхийллээс хамгаалах зорилт агуулаагүй ч гэсэн үүнийг хөтөлбөрийнхөө урт хугацааны зорилт болгон нэмж болно.

Зардал

Эцэг эхийн боловсролын хөтөлбөрт сургалтын зардал, ажилтнуудын цалин, удирдлагын болон захиргааны зардал багтана. Хамгийн их нь сургалт, хүний нөөцийг удирдахтай холбоотой зардал байдаг. Тогтмол зардалд сургалтын материал, мэдээллийн хуудас гаргах зардал, мөн эцэг эхийн сургалтын үеэр хоол унд, хүүхэд харахтай холбоотой нэмэлт зардал багтана.

Хөтөлбөрийн жилийн төсөв нь хөтөлбөрийн төрөл, үйлчилгээ хүргэх арга механизм, зорилтот бүлэг нь зөвхөн эрсдэлт бүлгийн эцэг эх үү, орон нутгийн бүх эцэг эх үү гэдгээс хамааран харилцан адилгүй байдаг. АНУ-д хөтөлбөрийн төрөл, үйлчилгээний давтамжаас хамаарч хөтөлбөрүүд нэг жилд нэг гэр бүлд 200-1200 ам. доллар зарцуулжээ (94).

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр: Бурунди, Өмнөд Африкийн туршлага

Бурунди Улсад 12 настай хүүхдийн зан үйл, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах зорилготой эцэг эхийн боловсролын богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлжээ (95). Хөтөлбөр нь тус бүр 20 оролцогчтой, сэтгэлзүй, боловсролын агуулгатай, 2.5-3 цагийн хоёр семинараас бүрдэж байв.

Эхний семинар нь хүүхдийн сэтгэлзүй, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэлтэй болгох, хоёр дахь семинар нь эцэг эхчүүдийн ашигладаг хүмүүжлийн болон асуудал шийдэх аргууд, ялангуяа бие махбодын хатуу шийтгэл ашиглахаас зайлсхийх асуудалд төвлөрчээ. Семинарыг орон нутгийн мэргэжлийн бус хоёр зөвлөх удирдан явуулсан ба тэднийг 3 сарын хугацаанд сургаж бэлтгэсэн байна. Энэ арга хэмжээг эцэг эхийн асуулгаар үнэлж үзэхэд хүүхдүүдийн, ялангуяа хөвгүүдийн хүмүүжлийн доголдол буурсан дүнтэй байсан ба эцэг эхчүүд хөтөлбөрийг эергээр үнэлсэн байв.

Өмнөд Африкийн “Насан туршийн эрүүл мэндийг тэтгэх гэр бүлийн хүмүүжил” төсөл нь хязгаарлагдмал нөөцтэй орчинд хэрэгжүүлэх өртөг зардал багатай, ашгийн төлөө бус, үр дүн нь нотлогдсон эцэг эхийн боловсролын хөтөлбөр боловсруулж, туршин өргөн хүрээнд тараан түгээх зорилготой. Багц хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харьцахаас урьдчилан сэргийлж, улмаар цаашдын амьдралдаа үе тэнгийн дарамт дээрэлхэлт, бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх зорилготой бөгөөд асуудал шийдвэрлэх багийн ажил, хүчирхийллийн бус хүмүүжлийн эерэг аргууд, хүүхдийг түр хугацаагаар “завсарлуулах” арга, түүнийг ашиглахтай холбоотой зөвлөгөө, хүүхэд өсгөхөд хэрэгтэй ур чадварууд эзэмшүүлэх дадлага ажил зэргийг багтаадаг. Хөтөлбөрт хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудыг илүүтэй ашиглаж, хатуу ширүүн аргуудыг бага хэрэглэх, хүүхдэд тавих эцэг эхийн хараа хяналт сайжрах, шийтгэлийн бус аргуудыг илүү хэрэглэх, стресс багасаж сэтгэцийн эрүүл мэнд сайжрах үр дүн гарсан байхад төслийн үндсэн зорилго оршиж байна. Хүүхдийн хувьд төсөл нь зан үйл, хүмүүжлийн доголдол багасаж, зүй бус харьцаанд өртөх эрсдэл буурсан байх зорилго агуулдаг байна (96).

“Насан туршийн эрүүл мэндийг тэтгэх гэр бүлийн хүмүүжил” төслийн үр дүнг үнэлэх ажил одоо ид өрнөж байна. Өмнөд Африкийн нэн ядуу, гэр бүлийн ба залуучуудын хүчирхийлэл өндөр, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, ХДХВ/ДОХ-ын тархалт ихтэй хэд хэдэн орон нутагт санамсаргүй түүврийн аргаар төслийн үнэлгээг хийж байна. Төслийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг үнэлэх зорилготой судалгааны эхний шатны дүгнэлтээс харахад эцэг эхийн хамрагдалт сайн, дундаас нь гарах явдал бага байсан ба төсөл нь эцэг эхчүүдийг хүүхэд хүмүүжүүлэх эерэг, шийтгэлийн бус аргуудыг давамгайлж ашиглахад чиглүүлж чадаж байна гэсэн эерэг төлөв ажиглагджээ (96).

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр

Олон бүрдэл хэсэгтэй Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүд нь эмзэг бүлгийн өрхүүдэд (жишээлбэл, өсвөр насандаа хүүхэд төрүүлсэн эхчүүд, орлого багатай эцэг эх) чиглэдэг ба голдуу орон нутагт бэлэн байгаа нөөц боломжид (эрүүл мэндийн төв, сургууль, соёлын төв зэргээр дамжин) түшиглэн хэрэгждэг. Хөтөлбөрийн хүрээнд гэр бүлд үзүүлэх дэмжлэг, сургуулийн өмнөх боловсрол, хүүхдийн асаргаа болон эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хөтөлбөр нь 0-5 насны хүүхдийг хожим буюу өсвөр, залуу насанд нь хүчирхийлэл рүү хөтөлдөг эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөнөөс хамгаалах зорилготой бөгөөд эдгээр хүчин зүйлд багадаа хэт дураар авирлах, түрэмгий зан гаргах; танин мэдэхүйн, нийгмийн харилцаа ба сэтгэл хөдлөлийн ур чадвар дутагдах; гэр бүлийн дэмжлэг дутах; эцэг эх нь хүүхэд өсгөн хүмүүжүүлэх мэдлэг, чадвар дутагдах зэрэг багтана (97, 98).

ХУРААНГУЙ

- Залуучуудын хүчирхийлэл, хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэн баривчлагдах явдалд хөтөлбөрийн үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр нь залуучуудыг хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэн баривчлагдахаас илэрхий хамгаалж чадаж байна.
- Үр дүнгийн нотолгоо нь зөвхөн орлого өндөртэй орнуудад хамаатай.
- Судалгааны ихэнх нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Дураар аашлах, нийгмийн эсрэг зан үйл гаргах нь голдуу бага насанд илэрдэг бөгөөд энэ нь хүүхэд болон өсвөр үе, залуу насандаа илүү ноцтой хэрэг зөрчилд холбогдох, хүчирхийлэл үйлдэх магадлалыг илэрхийлсэн дохио болдог. Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр нь түрэмгий авир, сөрөг зан үйлийг багаас нь таслан зогсоож, эцэг эх, хүүхдийн хоорондын эерэг холбоог бэхжүүлэн, хамгаалагч хүчин зүйлс болох хүүхдийн сурлагын амжилтыг ахиулж, ур чадваруудыг хөгжүүлэх зорилт тавьдаг. Хөтөлбөр нь мөн хожмын өдөр хүүхдэд тулгарч болох нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлөө хянахтай холбоотой асуудлуудыг амжилттай шийдэх зорилгоор эцэг эхэд дэмжлэг үзүүлж, дэмжих орчин бий болгоход анхаардаг байна. Асаргаа, анхаарал халамж сайн байх нь хүүхдийн танин мэдэхүйн болон хэл ярианы хөгжил, сурлагын амжилтад эергээр нөлөөлдөг ба эдгээр нь өсвөр, залуу насны хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлс юм (99).

Нотолгоо

Дотроо олон бүрэлдэхүүн хэсэгтэй Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүдийн үнэлгээгээр хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн дунд өсвөр, залуу насандаа хүчирхийлэл, гэмт хэрэгт холбогдох, саатуулагдах, баривчлагдах явдал 13 хувиар буурсан дүн гарчээ

(100). Энэ үр дүнг нотлох баримт ихэнхдээ АНУ-д хэрэгжиж, сайтар судлагдан ХайСкоуп/Перри сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр (HighScope/Perry Preschool Program), Чикаго хотын эцэг эх, хүүхдийн хөгжлийн төвийн хөтөлбөр; Хед Старт (Head Start) ба Эрт үеийн Хэд Старт (Early Head Start), Эйбисидариан (Abecedarian) зэрэг хөтөлбөртэй холбоотой байна. Эдгээр хөтөлбөр нь мөн танин мэдэхүйн чадвар, сурлагын амжилт зэрэг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэхэд багаас дунд зэргийн нөлөө үзүүлж байгаа нь тогтоогджээ. Төвөөр дамжуулан¹ хэрэгжих хөтөлбөрүүдийн дундаас эрсдэлт бүлгийн хүүхэд, гэр бүлд чиглэсэн, мөн эцэг эхийн боловсролын асуудалд анхаарсан хөтөлбөрүүд илүү үр нөлөөтэй байх хандлага ажиглагджээ. Мөн ганцаарчилсан болон бүлгээр ажиллах аргазүйг хослуулсан хөтөлбөр нь аль нэг аргыг дангаар ашигласан хөтөлбөрөөс илүү үр дүнтэй байгааг судалгаа тогтоожээ (82).

Бага, дунд орлоготой Бангладеш, Бразил, Ямайк, Кени, Мавритус, төв Азийн хэд хэдэн улсад олон бүрэлдэхүүн хэсэгтэй Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжиж байна. Гэвч бага, дунд орлоготой оронд хэрэгжсэн хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ хийсэн нь цөөн байна (85, 97, 101).

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Бага насны хүүхдийн хөгжлийн асуудалд улс орнууд онцгой ач холбогдол өгөх болсон нь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилтыг дэвшүүлэн тавих боломжийг нээж байна. Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр нь үүнээс гадна хүүхдийн хичээл сурлага сайжрах, бүтээлч үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэх зэрэг эерэг үр дүн авчирдаг. Хөтөлбөрийн оролцогчид хөтөлбөрийг өргөнөөр дэмжиж байгаа нь ажиглагдав. Өндөр эрсдэлтэй дэд бүлгүүдийг сонгон хөтөлбөрт хамруулж байгаа тохиолдолд нийгмийн гадуурхалт, ялгаварлал гарахаас сэргийлэх бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй.

¹ Гэрээр очиж үйлчлэх бус, үйлчилгээний цэг/төвд ирүүлж үйлчилгээ хүргэх загвар (редакторын тайлбар)

Төв Азид Бага насны хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрүүдээ сайжруулж байгаа нь

Олон гэр бүлийг нэг зэрэг хамруулдаг “Сургууль, гэр бүл хамтдаа” (Families and Schools Together буюу FAST) хөтөлбөр нь нэг ангийн түвшний бүх хүүхэд, тэдний гэр бүлийнхэнд зориулсан 8 долоо хоногийн хичээлийн дараах үйл ажиллагаа юм. Хөтөлбөр нь эцэг эх, гэр бүлийн бусад хүмүүс, сургууль, орон нутгийн иргэдийг нэг дор цуглуулж, хүүхдийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхийн тулд орон нутаг даяараа харилцаа холбоотой байж, стрессээс хамгаалдаг хүчин зүйлсийг бэхжүүлэх зорилготой үйл ажиллагааг хамтран хийх боломж олгодог. Хөтөлбөрт хамрагдагсад хичээлийн дараа гэр бүлээрээ сургууль дээр ирж, хамт хооллоод, нийтийн арга хэмжээнд оролцдог. Нэг удаагийн хөтөлбөрт 80 хүртэлх тооны гэр бүл хамрагдан 10, 10-аараа бүлэг болж хуваагдаад, оногдсон ангид орж ажиллана. Бүлэг бүрийг тусгайлан бэлтгэгдсэн баг удирдан чиглүүлэх ба энэ багт эцэг эх, ахлах ангийн сурагч, сургуулийн ажилтан, мөн сэтгэцийн эрүүл мэнд, мансууруулах бодисын даслыг эмчлэх чиглэлийн мэргэжилтэн зэрэг хүмүүс багтана. Багш, сургалтын менежер нь эцэг эхчүүдээ дэмжин, бүлгийн ажилд наад зах нь нэг удаа заавал оролцохыг уриалан ажилладаг байна. Шинээр шилжиж ирсэн сурагчдын гэр бүл уг хөтөлбөрт оролцон, хүүхдийнхээ нэг ангийнхны эцэг эх, гэр бүлийнхэнтэй танилцахын зэрэгцээ хүүхдэдээ нэмэлт цаг гаргаж, дэмжин ажиллах боломжтой болдог. Хөтөлбөрийн зорилго нь:

- Гэр бүлийн эв нэгдэл, эцэг эх, хүүхдийн холбоог бэхжүүлэх
- Хүүхдийн сургууль дээрх амжилтыг бэхжүүлэх
- Гэр бүлийн хүрээнд согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах
- Гэр бүлийн стресс, нийгмээс тусгаарлагдах байдлыг багасгах (102) зэрэг болно.

Гэр бүлийн чадварыг хөгжүүлэх замаар залуу хүмүүсийн дундах хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах дэлхий нийтийн санаачилгын хүрээнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба “Сургууль, гэр бүл хамтдаа” хөтөлбөрийг Казакстан, Киргизстан, Тажикстан улсуудын есөн бага сургуульд хэрэгжүүлжээ (103, 104). Эдгээр сургууль дээр хөтөлбөрийн өмнө болон дараа эцэг эх, багш нараас хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, гэр бүлийн уур амьсгал, хүүхдийн сургуулийн амьдралд эцэг эхийн оролцооны тухай асуулга авч, мэдээллийг харьцуулах замаар хөтөлбөрийн үр дүнг үнэлжээ. Хөтөлбөрийн үр дүнд гэр бүлийн эв нэгдэл 21 хувиар сайжирч, гэр бүл дэх зөрчил 52 хувиар бууран, эцэг эх, хүүхдийн холбооны чанар, бат бөх байдал 27 хувиар, нийгмийн харилцаан дахь хүүхдийн найрсаг байдал 44 хувиар өсөж, сахилга батын зөрчил, хэт хөдөлгөөншил 7 хувиар буурсан гэж эцэг эхчүүд мэдээлжээ (104). Хөтөлбөр хэрэгжсэнээр эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээл, сургалтад илүү оролцох болж, хүүхдүүдийн сургууль дээрх зан үйл сайжирсан гэж багш нар үзжээ.

Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт

Хөтөлбөр нь ихэвчлэн үйлчилгээний төвөөр дамжин хэрэгжүүлэх хүүхдийн асаргаа сувилгаа, эцэг эхийн боловсролыг сайжруулах сургалтуудаас бүрддэг. Хөтөлбөрт сурах арга барилд сургах; амьдрах ухаан, нийгмийн харилцаа болон танин мэдэхүйн ур чадвар хөгжүүлэх; эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа багтдаг. Өндөр орлоготой улс орнуудад эдгээр хөтөлбөр нь хүүхдийн цэцэрлэг, орон нутгийн төв зэрэг бэлэн дэд бүтцээ ашиглан хэрэгждэг. Хөтөлбөрийн үйл ажиллагааг бага насны хүүхдийн хөгжлийн асуудлаар мэргэшсэн багш, сурган хүмүүжүүлэгчид гүйцэтгэдэг. Нэг ажилтанд ногдох хүүхдийн тоо цөөн, үргэлжлэх хугацаа харилцан адилгүй ч ихэвчлэн 3-5 сар байдаг. Зарим хөтөлбөр нь хүүхдийг хэдэн жилийн турш тасралтгүй хамруулдаг.

Зардал

Олон бүрэлдэхүүн хэсэгтэй Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүд нэлээд хэмнэлт авчрах боломжтой болохыг эдийн засгийн шинжилгээ харуулж байна. Зардал, үр ашгийн харьцаа нь хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа дуссанаас хойших дэмжлэгээс хамаарч 6:1-ээс 12:1-ийн хооронд хэлбэлзэж байна (98, 106, 107). Гэхдээ энэ харьцаа нь багадаа таатай бус орчинд өссөнөөс үүдэлтэй урт хугацааны үр дагавар (жишээлбэл, архи, мансууруулах бодисын хэрэглээ, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэндийн хямрал)-ыг арилгахад нэлээд хөрөнгө зарцуулдаг улс орнуудад хамааралтай тоо юм. Бусад улс оронд Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр нь асуудлыг бууруулахад хувь нэмэртэй ч оруулсан зардлын буцааж өгөх үр ашиг нь дээрх харьцаанаас бага байх юм.

Ямайк Улсын багш нарт чиглэсэн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр

Ямайк Улсын сургуулийн өмнөх насны бүх хүүхдийн дөрөвний гурав нь багшийн мэргэжил эзэмшээгүй боловсон хүчинтэй орон нутгийн цэцэрлэгт хүмүүждэг. Ихэнх цэцэрлэгийн орчин нөхцөл муу; сургалтын материалын зардлыг эцэг эхчүүдээр гаргуулдаг байна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Багшийн ур чадвар хөгжүүлэх “Гайхамшигт он жилүүд” (The Incredible Years) хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан өөрчилж, багшийн ангиа хянах, удирдах арга зүйг бэхжүүлэх, хүүхдэд нийтэч, соёлч зан үйл хэвшүүлэх, хүүхэд ангидаа түрэмгий зан гаргахыг багасгахад чиглэсэн агуулгатайгаар хэрэгжүүлжээ. Кингстон хотын ядуу хорооллын 24 цэцэрлэгийг санамсаргүй аргаар хөтөлбөрийн оролцогч, хяналтын бүлэгт гэсэн хоёр хэсэгт хуваасан байна. Хөтөлбөрийн үнэлгээг хийхдээ цэцэрлэгийн анги бүрээс хүмүүжлийн зөрчил хамгийн их гаргадаг гэж багшийн нэрлэсэн 3 хүүхдийг сонгон, асуулга авчээ (нийт 225 хүүхэд). Хөтөлбөрт хамрагдсан цэцэрлэгийн хүүхдүүдийн хүмүүжлийн зөрчил эрс цөөрч, багш болон эцэг эхийн ажигласнаар зан үйлийн хүндрэл бэрхшээл нь багасаж, ирц сайжирсан үр дүн харагджээ (108).

Сургуульд түшиглэсэн сурлагын амжилтыг ахиулах, нийгмийн харилцааны чадвар хөгжүүлэх стратеги

Амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх нь

Амьдрах ухааны ур чадвар, нийгмийн харилцааны ур чадвар гэж “Өдөр тутмын амьдралдаа тулгарах асуудал, хэрэгцээ шаардлагыг үр дүнтэй шийдэх боломжийг хувь хүнд олгодог дасан зохицох болон эерэг зан үйлийн чадамж” юм (109). ДЭМБ амьдрах ухааны үндсэн 10 ур чадварыг тодорхойлоод байгаа бөгөөд асуудал шийдвэрлэх чадвар, шүүмжлэлт сэтгэлгээ, үр дүнтэй харилцаа, шийдвэр гаргалт, бүтээлч сэтгэлгээ, хүмүүс хоорондын харилцааны чадвар, өөрийгөө ойлгож мэдрэх, бусдыг энэрэх сэтгэл, стресс ба сэтгэл хөдлөлөө удирдах чадвар зэрэг багтжээ. Амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрүүд нь хүүхэд, залуучуудад өөрийгөө таньж мэдэх, сэтгэл хөдлөлөө ойлгон, хянаж сурахад тусалдаг. Хөтөлбөр нь мөн эерэг харилцаа үүсгэж, түүнийгээ хадгалахад туслахын зэрэгцээ бусдын байр суурь, сэтгэл хөдлөлийг ойлгоход сургана. Ийм ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрүүд нь өдөр тутмын амьдралд тохиолддог янз бүрийн асуудал, дарамт стресс үүсгэгч зүйлс, харилцаанд гардаг зөрчил зэргийг бүтээлчээр хүлээж авах хандлагыг залуу хүмүүст төлөвшүүлэх зорилготой.

ХУРААНГУЙ

- Түрэмгий зан, сахилга батын зөрчил, хүчирхийлэл, нийгмийн харилцааны ур чадвар зэрэгт үзүүлэх нөлөөллийг хэмжиж үнэлсэн.
- Амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадварууд нь бага, дунд ангийн хүүхдүүдийн дундах түрэмгий зан үйл, хүчирхийллийг бууруулдаг.
- Бага, дунд орлоготой улс орнуудад хамаарах зарим нэг нотолгоо бүрдээд байгаа.
- Ихэнх судалгаа нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар нь сургууль, хөдөлмөрийн талбар дахь амжилтын суурь болж, улмаар өсвөр болон залуу насандаа хүчирхийлэлд холбогдохоос хамгаалах хүчин зүйл болдог байна. Залуучуудын дундах хүчирхийлэлд хүргэдэг хэд хэдэн эрсдэлт хүчин зүйл (тухайлбал, архи, мансууруулах бодисын хэрэглээ, сургууль завсардалт зэрэг) нь нийгмийн харилцааны ба сэтгэл хөдлөлөө удирдах ур чадвар сул, өөрийгөө сайн таньж ойлгоогүйтэй холбоотой байдаг ажээ. Амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрүүд нь нийгмийн харилцааны явцад гардаг зөрчил, сөргөлдөөнийг үр нөлөөтэй, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхэд хүүхэд, залуучуудыг сургах зорилготой. Амьдрах ухааны ур чадвар эзэмшүүлэх зарим хөтөлбөр сургуулийн бүх хүүхдийг хамруулдаг бол зарим нь түрэмгий дээрэнгүй зан үйл гаргадаг хүүхдүүдийг сонгон хамруулдаг.

Нотолгоо

Түрэмгий, дээрэлхүү зан үйлийг бууруулах зорилготой сургуульд түшиглэсэн хөтөлбөрүүдийн үнэлгээг ашигласан нэгэн мета-анализ нь бүх сурагчийг хамруулсан болон өндөр эрсдэлтэй зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн аль аль нь мэдэгдэхүйц үр нөлөөтэй байна гэж дүгнэжээ (110). Цаашилбал, танин мэдэхүйг хөгжүүлэх, нийгмийн харилцааны ур чадварт сургах, зан үйлийг өөрчлөх зэрэг зорилготой хөтөлбөрүүд бүгд үр нөлөөтэй байна гэсэн дүгнэлт гарчээ. Сургуулийн нийт сурагчийг хамруулсан сургуульд түшиглэсэн хөтөлбөрүүдийн тойм судалгаагаар хичээлийн жилийн туршид сурагчдын гаргасан түрэмгий зан үйл 15 хувиар, зөвхөн дунд ангийн сурагчдын дунд хүчирхийлэл 29 хувиар буурсан дүн гарчээ (111). Испани хэл дээр хэвлэгдсэн голдуу Латин Америкийн орнуудад хамаарах 54 судалгааны агуулгын шинжилгээгээр (112) ижил дүгнэлт гарсан байна. Өмнө нь түрэмгий зан үйл гаргаж байсан, эсвэл гаргах өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон хүүхэд, залуучуудад чиглэсэн сургуулиар дамжин хэрэгжих хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн хөтөлбөрүүд нь түрэмгий зан үйлийг эрс бууруулах нөлөөтэй байгааг системтэй тойм судалгаагаар тогтоожээ.

Сургуульд түшиглэсэн амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд өдөр тутмын ажиллагаа сайтай, хяналт болон менежментийн механизмууд нь бүрэлдэн тогтсон сургуулийн систем шаардлагатай. Амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөр нь хэдэн жилийн туршид үргэлжлэх ба нийт 20-150 цагийн танхимын сургалтаар хэрэгждэг. Ихэнх хөтөлбөр нь хүүхдийн насны онцлогт нийцсэн сургуулийн өмнөх ба цэцэрлэгийн насны, бага болон дунд ангийн насны гэсэн ангилалтай модулиудтай байдаг. Амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх сургалтын хөтөлбөр нь хүүхдэд уур уцаар, бусад сэтгэл хөдлөлөө ойлгож хянах, бусдад анхаарал тавих, бусадтай харилцаа холбоо тогтооход нь тус болох мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх агуулгатай байдаг. Хөтөлбөрийг хичээлийн үндсэн хөтөлбөрт интеграцчилж суулган багш, эсвэл тусгай хөтөлбөрөөр нийгмийн ажилтан хүргэх хэлбэрээр хэрэгжүүлдэг.

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрийг хүүхэд залуучууд өргөнөөр дэмжиж хүлээн авдаг. Харин шийдвэр гаргагчдын дэмжлэгийг олж авахын тулд хөтөлбөрийн ач холбогдол, богино болон урт хугацааны үр нөлөөг нь тайлбарлаж таниулах хэрэгтэй. Эдгээр хөтөлбөрийг дэмжүүлэхээр нөлөөллийн ажил хийхдээ амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүнд хүүхдүүдийн сурлагын амжилт дээшилж, сурагчид ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэлтэй болж, залуучуудын дунд мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээ буурдаг зэрэг хоёрдогч зэрэг үр нөлөөг нь онцлох хэрэгтэй.

Зардал, үр ашиг

Хөтөлбөрийн төсөв нь үйл ажиллагаа хэрэгжүүлэх багш нарыг бэлтгэх сургалт; төслийн туршид багш, зохицуулагчдад үзүүлэх арга зүйн дэмжлэг; сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах зардал зэргээс бүрддэг. АНУ-ын сургуулиудад амьдрах ухаан, нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх бүх нийтийн хөтөлбөрүүд хэрэгждэг ба “Амьдрах ухааны ур чадвар” хөтөлбөрийн зардал нэг сурагчид нэг жилд 35 ам. доллар, “Хувилбарт сэтгэлгээний стратеги” хөтөлбөрийн зардал нэг ангид 350-600 ам. доллар, “Эерэг үйл” хөтөлбөрийн зардал нэг ангид 390-460 ам. доллар байжээ. Эдгээр хөтөлбөрт хийсэн эдийн засгийн шинжилгээгээр хүчирхийллээс сэргийлэх болон хар тамхины хэрэглээ буурах зэрэг үр дүнг хамтатган тооцвол зардал, үр ашгийн харьцаа нь 25:1 байжээ (114).

Колумб Улсад хэрэгжсэн амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх сургалт

Сургуульд түшиглэсэн амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх “Амар тайван анги танхим” (Aulas en Paz) хөтөлбөрийг Колумб Улсын 27 сургуульд хэрэгжүүлжээ. Хөтөлбөр нь 3 үндсэн хэсэгтэй. Эхний хэсэгт амьдрах ухааны ур чадвар, бусдыг ойлгож хандах, уур уцаараа хянаж удирдах, идэвхтэй сонсох ур чадварыг хүүхдүүдэд зааж, дадлага хийлгэжээ. Хоёр дахь хэсэг нь эцэг эх, асран хамгаалагчдад зориулагдсан ба тэд жилийн туршид 4 удаагийн сургалт семинарт оролцон, хүүхэд залуучуудын хөгжил, зөрчлийг шийдвэрлэх аргуудад суралцжээ. Үүний зэрэгцээ, өмнө нь түрэмгий зан үйл гаргаж, хэрэг зөрчилд холбогдож байсан хүүхдүүдийн эцэг эхчүүдэд жилд 4 удаа гэрээр нь очиж зөвлөгөө өгөн, долоо хоног бүр утсаар холбогддог байна. Гурав дахь хэсэг нь түрэмгий зан үйл гаргадаг хүүхдүүдэд түрэмгий бус зан үйлийн сайн загварыг ажиглаж, суралцах боломж олгох зорилгоор сахилга бат сайтай хүүхдүүдтэй нэг бүлэг, баг болгон ажиллуулах үйл ажиллагаа юм. Хөтөлбөр нь нэг жилийн 40 удаагийн хичээлээс бүрдэх ба хичээл бүр нь 45 минут үргэлжилнэ. Хөтөлбөрийн эхэн болон төгсгөлд хийсэн үнэлгээгээр хүүхдүүдийн дунд түрэмгий зан үйл буурч, сахилга бат сайжирсан байжээ (115).

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр

Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлт гэдэг нь төрсөн ах дүү, болзож байгаа хүн зэрэг ойр дотно холбоо байхгүй хүн юмуу бүлэг залуусын зүгээс гарах түрэмгий зан үйл бөгөөд бодит юмуу төсөөлөгдсөн хүч тэнцвэргүй байдлаас үүсэлтэй энэ үйлдэл нь давтамжтай, эсвэл давтагдах өндөр магадлалтай байх онцлогтой. Үе тэнгийнхний дарамт нь өртсөн хүүхдэд бие махбод, сэтгэл санааны хохирол, хямрал учруулж, нийгмийн харилцаа болон сурч боловсроход нь сөргөөр нөлөөлдөг.

ХУРААНГУЙ

- Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлт үйлдэх, түүнд өртөхийн үр нөлөөг үнэлсэн судалгаанууд бий.
- Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар үйлдэх, өртөх явдал багасдаг.
- Өндөр орлоготой нэлээд хэдэн орны туршлагад түшиглэсэн нотолгоо бүрдээд байна.
- Ихэнх судалгаа нь аргачлал сайтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлт нь залуучуудын дундах хүчирхийллийн нэг хэлбэр болоод зогсохгүй даамжирснаар илүү ноцтой хүчирхийлэлд хүргэдэг эрсдэлт хүчин зүйл юм (22). Үе тэнгийнхний дарамт нь бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, эд хөрөнгийн хохирол зэрэг хэлбэртэй байж болно (117).

Нотолгоо

Энэ төрлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой 22 хөтөлбөрийн мэдээллийг системтэйгээр тоймлон нэгтгэхэд (117) хөтөлбөрүүдийн тал нь үе тэнгийнхний дарамт үйлдэх явдлыг, 67 хувь нь өртөх явдлыг дорвитой бууруулсан үр дүн гарчээ. Нарийвчилсан судалгаагаар урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь үе тэнгийнхний дарамт дээрэлхэлт үйлдэх явдлыг дунджаар 20-30 хувиар, түүнд өртөх явдлыг 17-20 хувиар бууруулсан дүн гарчээ (118). Судалгаагаар мөн үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн амжилтын үндэс болж буй зүйлсийг тодорхойлоход багш, эцэг эхэд сургалт хийх, сургуулийг бүхэлд нь хамарсан дарамт дээрэлхэлтийн эсрэг хатуу дүрэм журам гаргах, сургалтын видео материал ашиглах зэрэг багтжээ.

Үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд үе тэнгийнхний дээрэлхэлтийн түвшин, хэлбэрийг тогтоох зорилготой гарааны нөхцөл байдлын үнэлгээнээс эхэлдэг бөгөөд үр дүнг нь хөтөлбөрөө боловсруулахад ашиглахын зэрэгцээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үзүүлэлт болгож ашигладаг. Ихэнх хөтөлбөр нь үе тэнгийн дарамт, дээрэлхэлттэй хэрхэн үр нөлөөтэй тэмцэх талаар сургуулийн бүх ажилтан, эцэг эхэд зориулсан сургалт, хөтөлбөр хэрхэн хэрэгжүүлэх, анги танхимд сурагчдын харилцаа, зан үйлийг хэрхэн зохицуулах талаар багш нарт зориулсан сургалтаас бүрдэнэ. Багш нар дарамт, дээрэлхэлт гэж юу болох, энэ үзэгдлийг хэрхэн таньж мэдэх, дарамт дээрэлхэлт гарсан тохиолдолд юу хийх тухай сурагчдад хэрхэн заах, сурагчдын харилцааны ур чадварууд, мөн дарамт дээрэлхэлтийн гэрч болсон тохиолдолд хэрэг болох ур чадварыг хөгжүүлэхэд суралцдаг байна. Дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх

агуулгыг стандарт хичээлүүдийн агуулгад суулган интеграцчилж хүргэхийн зэрэгцээ хөтөлбөрүүд үе тэнгийн дарамтын үйлдэгч, хохирогч хүүхдүүдтэй шууд ажиллахдаа илүү мэргэшсэн боловсон хүчин (жишээлбэл, сургуулийн нийгмийн ажилтан)-г дайчлан ажиллуулдаг. Ихэнх хөтөлбөр нь дарамт, дээрэлхэлтийн асуудлыг зохицуулсан сургуулийн бодлого, журам бий болгохыг шаарддаг (118-120).

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Хүүхэд залуучууд дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг өргөнөөр дэмжиж хүлээн авдаг. Дарамтлагч, хохирогч хүүхдүүдийн эцэг эхийг хамруулах нь хөтөлбөрийн амжилтыг нэмэгдүүлэх нэг чухал алхам болдог ч ингэснээр хохирогч хүүхэд ичиж зовох, нэр хүнд нь унах, харин дарамтлагч нь эцэг эхийн хатуу шийтгэлд өртөх эрсдэлтэй. Гэхдээ үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх аливаа хөтөлбөрийн амжилтын нэг үндэс нь эцэг эхийг оролцоо юм. Дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлага, багш нар тууштай бөгөөд идэвхтэй оролцож, сурагчдад хяналт тавьж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах нь нэн чухал.

Зардал

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зардалд сургуулийн удирдлага, багш нарыг сургахтай холбоотой зардал, мөн тэдний нэмэгдэл цагийн хөлс (долоо хоногийн 20-40 минут) зэрэг багтдаг. Жишээлбэл, үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх Олвеус хөтөлбөрийг дунд хэмжээтэй сургуульд хэрэгжүүлэхэд нэг жилд нэг сурагчид 25 ам. долларын зардал гардаг байна.

Үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх Испани Улсын туршлага

“Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг Севиллийн их сургуулийн төсөл” (The Proyecto Sevilla Antiviolenencia Escolar) нь үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх зорилгоор Испанийн 29 орон нутагт хэрэгжүүлсэн хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн хүрээнд үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудлыг сургуулийн хэмжээнд хариуцах элч буюу тусгайлсан ажилтан томилох, сургалтын агуулгыг шинэчлэх, сургуулийн бүх хүүхдийг нийгмийн харилцааны ур чадвар, энэрэнгүй хандлага хөгжүүлэх сургалтад хамруулах, мөн бусдыг дээрэлхэх үйлдэлд оролцсон сурагчдыг эрчимтэй хөтөлбөрт хамруулах зэрэг үйл ажиллагаа багтжээ. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 4900 сурагчийг сонгон судалгаа авсан ба уг хөтөлбөр нь үе тэнгийн дарамт, дээрэлхэлтэд өртөх явдлыг 25 -аас 15 хувь болгож бууруулсан дүн гарчээ (121).

Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөр

Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөр нь сурлагаар хоцорсон хүүхдүүдэд хичээл сурлагын дэмжлэг үзүүлэх, хичээлийн бус цагаар зохион байгуулалттай арга хэмжээнд хамруулах замаар сурлагын амжилт, сурах идэвхийг нь өрнүүлэх, мөн сургууль завсардах эрсдэлтэй, эсвэл завсардчихаад байгаа хүүхэд, залуучуудад дунд сургуулиа төгсөхөд нь дэмжлэг үзүүлдэг хөтөлбөр юм.

ХУРААНГУЙ

- Сурлагын амжилт, сурах үйл явцад үзүүлж буй үр нөлөөг үнэлсэн.
- Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөр нь бичиг үсэг, тоо бодох чадвар, сурлагын амжилтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нийгмийн дасан зохицлыг сайжруулж байна.
- Бага, дунд орлоготой зарим улс оронд хамаарах нотолгоо бүрдээд байгаа.
- Ихэнх судалгаа нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Сурлагаар хоцрох, хичээл таслах нь хүчирхийлэлд хөтөлдөг эрсдэлт хүчин зүйлс мөн. Сургуульд сурсан нийт жил нь ирээдүйд ажилтай болох магадлалтай шууд холбоотой чухал урьтач нөхцөл болдог бөгөөд сургуульд сурах, ажилтай байх нь хүчирхийллээс хамгаалдаг чухал хүчин зүйлс юм. Улмаар хүүхдийн сурлагын амжилт, хичээлийн ирцийг дэмжсэн хөтөлбөрүүд нь хүчирхийллийг бууруулах магадлалтай (88). Бразил, Чили, Гондурас, Мексик, АНУ-д хийсэн судалгаагаар сурагчид сургуульдаа дуртай, татагдаж байхын хэрээр хичээл таслах, зодолдох, бусдыг дээрэлхэх, танхайрах тохиолдлууд буурч байжээ (122). Гэхдээ хичээл сурлагыг дэмжих хөтөлбөрүүд нь залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой зарим эрсдэлийг бууруулах нөлөөтэй ч тухай улс орон, орон нутгийн боловсролын хүртээмж, чанар нь муу, мөн нийгмийн бүлгүүдийн хооронд боловсролын тэгш бус байдал (охид, хөвгүүдийн хооронд гэх мэт) их байдаг бол энэхүү үр нөлөө хумигддаг.

Нотолгоо

Хичээл, сурлагыг дэмжих хөтөлбөр нь сургалтын амжилтыг ахиулж, хичээл таслалтыг бууруулах нөлөөтэй болох нь хэд хэдэн судалгаагаар нотлогдоод байгаа ч ийм хөтөлбөр хүчирхийлэлд өртөх, үйлдэх, үе тэнгийнхнээ дээрэлхэх явдал, гэмтэл бэртэл зэрэг хүчирхийллийн шууд үр дагавруудад хэрхэн нөлөөлж байгааг судалсан судалгаа маш цөөн байна. Ихэнх судалгаа сурлагын амжилт, сургууль төгсөх зэрэг үзүүлэлтэд хөтөлбөрийн үзүүлсэн нөлөөг хэмжихэд төвлөрчээ. Жишээлбэл, зарим судалгаагаар сурлагыг амжилтыг дэмжих хөтөлбөр нь бичиг үсгийн болон тоо бодох ур чадвар, нийгмийн орчин нөхцөлд дасан зохицох чадварыг ахиулж байгаа нь дам байдлаар хүчирхийллээс хамгаалах нөлөө үзүүлнэ гэж үзжээ (123). Сурлагын амжилтыг дэмжих аливаа хөтөлбөртэй холбоотой ямар нэг сөрөг үр дагавар ажиглагдаагүй бөгөөд хүчирхийллээс сэргийлэхийн зэрэгцээ өөртөө итгэх итгэл нэмэгдэх, сургуульдаа илүү

татагдах, харилцааны эерэг зан үйл нэмэгдэх, сурлагын амжилт өсөх зэрэг бусад эерэг үр нөлөө гарсан байна.

Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд чиглэсэн сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөр нь хүүхдүүдийн дундах боловсролын тэгш бус байдлыг бууруулж, боловсролын түвшинг жигдлэх зорилготой. Харин сургуулийн насны, нэн ялангуяа ахлах ангийнханд чиглэсэн хөтөлбөр нь сурлагаар хоцрохгүй байхад туслах, улмаар сургууль завсардахаас сэргийлэх зорилготой хичээлийн бус цагийн нэмэлт хичээл, ганцаарчилсан давтлага зэрэг үйл ажиллагаанаас бүрддэг. Заримдаа ийм хөтөлбөрийг телевизээр дамжуулан хэрэгжүүлдэг бөгөөд үүний нэг жишээ нь Мексик Улсад хэрэгжүүлж байгаа “Телесекундариа” (Telesecundaria буюу теле-дунд боловсрол) хөтөлбөр юм.

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Сурлагын амжилтыг ахиулах стратегийг бодлого боловсруулагчид таашаан дэмждэг. Мөн хөтөлбөрийн оролцогчдын дунд сургууль завсардалт бага буюу Мексикийн “Телесекундариа” хөтөлбөр 25 хувь, Индонезийн “Нээлттэй ахлах сургууль” хөтөлбөр 7 хувийн завсардалттай байгаагаас харахад оролцогч хүүхдүүд уг хөтөлбөрт дуртай байдаг (24, 125).

Зардал

Сурлагын амжилтыг дэмжих хөтөлбөрийн өртөг зардлын талаар мэдээлэл тун бага байна. АНУ-ын Лос-Анжелос хотон хэрэгжүүлсэн “Маргаашийн төлөө бүр сайн сурцгаая” (Better Educated Students for Tomorrow буюу LA’s BEST) хөтөлбөрийн эдийн засгийн шинжилгээгээр хөтөлбөрт зарцуулсан нэг ам. доллар бүрт дунджаар 2.5 ам долларын ашиг эргэж ирсэн байна (126).

Танзани Улсын Занзибарт хэрэгжүүлсэн хичээл сурлага дэмжих радио хөтөлбөр

Занзибарын “Боловсролыг бэхжүүлэх радио хичээл” хөтөлбөр нь хүрч үйлчлэхэд хэцүү хүн амд боловсролын үйлчилгээг амжилттай хүргэж байгаагийн жишээ юм. Алслагдсан орон нутгуудад бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээг хүргэх хэд хэдэн загварыг боловсруулж, турших зорилготой уг төслийг Занзибар мужийн Боловсролын яам болон Мэргэжлийн сургалт, боловсролын хөгжлийн төв хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд хэл ярианы хөгжил, тоо, амьдрах ухааны хичээлүүдийг радиогоор зааж байна. Одоогийн байдлаар хөтөлбөрийн зөвхөн боловсролын үр нөлөөг үнэлээд байгаа ба цаашид энэ хөтөлбөр хүүхэд өсөж том болохын хэрээр өсвөр болон залуу насандаа хүчирхийлэлд холбогдохоос хамгаалж чадаж байгаа эсэхийг судалж тогтоох хэрэгтэй байна (127).

Болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр

Болзооны харилцаан дахь хүчирхийлэл гэж болзож байгаа хүмүүсийн дунд бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, сэтгэл зүйн хүчирхийлэл гарахыг хэлнэ. Болзооны үеийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь залуу хүмүүст эрүүл, хүчирхийлэлгүй харилцаа бий болгох мэдлэг чадварыг эзэмшүүлж, хурцадмал байдлыг даван туулах эерэг аргууд, зөрчилдөөнийг хүчирхийлэлгүй шийдэх арга хандлагыг төлөвшүүлэх зорилготой. 12-16 насны сурагчдыг хамруулдаг уг хөтөлбөр сургуульд түшиглэн хэрэгждэг.

ХУРААНГУЙ

- Болзож буй залуусын бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх хувь хэмжээнд үзүүлэх өөрийн мэдээлсэн нөлөөг үнэлсэн.
- Болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр үр нөлөөтэй эсэхийг тодорхой хэлэх боломжгүй байгаа ба хэд хэдэн системтэй шинжилгээ нь холимог дүгнэлтэд хүрчээ.
- Зөвхөн өндөр хөгжилтэй цөөн хэдэн улс оронд хамаатай нотолгоо бүрдээд байна.
- Ихэнх судалгаа нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Болзооны харилцаан дахь хүчирхийлэл бол бэлгийн хамтрагчийн хүчирхийллийн эрт үеийн хэлбэр бөгөөд өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд тохиолддог. Эрт үеийн дотно харилцаандаа хүчирхийлэлд өртөж байсан хүмүүсийн хувьд цаашдын амьдралынхаа явцад хүчирхийлэл үйлдэх, хохирогч болох эрсдэл нэмэгддэг байна. Болзооны харилцаанд соёлын хэм хэмжээ хүчтэй нөлөөлдөг учраас энэ төрлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь соёлын онцлогийг тусгасан өвөрмөц ялгаа ихтэй байхаас гадна өсвөр насныхан, залуу хүмүүс болзох харилцааг хүлээн зөвшөөрдөг орчин нөхцөлд үр нөлөөтэй байдаг.

Нотолгоо

Урьдчилан сэргийлэх зорилготой хэд хэдэн хөтөлбөрийн өгөгдлийг нэгтгэн дүгнэсэн мета анализаар (128) болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх явдлыг (өөрөө мэдүүлсэн байдлаар) бууруулах нөлөөтэй байгаа эсэхийг нэг мөр хэлж чадахааргүй холимог дүгнэлт гарчээ. Өөр нэг системтэй шинжилгээгээр (129) хөтөлбөрүүдийн тал нь болзох харилцаан дахь хүчирхийллийг бууруулж чадсан (өөрийн мэдүүлснээр), үлдсэн тал нь бие махбодын, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийллийг бууруулахад ямар нэг нөлөө үзүүлээгүй гэсэн дүгнэлт гарчээ. Нэмж хэлэхэд, ихэнх үнэлгээ нь хөтөлбөрт оролцогчдын ойлголт, хандлагад гарсан эерэг өөрчлөлтийг хэмжих аргачлалтай байв. Бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг батлах нотолгооны ихэнх нь Канад, АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад хамаатай (130) бөгөөд БНСУ-д хийсэн нэг судалгааг багтаажээ. Дунд болон бага

орлоготой улс орнуудад бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх ажил одоо хийгдэж байна.

Болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Ихэнх хөтөлбөр нь охид, хөвгүүдийн холимог бүлгээр сургууль дээр хэрэгждэг ч заримдаа охид, хөвгүүдийг тус тусад нь хамруулдаг. Хөтөлбөрийн агуулга, үйл ажиллагааг ихэнхдээ үндсэн хичээлүүдийн агуулгад интеграцчилж оруулдаг ба жилийн 30-40 цагийн агуулгыг тарааж суулгадаг байна. Мөн хөтөлбөрийн үйл ажиллагааг хичээлээс гадуурх спорт, сонирхлын клуб гэх мэт хэлбэрээр багшийн удирдлага дор хэрэгжүүлж болно. Хөтөлбөрт хамрагдаж байгаа өсвөр насны хүүхдүүдийн эцэг, эхэд мэдээлэл өгөх, тэднийг үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор тараах хуудас хүргүүлэх, мэдээллийн үдэшлэг зохион байгуулах ажил заавал багтдаг. Болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн үйл ажиллагаа нь дүрд тоглох, гарын авлага гаргах, тоглоом, хэлэлцүүлэг хийх, ухуулах хуудас гаргах, жүжигчилсэн тоглолт хийх зэрэг хэлбэртэй байдаг. Хөтөлбөр агуулга нь халамжит болон хүчирхийлэлт харилцааны шинж чанаруудыг тодорхойлох, бие биедээ туслах найз нөхдийн дэмжлэгийг хэрхэн бий болгох, харилцааны ур чадвар, бэлгийн дарамтад орсон бол туслалцаа дэмжлэгийг хэрхэн, хаанаас хайх зэрэг сэдэвт төвлөрдөг.

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Ихэнх соёлд болзоог өргөнөөр хүлээн зөвшөөрдөг ч зарим нийгэмд хүлээн зөвшөөрдөггүй, залуу хүмүүс эрт гэрлэдэг юмуу гэр бүлийн гадуурх харилцааг буруушаадаг соёлын орчинд бол хориотой байдаг. Зорилтот бүлгийн залуусын эцэг эхчүүд хөтөлбөр нь залуу хүмүүсийг бэлгийн харьцаанд эрт оруулах түлхэц болно гэж үзэх юм бол хөтөлбөрт оролцуулахаас татгалзах явдал гарч болно.

Болзооны харилцаан дахь хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь сургуульд түшиглэсэн уламжлалт амьдрах ухааны хөтөлбөр, бэлгийн юмуу нөхөн үржихүйн хөтөлбөр зэрэгт хялбархан интеграцчилан суулгаж болох агуулгатай ба сургууль, эрүүл мэндийн төвөөр дамжуулан, эсвэл хүүхэд, залуучуудын чөлөөт цагийн арга хэмжээний үеэр хэрэгжүүлэх боломжтой.

Зардал

Эцэг, эхэд мэдээлэл хүргэн зөвшөөрлийг нь авах, мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш, ажилтнуудыг сургах зорилгоор хөтөлбөрийн материал, мэдээллийн хуудас, гарын авлагыг орчуулан, орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулах шаардлагатай. Канадад “Дөрвөн Р” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэг сурагчид 16 орчим ам. долларын зардал гарчээ (131).

Өмнөд Африк, Танзани Улсад хэрэгжүүлсэн болзооны харилцаан дах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр

Өмнөд болон Зүүн Африкийн бүсийн өсвөр насныхны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх төсөл нь 12-14 насны хүүхдүүдэд эрүүл аюулгүй бэлгийн зан үйл төлөвшүүлэх зорилгоор сургуульд түшиглэсэн шинэлэг хөтөлбөрүүд боловсруулан, хэрэгжүүлэх зорилготой. Төслийн үндсэн зорилго нь бэлгийн замаар дамжих халдвар, өсвөр насныхны дундах бэлгийн харилцагчийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх явдал юм. Өсвөр насныхны дунд хийсэн явцын судалгаа, бусад судалгааны дүнд тулгуурлан төслөөс сурагчдыг эрүүл аюулгүй бэлгийн зан үйлд сургах зорилгоор хөтөлбөр боловсруулж, туршин сайжруулснаа Кейп Таун, Дар эс Салаам хотын сургуулиудад хэрэгжүүлэхээр бэлтгэлээ хангаад байна. Хөтөлбөрийг боловсруулахдаа чанарын болон тооны үзүүлэлтээр хөтөлбөрийн явцыг үнэлэх боломжтой байхаар төлөвлөжээ. Нэмэлт мэдээллийг <http://prepare.b.uib.no/> хаягаас авна уу (130).

Өсвөр насныхны хичээлийн ирцийг дэмжих санхүүгийн урамшууллын хөтөлбөр

Энэхүү стратегид хичээлийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор нөхцөлт мөнгөн дэмжлэг олгох, сургалтын ваучер (эрхийн бичиг) өгөх, буцалтгүй тусламж болон хичээлийн хэрэгсэл үнэгүй олгох, сургуульдаа ирэхдээ нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих зэрэг арга хэмжээ багтана.

ХУРААНГУЙ

- Хичээлийн ирцэд үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Хичээлийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор өсвөр насныханд санхүүгийн урамшуулал олгох нь ирц сайжруулахад эергээр нөлөөлж байх магадлалтай.
- Хязгаарлагдмал нөөц боломжтой улс оронд хамааралтай зарим нэг нотолгоо бий болж байна.
- Судалгааны зарим нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Сургууль завсардах, боловсролын түвшин доогуур, насанд хүрсэн хойноо ажил олж чадахгүй байх зэрэг нь хүчирхийлэлд хөтөлдөг эрсдэлт хүчин зүйл болдог бол хичээл таслахгүй байх, боловсролын түвшин ахиулах зэрэг нь хүчирхийллийн эсрэг хамгаалагч хүчин зүйл болдог. Сургуульдаа дуртай байх нь хүчирхийлэлтэй урвуу хамааралтай болох нь нотлогдоод байна (132). Иймд хичээл таслахгүй байх нөхцөлтэй урамшуулал нь өсвөр насныханд нөлөөлж чадах хөшүүрэг болж байна.

Нотолгоо

Хичээл таслахгүй байх нөхцөлтэй мөнгөн тэтгэмж, санхүүгийн бусад урамшуулал нь залуучуудын дундах хүчирхийллийн гаралтад хэрхэн нөлөөлж байгааг авч үзсэн үнэлгээний тайлан олдсонгүй (133, 134). Гэхдээ санхүүгийн урамшуулал, боловсролын тэтгэмж, тэтгэлэг нь хүчирхийллээс хамгаалах хүчин зүйл болох сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх нөлөөтэй байна (135, 136). Өсвөр насны хүүхэд нь сургуульд явж байх нөхцөлтэйгөөр гэр бүлд тэтгэмж олгодог Мексикийн “Опортунидадес” хөтөлбөрийн (Oportunidades буюу боломж) үр дүнд дунд сургуулийн хамрагдалт 8 хувиар өсжээ (137). Бразилд “Болса Эскола” хөтөлбөр (Bolsa Escola буюу сургуулийн тэтгэмж) хэрэгжүүлснээр сургууль завсардалт буурсан дүн гарчээ (138).

Өсвөр насныхны хичээлийн ирцийг дэмжих мөнгөн тэтгэмж, санхүүгийн бусад урамшуулалт хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Латин Америкийн орнууд, Турк, АНУ, бусад оронд өсвөр насныхныг дунд сургуулиас завсардуулахгүй байх анхдагч ба хоёрдогч зорилготой мөнгөн тэтгэмжийн томоохон хөтөлбөрүүд хэрэгжсэн. Эдгээр хөтөлбөр нь нэг гэр бүл юмуу нэг хүүхдэд ногдох хэмжээгээр тооцон бэлэн мөнгө олгодог ба ингэхдээ өсвөр насны хүүхэд нь хичээлийн нэг өдрийн 80-аас доошгүй хувийг хичээлдээ сууж өнгөрөөх нөхцөл тавьдаг. Мөнгөн тэтгэмж нь сургуулийн төлбөр, хичээлийн хэрэгсэл зэрэг шууд зардлыг санхүүжүүлэх, мөн хүүхдээ сургуульд явуулснаар тухайн гэр бүлд учирч болох боломжит орлогын алдагдлыг нөхөх зориулалттай. Жишээлбэл, Бразилд Болса Эскола хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүүхдийг хөдөлмөр эрхлэлтээс хамгаалж, сургууль завсардахаас сэргийлэх зорилт тавьжээ. Хүүхэд нь сургуульд баталгаатай явж байгаа тохиолдолд өрх хоёр сар тутамд 15 бразил реал авдаг байна.

Мексик: Сургуулиа төгсөх нөхцөлтэй залуучуудын урамшууллын хөтөлбөр

Опортунидадес (Боломж) хөтөлбөр бол Мексикийн ядуурлыг бууруулах үндсэн хөтөлбөр юм. Хөтөлбөр нь өрхийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор мөнгөн тэтгэмж олгодог ба үүнд тухайн өрхийн 22 хүртэлх насны хүүхдүүдэд сургуулиа төгсөх нөхцөлтэйгөөр олгох боловсролын тэтгэмж багтдаг. Хэд хэдэн удаагийн үнэлгээгээр уг хөтөлбөр нь залуучуудын сургуульд хамрагдалт, сургуульд суралцах нийт жил, сургууль завсардалтын хувь хэмжээ, ажил олох магадлал зэрэгт эерэг нөлөө үзүүлсэн дүн гарчээ. Согтууруулах ундаа, тамхины хэрэглээ болон өндөр эрсдэлтэй бэлгийн зан үйл багассан байхад бэлгийн хамтрагчийн хүчирхийлэлд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна. Харин залуучуудыг хүчирхийллээс хамгаалах хөтөлбөр хэрхэн нөлөөлж байгааг үнэлээгүй байна. 1997 онд хөдөөний ядуу орон нутгуудад хэрэгжиж эхэлсэн уг хөтөлбөр яваандаа хот суурин газрыг хамруулан тэлсээр, одоо дөрвөн сая орчим өрхөд хүрч үйлчилж байна (137).

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Нөхцөлт мөнгөн тэтгэмж, санхүүгийн урамшууллын хөтөлбөрүүд нь янз бүрийн орчин нөхцөлд өргөнөөр дэмжигддэг. Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хөтөлбөр нь хүн амын ядуу хэсэгт илүү нөлөөлж, эрүүл аюулгүй зан үйл хэвшүүлэх, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлдэг. Заримдаа нөхцөлт тэтгэмж, санхүүгийн урамшуулалд хамрагдах болзлыг хангахын тулд эрсдэлт зан үйл улам нэмэгдэх тохиолдол гарч болзошгүй. Мөн бэлэн мөнгө, санхүүгийн урамшуулал нь бэлэнчлэх сэтгэлгээг бий болгож, бусад эх сурвалжаас олсон орлогоо эрүүл бус зан үйлд шилжүүлэн зарцуулах тул үр дүнгүй, мөн авлига өгөх нөхцөл болно гэх зэрэг шүүмжлэл гардаг (140).

Зардал

Хөтөлбөрийн зардал нь нөхцөл байдлаас хамаарч янз бүр байдаг. Ерөнхийдөө нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээ нь өсвөр насны хүүхдийн боломжит орлогоос бага байх ёстой ба том болсон хүүхдээ сургуульд явуулахтай холбоотой гэр бүлийн шууд бус зардал өсөх, мөн өсвөр насны хүүхдэд хар тамхины наймаа гэх мэт их орлоготой ч эрсдэлтэй зүйлд оролцох боломж байдаг зэргийг тооцоолох ёстой. Хүүхдийн боловсролтой холбоотой мөнгөн тэтгэмжийн зэрэгцээ нэмэлт хэд хэдэн дэмжлэг багтаасан Бразилийн “Болса Фамилия” хөтөлбөр (Bolsa Familia буюу өрхийн тэтгэмж) нь ойролцоогоор ДНБ-ийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний зардлаар хэрэгждэг байна (141).

Үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр

Залуучуудын дунд зөрчил, хүчирхийлэл гарвал үе тэнгийнхэн нь албан ёсоор оролцож зохицуулах ажлыг үе тэнгийн зуучлал гэж нэрлэдэг. Сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн сурагч хүүхдүүд үе тэнгийнхэндээ өдөр тутмын зөрчил, маргааныг хамтран шийдвэрлэхэд нь тусалдаг. Үе тэнгийн зуучлал, зөвлөгөө бол сайн дурын үйл ажиллагаа юм. Үе тэнгийн зуучлал, зөвлөгөө нь хувь хүний нууцыг хадгалах зарчимтай тул амь насанд аюултай, эсвэл хууль бус байж болзошгүй асуудлаар мэдээлэл солилцохоос бусдаар насанд хүрэгчид, багш нарыг оролцуулдаггүй (142).

ХУРААНГУЙ

- Зөрчлийг зохицуулах, хэлэлцэн зөвшилцөх ур чадварын хөгжил, мөн өсвөр насныхны дундах дээрэлхэлт, зодоон зэрэгт үе тэнгийн зуучлалын үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Үе тэнгийн зуучлалын үр нөлөөний талаар нэг мөр дүгнэлт хийж чадаагүй бөгөөд учир нь системтэй хэд хэдэн үнэлгээ нь хоорондоо зөрчилдсөн дүгнэлтэд хүрсэн бол зарим үнэлгээгээр сөрөг нөлөөлөл илэрчээ.
- Зөвхөн өндөр хөгжилтэй улс орнуудад хамаатай нотолгоо бүрдээд байна.
- Судалгааны ихэнх нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Сургуулийн орчинд сурагчдын дунд зөрчил байнга гарч байдаг ч ихэнх нь ноцтой гэмтэлд хүргэдэггүй. Хүүхэд нас, өсвөр насны хүүхдийн хандлага, зан үйлд үе тэнгийнхэн хүчтэй нөлөөлдөг гэсэн ойлголтод суурилсан үе тэнгийн зуучлалын хөтөлбөр нь харилцааны явцад гарсан зөрчлийг бүтээлч, энэрэнгүй арга замаар шийдэхэд хүүхдүүдийг сургах зорилготой. Үе тэнгийн зөвлөгөө, зуучлал нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилгоор өргөнөөр ашигладаг стратеги юм.

Нотолгоо

Үе тэнгийн зуучлалын хөтөлбөр нь сурагчдад эвлэрүүлэн зуучлах, хэлэлцэн тохирох стратегиудыг зааж сургахүрдүнтэй арга болж болох ба нэг судалгаагаар хүчирхийлэлтэй холбоотойгоор сургуулийн зүгээс сахилгын арга хэмжээ авах явдлыг бууруулсан дүн гарчээ (143). Гэвч үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг бууруулах зорилготой сургуульд түшиглэсэн хөтөлбөрүүдийн үр нөлөөг судалсан өөр нэг системтэй үнэлгээгээр үе тэнгийн зуучлалын үйл ажиллагаа үр нөлөөгүй байсан төдийгүй дээрэлхэлт нэмэгдэхэд хүргэсэн сөрөг үр нөлөө илэрчээ (142, 144). Зарим судалгаанд үе тэнгийн зөвлөгч нар эерэг нөлөө үзүүлж байгааг мэдээлсэн байхад өөр судалгаануудад үе тэнгийн зөвлөгчийн эсрэг өширхлөөс үүдсэн хүчирхийлэл нэмэгдэх эрсдэл ажиглагдсан тухай дурджээ. Нэгтгэн дүгнэх юм бол хөтөлбөрийн үзүүлэх нөлөөний талаар нэгдсэн дүгнэлт хийж чадаагүй байна. Үе тэнгийн зуучлагч, зөвлөгчийн хөтөлбөрийг хүчирхийлэл, түрэмгийллийн түвшин дунд зэрэгтэй орон нутагт голдуу хэрэгжүүлж, үнэлсэн байгаа учраас дүгнэлтүүд нь хүчирхийлэл ихтэй, мансууруулах бодис, согтууруулах ундааны хэрэглээ гэх мэт нэмэлт эрсдэлийн нөлөө ихтэй орон нутагт хамаарахгүй болно.

Үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Үе тэнгийн зуучлалын хөтөлбөр голдуу сургуулиар дамжин хэрэгждэг. Үе тэнгийн зуучлагчийг анги хамт олноороо нэр дэвшүүлэн, жендерийн тэгш байдлыг хангасан баг сонгон бүрдүүлдэг. Сонгогдсон үе тэнгийн зуучлагчид зөрчлийг таньж зохицуулалт хийх, зөвлөгчийн хувьд тэдний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, мөн зөрчлийг өөрсдөө зохицуулж чадахгүй бол тусламж хэрхэн авах талаар 20-25 цагийн сургалтад хамрагдана. Ихэнх хөтөлбөр зөрчлийг зохицуулах ур чадварын сургалтыг бүх сурагчдад хүргэх зорилгоор үндсэн хичээлүүдийн агуулгад интеграцчилан оруулдаг. Бага, дунд орлоготой янз бүрийн улс оронд үе тэнгийн зуучлагчийн хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлага бий.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Үе тэнгийн зуучлал нь өдөр тутмын зөрчлийг зохицуулахад тохиромжтой арга бөгөөд илүү ноцтой асуудал, зан үйлийг зохицуулахад ашиглах ёстой эрчимтэй арга хэмжээг орлож чадахгүй. Хүчирхийлэл ихээр гардаг орчинд үе тэнгийн зуучлагчид өөрсдөө эрсдэлд өртөх магадлалтай. Бага зардлаар цөөн хүний тусламжтай хэрэгжүүлж болох үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөрийг боловсролын салбарын бодлого боловсруулагч, сургуулийн удирдлагууд ихэд дэмждэг. Хөтөлбөр хэрэгжүүлэхийн тулд түүнийг гардан

хэрэгжүүлэх багш, сургуулийн удирдах ажилтнууд, хамрагдах сурагчдын эцэг эх, сурагчид өөрсдөө хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч байх шаардлагатай. Харин сургуулийг сайн ажиллагаатай, амгалан тайван орчин болгох хариуцлагыг сурагчдад өөрсдөд нь шилжүүлж үүрүүлэх нь зөв үү гэж эцэг эх, багш, сурагчид асууж магадгүй.

Зардал

Үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөрийн урьдчилгаа болон урсгал зардал нь үе тэнгийн зуучлагчдыг сургах сургагч багш/хөтөлбөрийн зохицуулагчийн зардал, хөтөлбөрт хамрагдах багшийг шаардлагатай үед орлох нэмэлт багш сургах зардал, мөн сургалтын материал зэргээс бүрддэг. Хөтөлбөрийг сургуулийн төсвөөс (жишээлбэл, багшийн мэргэжил дээшлүүлэх зардлаас) санхүүжүүлдэг. АНУ-д “Үе тэнгийнхэн амар амгаланг бий болгоно” хөтөлбөр хэрэгжүүлэх эхний жилд нэг сургуульд дунджаар 2575- 4075 ам.долларын зардал гарчээ. Хэрэгжилтийн дараагийн жилүүдэд тогтмол хийх гүнзгийрсэн сургалт семинаруудад нэг сургууль дунджаар 1500 ам доллар зарцуулжээ (145).

АНУ: Үе тэнгийн зуучлал

“Үе тэнгийнхэн амар амгаланг бий болгоно” хөтөлбөр нь бага, дунд сургуулийн сурагчдыг хамруулсан сургуульд түшиглэсэн үе тэнгийн зуучлалын хөтөлбөр юм. Хөтөлбөрийн зохицуулалтыг хариуцах үүрэгтэй насанд хүрэгчид буюу багш, сургуулийн сэтгэл зүйч, эмч зэрэг хүмүүс 3 өдрийн сургалтад хамрагдаж, үе тэнгийн зуучлагчаар ажиллах сурагчдыг сургаж бэлтгэх арга зүй эзэмшинэ. Үе тэнгийн зуучлагчид нь анги хамт олноосоо сонгогдсон 15-24 сурагчаас бүрдсэн баг байна. Хөтөлбөрийн зохицуулагч нэг хичээлийн жилдээ тус бүр 3-5 цагийн нийт 3 удаагийн сургалтыг үе тэнгийн зуучлагчдад хийнэ. Сургалтаар үе тэнгийн зуучлагчид бусдад хэрхэн үлгэрлэх, харилцааны явцад үүссэн зөрчлийг хүчирхийлэлгүйгээр шийдвэрлэх чадвар сул үе тэнгийн хүүхдүүддээ эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ хэрхэн үзүүлэх зэрэгт суралцана. Санамсаргүй түүврийн аргаар хөтөлбөрийн оролцогчдыг хяналтын бүлэгтэй харьцуулсан хоёр ч удаагийн үнэлгээгээр хөтөлбөр хэрэгжүүлсэн сургуулийн дүүргүүдэд сахилгын шийтгэл, зодоон, хичээл таслалтын тоо хэмжээ буурсан дүн гарчээ. Хөтөлбөрт оролцогчдын аюулгүй байдлын мэдрэмж, өөрийн чадварт итгэх итгэл, өөрийгөө хүндлэх сэтгэл зэрэг нь хяналтын бүлэгтэй харьцуулахад өссөн дүнтэй гарчээ (145).

Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад үйл ажиллагаа

Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад арга хэмжээ нь өсвөр насны хүүхэд, залуучуудад үе тэнгийн залуустай харилцах, тэднээс төрөл бүрийн ур чадвар сурч авах боломж олгодог. Голдуу хичээлийн дараа үдээс хойш, эсвэл

сургуулийн амралтаар зуны цагт хэрэгждэг ийм үйл ажиллагаанд сайн дурын үндсэн дээр оролцдог. Хөтөлбөрүүд үйл ажиллагааны төрөл, үргэлжлэх хугацаа, зорилтот бүлэг, насанд хүрсэн удирдагчид тавих шаардлага зэргээрээ маш их ялгаатай байдаг.

ХУРААНГУЙ

- Сургууль завсардалт, өсвөр насныхны өдөөсөн хэрэг зөрчил, гэмт хэргийн гаралтад нөлөөлөх байдлыг үнэлсэн.
- Харилцааны ур чадвар хөгжүүлэх сургалт агуулсан зарим стратеги нь хэрэг зөрчлийн гаралт, мөн согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг эрсдэлт хүчин зүйлийг бууруулах нөлөөтэй.
- Бага, дунд орлоготой улс орнуудад хамаарах тодорхой хэмжээний нотолгоо бүрдээд байна.
- Судалгааны ихэнх нь сул аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Чөлөөт цагийн зохион байгуулалттай арга хэмжээ, хичээлийн бус цагийн үйл ажиллагаа нь залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсийг гурван арга замаар бууруулдаг гэж үздэг. Нэгдүгээрт, өдрийн хамгийн эгзэгтэй цагуудад хүүхдэд тавих хараа хяналт нэмэгддэг байна. Өсвөр насны хүүхэд, залуус хараа хяналтгүй байдаг хичээлийн дараах үдээс хойших цагуудад залуучуудын дундах хүчирхийллийн зарим төрлүүдийн гаралт оргил цэгтээ хүрдэг болохыг судалгаагаар тогтоожээ. Хоёрдугаарт, сургуульд түшиглэсэн хөтөлбөрт хамрагдсанаар хүүхдүүд сургуульдаа татагдаж, илүү дуртай болдог. Сургуульдаа дуртай байх нь залуучуудыг хүчирхийллээс хамгаалдаг бас нэг хүчин зүйл билээ. Гуравдугаарт, эдгээр хөтөлбөр нь залуу хүмүүст хүчирхийлэлт зан үйл гаргахаас зайлсхийж сурахад шаардлагатай ур чадвар олгодог байна. Чөлөөт цагийн хөтөлбөрүүдэд ихэвчлэн амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар олгох сургалтууд багтдаг.

Нотолгоо

АНУ-д хэрэгжсэн хичээлээс гадуурх хөтөлбөрүүдэд хийсэн мета шинжилгээгээр хөтөлбөрт хамрагдсан залуусын хувьд хүчирхийллээс хамгаалах нөлөө бүхий сургуульдаа дуртай байх, нийгмийн эерэг зан үйл, сурлагын амжилт зэрэг үзүүлэлт илэрхий сайжирч, сөрөг зан үйл гаргах нь илт буурсан нь харагджээ. Сурлагын амжилтыг дэмжих, нийгмийн харилцааны ур чадвар эзэмшүүлэх бүрэлдэхүүн хэсэг агуулсан хөтөлбөрүүд нь ийм үйл ажиллагаа агуулаагүй бусад хөтөлбөрөөс урьдчилан сэргийлэх нөлөөллөөрөө илүү байжээ (146).

Дээр дурдсан мета шинжилгээнд багтаагүй зарим судалгаанд зохион байгуулалттай чөлөөт цагийн хөтөлбөрийн үр дүнд хүчирхийллийн түвшин хэрхэн өөрчлөгдсөнийг хэмжсэн үзүүлэлт багтжээ. Урт хугацааны өгөгдөл ашигласан нэгэн судалгаагаар

өсвөр насныхны хэрэг зөрчил, хүчирхийлэлт зан үйлийн бууралт 4 жилийн дараа ч хадгалагдаж байсан (147) бол Лос Анжелос хотын “Бэст” хөтөлбөрийн (LA’s Best буюу Лос Анжелос хотын “Шилдэгүүд”) хэд хэдэн удаагийн үнэлгээгээр хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд хэрэг зөрчилд холбогдох магадлал 30 хувиар бага байна гэж дүгнэжээ. Гэтэл зарим үнэлгээ нь хичээлийн бус болон чөлөөт цагийн хөтөлбөрүүдийн сөрөг нөлөөг илрүүлсэн байна. Хичээлийн бус цагийн хөтөлбөрүүд нь ихэнхдээ эдийн засгийн боломж бололцоо муутай эмзэг, ядуу өрхийн хүүхэд, эсвэл зан үйлийн асуудалтай хүүхэд залууст тусгайлан чиглэдэг бөгөөд өндөр эрсдэлтэй залуучуудыг нэг дор цуглуулах нь сөрөг үр дагавар авчирч мэднэ гэж хэд хэдэн судалгаа анхааруулжээ (144).

Хичээлээс гадуур хөтөлбөр, чөлөөт цагийн зохион байгуулалттай арга хэмжээ хэрэгжүүлэх нь

Чөлөөт цагийн зохион байгуулалттай үйл ажиллагаа нь голдуу бүлгээр, эсвэл сурлагын амжилтыг дэмжих зорилготой бол ганцаарчилсан хэлбэрээр хэрэгждэг. Хөтөлбөрийн хүрээнд гэрийн даалгавар хийхэд туслах, давтлага өгөх, компьютер дээр ажиллах зэрэг танин мэдэхүйн болон сурах чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа; дүрслэх урлаг, гар урлал, хоол хийх, спорт гэх мэт амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа; хөгжим, бүжиг, театр зэрэг тайзны болон дүрслэх урлаг; эрүүл мэнд, хоол тэжээл; орон нутгийн иргэд, эцэг эхийн оролцооны арга хэмжээ зэрэг багтдаг байна. Хөтөлбөрийн үйл ажиллагаа ихэвчлэн сургууль, олон нийтийн төв, спортын байгууламж түшиглэн хэрэгждэг. Багш, эцэг эх, сургуулийн нийгмийн ажилтан, сайн дурынхан хяналт тавьж ажиллана.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад арга хэмжээ нь зохион байгуулахад хялбар, ихэнхдээ эерэг туршлага болдог тул бодлого боловсруулагчид, хөтөлбөрт оролцогчид нийтлэгээр дэмждэг. Харин үйл ажиллагаанд оролцохтой холбоотой унаа, хэрэглэгдэхүүний зардал гарахаар ялангуяа төлбөртэй байвал залуус оролцохгүй байх магадлалтай. Зарим хөтөлбөр хүчирхийлэл гарах өндөр эрсдэлтэй орон нутагт хүрч чадахгүй байх, мөн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй залуучуудад хөтөлбөрийн талаар мэдээлэл хүрээгүй учраас идэвх оролцоо сул байх зэрэг асуудал тулгарах магадлалтай. Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн туршлага, сургамжаас үзэхэд оролцогч хүүхэд, залуучуудын нэр хүндийг хамгаалах үүднээс тэднийг “эрсдэлт бүлгийн” гэж нэрлэхээс зайлсхийх нь чухал юм (148).

Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн арга хэмжээнд оролцоход саад болох зүйлс, ялангуяа эдийн засгийн боломж муутай өрхийн юмуу хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй хүүхэд залууст тулгарах саад тотгорыг илрүүлж, арилгахад анхаарах шаардлагатай. Жишээлбэл, арга хэмжээ болох газарт үнэгүй хүргэж, буцааж авах унаа гаргах, үйл ажиллагаанд үнэ төлбөргүй оролцуулах, цаашилбал зууш, хоолоор үйлчлэх зэрэг арга хэмжээ авч болно.

Зардал, үр ашиг

Хөтөлбөрийн зардал нь үйл ажиллагааны төрөл, хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, хэрэгжилтийг хариуцах ажилтнуудад тавигдах мэргэжлийн шаардлага зэргээс хамаарч янз бүр байх ч гол зардал нь үйл ажиллагаанд ашиглах материал, сургалтын хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн ажилтан бэлдэх, ажилтны цалин хөлс зэрэг болно. Хөтөлбөрийн зардал, үр ашгийг тооцоолсон цөөн хэдэн судалгаа байна. Лос Анжелос хотын “Бэст” хөтөлбөрөөс зарцуулсан нэг доллар тутамд 2,5 ам. долларын үр ашиг гарсан байна. Бразил улсад хэрэгжүүлсэн ЮНЕСКО-ийн “Абриндо Эспасос” хөтөлбөр (Abrindo Espaços буюу нээлттэй сургууль) нь нэг жилд нэг сурагчид 12-24 ам.доллар зарцуулжээ (149).

Бразил Улсын залуучуудын хичээлийн бус цагийн хөтөлбөр

Абриндо Эспасос (Нээлттэй сургууль) хөтөлбөрийг ЮНЕСКО, Бразилийн Боловсролын Яам хамтран “Нээлттэй сургууль: залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, ажил хөдөлмөрийн хөтөлбөр” нэртэй бодлогын хүрээнд 2004 оноос хэрэгжүүлжээ. Хөтөлбөр нь амралтын өдрөөр залуучуудад зориулсан спорт, соёл, урлаг, чөлөөт цагийн арга хэмжээ, анхан шатны мэргэжлийн боловсрол олгох сургалтууд зохион байгуулдаг байна. Хөтөлбөрийн дундаж зардал нь нэг сардаа нэг сурагчид 1-2 ам доллар байдаг. Үнэлгээгээр хөтөлбөрт хамрагдсан сургуулиудын дотор болон гадуур орчинд хүчирхийллийн гаралт бусад сургуулиас бага байгаа нь тогтоогджээ. Сан-Паоло хот 2003-2006 онд “Нээлттэй сургууль” хөтөлбөрийг 5306 сургуульд хэрэгжүүлсний дараа гэмт хэрэг 46 хувиар буурчээ. Рио-де-Жанейро хотод “Нээлттэй сургууль” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 12 сарын дараа үнэлгээ хийхэд хөтөлбөрийн сургуулиуд бусад сургуулиас хүчирхийллийн түвшнээр 31 хувиар бага гарсан ч хоёр төрлийн сургуулийн хүчирхийллийн түвшнийг хөтөлбөр эхлэхээс өмнө ямар хэмжээнд байсныг тодорхойлоогүй байжээ (150).

Хүчирхийлэлд холбогдох өндөр эрсдэлтэй, эсвэл хүчирхийлэл үйлдэж байсан залуучуудад чиглэсэн стратеги

Эмчилгээ заслын хөтөлбөр

Уг тоймд түрэмгий зан гаргаж, хүчирхийлэл үйлдэж байсан, эсвэл ийм зан байдал гаргах өндөр эрсдэлтэй залуучуудад хандсан танин мэдэхүй, зан үйлийн, сэтгэл зүй, харилцааны ур чадвар хөгжүүлэх зорилготой эмчилгээ заслын аргуудыг багтаалаа. Эмчилгээ заслын хөтөлбөрүүд нь ганцаарчилсан юмуу бүлгийн зохион байгуулалттай байх ба залуучуудын нийгмийн хүрээлэл, гэр бүлийг нь давхар хамруулах боломжтой. Хөтөлбөрийн үйл ажиллагааг мэргэшсэн засалч, нийгмийн ажилтан, заримдаа сургалтад хамрагдсан сайн дурынхан хэрэгжүүлдэг.

ХУРААНГУЙ

- Нийгмийн эсрэг зан үйл, хүчирхийлэл, давтан гэмт хэргийн гаралтад үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Эмчилгээ заслын зарим хөтөлбөр (жишээлбэл, танин мэдэхүй, зан үйлийн засал) нь нийгмийн эсрэг зан үйл, хүчирхийлэл, давтан гэмт хэргийг бууруулах нөлөөтэй.
- Зөвхөн өндөр хөгжилтэй улс орнуудад хамаатай нотолгоо бүрдсэн.
- Судалгааны ихэнх нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Эмчилгээ заслын зарим аргачлал нь залуу хүний түрэмгий, хүчирхийлэлт зан үйлийн нэг бус, хэд хэдэн шалтгааныг түүний орчин тойрныг бүрдүүлж байгаа янз бүрийн систем (жишээлбэл, гэр бүл ба үе тэнгийнхний харилцаа, сургууль дээрх нөхцөл байдал, амьдарч буй орон нутаг)-тэй холбон ойлгохыг хичээж, хүчирхийлэл үйлдэх, түрэмгийн зан гаргахад хүргэх магадлалтай эрсдэлт хүчин зүйлсийг эдгээр орчин нөхцөл, харилцаа холбооноос илрүүлэн, шийдэхэд туслах хандлагад суурилсан байдаг. Эмчилгээ заслын өөр аргачлалууд нь залуу хүмүүст сөрөг үйлдэл гаргахад хүргэсэн ойлголт хандлага, логикоо таньж ойлгон, өөрчлөн зохицуулах замаар амьдралдаа тохиолдох аливаа асуудлыг илүү үр бүтээлтэй шийдвэрлэж сурахад нь туслах хандлагаар боловсруулагдсан байдаг.

Нотолгоо

Эмчилгээ заслын сэтгэлзүйн, мөн нийгмийн эерэг зан үйл төлөвшүүлэх боловсролын, нийгмийн харилцааны гээд янз бүрийн хөтөлбөрүүд хүчирхийлэл, ноцтой гэмт хэрэг үйлдэн ял эдэлсэн залуучуудыг давтан гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэхэд хэрхэн нөлөөлж байгааг судалсан нэг тойм шинжилгээ байна (151). Энэ шинжилгээнд Канад, Их Британи, АНУ-д баривчлагдсан 6600 гаруй насанд хүрээгүйчүүдийн мэдээллийг агуулсан 30 судалгааг авч үзжээ. Шинжилгээний дүнгээр, эмчилгээ заслын үйлчилгээ нь нийт дүнгээрээ насанд хүрээгүйчүүдийн давтан гэмт хэргийг 60 хувиас 56 хувь хүртэл буулгахад нөлөө үзүүлжээ. Танин мэдэхүйн эмчилгээ заслын хөтөлбөрүүд хамгийн их үр нөлөөтэй байв. Зөвхөн боловсролын юмуу сурлагын амжилтад төвлөрсөн, эсвэл эерэг үлгэр дуурайллаар зан үйлийн өөрчлөлт гаргах зорилготой хөтөлбөрүүд төдийлөн амжилтад хүрээгүй байна. Зөвхөн танин мэдэхүйн зан үйлийн заслын хөтөлбөрүүдийг сонгон авч хийсэн системтэй тойм шинжилгээгээр (152) хөтөлбөр хэрэгжсэнээс хойш нэг жилийн дараа насанд хүрээгүйчүүдийн давтан гэмт хэрэг 25 хувиар буурсан дүн гарчээ.

Түрэмгий зан ааш гаргадаг хүүхдүүдэд чиглэсэн танин мэдэхүйн зан үйлийн заслын хөтөлбөрүүдэд хийсэн мета шинжилгээгээр ийм хөтөлбөр дүүргэсэн хүүхдүүд түрэмгий болон нийгмийн эсрэг зан үйл, сахилгын зөрчил гаргах нь эрс багассаныг илрүүлжээ (153). Эмчилгээ заслын бусад хөтөлбөрүүд ч танин мэдэхүйн зан үйлийн арга, аргачлалыг ашигладаг бөгөөд зан үйлийн зөрчилтэй залуу хүмүүстэй ажиллахдаа тэдний нийгмийн

хүрээллийг бас хамруулах хэрэгтэй. Жишээлбэл, Гэр бүлийн функционал засал (Functional Family Therapy), Олон системийн засал (Multiple-Systemic Therapy) зэрэг хөтөлбөрүүд ийм хандлага баримталдаг. Гэр бүлийн функционал заслын хөтөлбөрүүд нь насанд хүрээгүйчүүдийг давтан гэмт хэргээс сэргийлэх багаас дунд зэргийн нөлөөтэй байгааг мета шинжилгээгээр тогтоожээ (154). Олон системт засал нь гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэн баривчлагдах, ял авах тохиолдлыг хоёр дахин бууруулах нөлөөтэй болохыг чанарын судалгаагаар илрүүлсэн байна (94). Урт хугацааны мэдээлэлд суурилсан зарим судалгаа нь эмчилгээ заслын хөтөлбөрүүд хэрэгжсэнээс хойш 21 жилийн туршид эерэг нөлөөлөл нь хадгалагдаж байдаг гэсэн дүгнэлт хийжээ.

Өндөр эрсдэлт бүлгийн залуусыг эмчилгээ заслын хөтөлбөрт хамруулах нь

Заслын хөтөлбөрүүд дунджаар 10-20 долоо хоног үргэлжилдэг. Заслын үйлчилгээг бие даасан хөтөлбөр хэлбэрээр, эсвэл томоохон хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар хэрэгжүүлж болох ба ихэнх хөтөлбөр стандартчилсан материал, гарын авлага ашигладаг. Заслын үйлчилгээг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эсвэл эмчилгээ заслаар мэргэшсэн нийгмийн ажилтан үзүүлнэ. Ихэнх хөтөлбөр өндөр түвшний мэргэжлийн боловсрол, туршлагатай удирдагч/зөвлөхтэй байдаг ба зөвлөх нь хөтөлбөрийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Эмчилгээ заслын хөтөлбөрийн агуулгыг залуу хүний онцлог хэрэгцээнд нийцүүлэн өөрчилдөг ч дийлэнхдээ нийгмийн харилцааны ур чадвар ба зан үйлийн сургалт; уур уцаараа хянах болон өөрийгөө хянах аргууд; мөн хохирогчийн зовлон шаналлыг ойлгуулж, мэдрүүлэх зорилгоор ёс суртахууны үндэслэл, бусдын байр суурийг ойлгох зэрэг танин мэдэхүйн ур чадвар хөгжүүлэх дасгал зэргийг хослуулсан агуулгатай байдаг. Зарим хөтөлбөр хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй залуусын гэр бүл, нийгмийн сүлжээнд ихээхэн анхаарсан дизайнтай байдаг.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Бодлого боловсруулагчид хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй залуу хүмүүсийн асуудалд анхаарал хандуулж, эерэг хөгжлийн зам руу шилжихэд нь туслах ёстой гэсэн хүсэлт, шаардлага их гардаг. Янз бүрийн улс оронд хэрэгжсэн эмчилгээ заслын хөтөлбөрүүд нь завсардалт багатай байгаагаас харахад ийм хөтөлбөрийг хүмүүс өргөнөөр хүлээн зөвшөөрдөг бололтой (155). Гэвч сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ хүрэлцээгүй, мэргэжилтэн дутагдалтай нөхцөлд ийм хөтөлбөр хэрэгжүүлэх боломжгүй болно.

Зардал

Өртөг багатай эмчилгээ заслын хөтөлбөр байхгүй байгаа нь энэ үйлчилгээний хүртээмжийг хязгаарлаж байгаа гол асуудал юм. Заслын хөтөлбөр хэрэгжүүлэхэд өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтнүүд цагаар ажиллаж, залуучууд, тэдний гэр бүлд тогтмол зөвлөгөө тусламж үзүүлэх боломжтой байх шаардлагатай. Жишээлбэл, Их Британид “Логик сэтгэлгээ, сэргээн засал” хөтөлбөр хэрэгжүүлэхэд хэрэг зөрчил гаргасан насанд хүрээгүй нэг хүнд 121 фунт стерлинг, насанд хүрсэн нэг хүнд 637 фунт стерлинг зарцуулжээ (154).

Логик сэтгэлгээ, сэргээн заслын олон улсын хөтөлбөр

Хүчирхийлэлд холбогдох эрсдэлтэй залуучууд, насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд чиглэсэн олон бүрдэлт “Логик сэтгэлгээ, сэргээн засал” хөтөлбөр нь зан үйлийн эерэг сонголт хийж заншихад нь тус болох танин мэдэхүйн ур чадваруудыг хөгжүүлэх зорилготой бөгөөд 20 улсад хэрэгжиж байна. Хөтөлбөр нь 6-12 хүнтэй бүлгээр долоо хоног бүр 2-4 удаа 2 цагаар хичээллэх нийт 36 удаагийн сургалтаас бүрдэнэ. Сургалтад нийгмийн харилцааны ур чадвар, зөвшилцөх чадвар, сэтгэл хөдлөлийн хяналт зохицуулалт, үнэт зүйл ба шүүмжлэлт үндэслэл гаргах ур чадвар хөгжүүлэх зорилгоор дүрд тоглох, сэтгэн бодох, суралцах тоглоом, дасгалуудыг ашигладаг (156). Анх Канадад боловсруулан хэрэгжүүлсэн уг хөтөлбөр 20 улсад хэрэгжсэнээс Финлянд, Герман, Исланд, Иран, Их Британи улсуудад хөтөлбөрийн үнэлгээ хийгджээ. Мета шинжилгээгээр хөтөлбөрт оролцогчдын дунд давтан гэмт хэрэг 14 хувиар буурсан дүн гарчээ. Хөтөлбөрийн үнэлгээнүүдийн зарим нь л хүчирхийллийг бууруулах асуудлыг авч үзсэн байх ба Канадад хөтөлбөрт оролцогчдын дунд хүчирхийлэлт гэмт хэрэг дахин үйлдсэний улмаас баривчлагдах магадлал 49 хувиар буурсан тооцоо гарчээ (157).

Мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр

Мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь эмзэг бүлгийн залуучуудад техник мэргэжлийн, худалдаа арилжааны, менежментийн мэдлэг, чадвар олгох зорилготой ба зарим хөтөлбөр нь өөртөө ажлын байр бий болгох, бичил үйлдвэрлэл эрхлэх талаар зөвлөгөө өгдөг.

ХУРААНГУЙ

- Залуучуудын дундах ажилгүйдэл, хүчирхийлэл, түрэмгий зан үйлд үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Сургалтууд нь хөдөлмөрийн зах зээл дээрх өнөөгийн эрэлт, ажлын байрны боломжтой сайтар уялдсан байх юм бол мэргэжлийн сургалт нь залуучуудыг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйл болсон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Гэхдээ мэргэжлийн сургалтын хөтөлбөр хүчирхийллийг бууруулах шууд нөлөөтэй нь батлагдаагүй.
- Бага болон дунд орлоготой зарим улсад хамаарах нотолгоо бүрдээд байна.
- Судалгааны ихэнх нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой уялдах нь

Ажил олж чадахгүй, эсвэл олсон ажлаа хадгалж чадахгүй байгаа залуучууд гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэх, согтууруулах болон мансууруулах бодист донтох зэрэгт илүү өртөмтгий байдаг ажээ. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт бол хүчирхийллээс хамгаалдаг хүчин зүйл юм. Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг олон улс оронд залуучуудын дундах ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндсэн зорилготойгоор хэрэгжүүлдэг.

Нотолгоо

Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг залуучуудын дундах хүчирхийллийг бууруулах зорилттой уялдуулан үнэлсэн хэд хэдэн судалгаа байдаг ч ихэнх нь хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй, эсвэл эрүүгийн эрх зүйн системийн хараанд хэдийнээ орсон залуучуудад хамаатайгаар авч үзжээ. Чанарын хувьд илүү гэж үздэг санамсаргүй түүврийн судалгаанууд (158, 159) нь мэргэжлийн сургалтууд түрэмгий, хүчирхийлэлт зан үйлийг бууруулж чадахгүй байна гэж дүгнэсэн байхад чанараар арай сулд тооцогдох ажиглалтын судалгаануудад (160) багаас дунд зэргийн үр нөлөө тэмдэглэгджээ. Хүчирхийлэл үйлдэх эрсдэлийн улмаас цагдаагийн хараа хяналтад байгаа залуучуудад ажил мэргэжлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зөвлөгөө өгөх зорилтот дэмжлэгийн хөтөлбөрүүд нь гэмт хэрэг үйлдэн баривчлагдах явдалд хэрхэн нөлөөлж байгааг судалсан системтэй тойм шинжилгээгээр холимог үр дүн илэрчээ (161). Тиймээс мэргэжлийн сургалтын хөтөлбөр хүчирхийллийг бууруулахад нөлөөлж чадах эсэхийг судалж тогтоох шаардлагатай байна.

Мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Мэргэжлийн сургалт нь эрэлтэд нийцсэн буюу хөтөлбөрөөр олгох ур чадварууд нь хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад зохицсон байх ёстой. Улс орны эдийн засгийн хөгжлийн бодлого, ажлын байр бий болгох стратегийн зорилго, чиглэлтэй уялдсан мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хүчирхийллийг бууруулахад эерэг нөлөө үзүүлж чадна. Тиймээс хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй залууст чиглэсэн мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх эсэхээ шийдэх гэж байгаа бол сургалтын байгууллагын хүчин чадал, ашиглаж болох техник, тоног төхөөрөмжийн бааз, хувийн салбартай хамтран ажиллах боломж, тогтвортой санхүүжилтийн боломжууд зэргээ үнэлж үзэх шаардлагатай.

Мэргэжлийн сургалтын хөтөлбөр олон улс оронд хэрэгждэг бөгөөд бага, дунд орлоготой улс орны туршлага нэлээд байгаагаас жишээ болгож Самоа Улсын “Эмзэг бүлгийн орлого багатай залууст боломж олгох нь” хөтөлбөр, Филиппин Улсын “Ажилчин залуусын төв” хөтөлбөрийг нэрлэж болно (162).

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд нь завсардалт өндөртэй ч хүлээн зөвшөөрөгдөх байдал нь мөн өндөр байдаг. Хэрвээ хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцээгүй, сургалтаа дуусгаад ажил олох бодит боломжгүй бол мэргэжлийн сургалтад хамрагдсан залуучуудын урам хугарах, төрд итгэх итгэл буурах үр дагавар гарч мэднэ.

Зардал

Мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд нь зардлын хувьд янз бүр байдаг. Хөтөлбөрийн хугацаанд суралцагчид бага цалин, мөн мэргэжилгүй ажилчны хувиар олж болдог байсан боломжит орлогын алдагдал зэргийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болох бол ажил олгогч нь цалин, хөдөлмөрийн хөлс төлөхийн зэрэгцээ туршлагатай ажилтныг хөтөлбөрийн удирдагчаар ажиллуулах зохицуулалт хийх хэрэгтэй болно. Сургалтын төвд хэрэгжих хөтөлбөрийн зардалд сургалтын материал, тусгай хувцас, багшийн цалин, захиргааны зардал багтана. Төр засаг мэргэжлийн сургалтын байгууллагуудад төсвөөс татаас олгох, эсвэл ажил олгогчтой концессын гэрээ хийх замаар мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдээ санхүүжүүлэх шаардлагатай болдог. Чили Улс залуучуудын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх зорилгоор олон хөтөлбөр хэрэгжүүлсэн ба “Чили Жовен” (Chili Joven буюу залуу Чили) сургалтын хөтөлбөр 11 жилийн туршид 107 сая ам. доллараар 165.000 хүнийг (1 хүнд 648 ам.доллар) сургажээ (163).

Залуучуудын мэргэжлийн сургалтын хөтөлбөр Аргентин, Чили, Доминиканы Бүгд Найрамдах Улсад

“Залуус” (Jóvenes) хөтөлбөр бол эмзэг бүлгийн залуучуудад ажлын туршлагатай болох боломж олгон, ажил хайхад нь тусалж, зөвлөгөө өгч, амьдрах ухааны ур чадварт сургадаг хөтөлбөр юм. Уг хөтөлбөр анх Чилид эхэлсэн ба улмаар Аргентин, Доминиканы Бүгд Найрамдах Улс авч хэрэгжүүлээд байна. Хөтөлбөрийн үнэлгээгээр оролцогчид нь хяналтын бүлгийнхэнтэй харьцуулахад ажил олох илүү өндөр магадлалтай, яваандаа илүү өндөр цалин авч байсан дүн гарчээ. Улс орон, оролцогчийн нас, хүйсээс хамааран хөдөлмөр эрхлэлтийн түвшин 10 хувь байснаас 26 хувь болж нэмэгдсэн байв. Ерөнхийдөө насаар залуу, мөн эмэгтэй оролцогчид ажилд орох илүү магадлалтай байжээ (162). Хөтөлбөр нь залуучуудыг хүчирхийллээс хамгаалах нөлөө үзүүлж байгаа эсэхийг одоогоор үнэлж үзээгүй байна.

Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр

Зөвлөн дэмжих менторын ажил гэж арвин туршлагатай хүн өөрийн мэдлэг, туршлага, мэдээлэл, үзэл бодлоо хуваалцах замаар залуу хүний эерэг хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой түншлэлийг хэлдэг (164). Менторын зарим хөтөлбөр хүүхдийн сурлагын амжилтыг ахиулах, эсвэл хүчирхийллээс сэргийлэх гэх мэт тодорхой зорилт дэвшүүлэн ажилладаг бол зарим нь хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлж, эрсдэлт хүчин зүйлсийг багасгах чиглэлийг баримтлан өсвөр насны хүүхэд, залуу хүмүүсийн эрүүл, эерэг хөгжлийг дэмжих ерөнхий зорилгын хүрээнд ажилладаг.

ХУРААНГУЙ

- Түрэмгий зан үйл гаргах, хэрэг зөрчилд холбогдох байдалд үзүүлэх нөлөөг судалсан.
- Зөвлөн дэмжих менторын хөтөлбөрийн үр дүн нотлогдоогүй байгаа ба хэд хэдэн системтэй тойм шинжилгээний дүгнэлт хоорондоо зөрчилдөөд зогсохгүй зарим нь бүр сөрөг нөлөөлөл илрүүлсэн.
- Зөвхөн өндөр орлоготой цөөхөн хэдэн улсад хамаатай нотолгоо бүрдсэн.
- Цөөн хэдхэн судалгаа л сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой уялдах нь

Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр нь хүчирхийлэлд холбогдох, сургууль завсардах эрсдэлтэй, зан үйлийн асуудал гаргадаг боловч өөрийнх нь орчин хүрээлэлд эерэг үлгэр дуурайлал болох, зөвлөгөө чиглүүлэг өгөх хүн дутагддаг хүүхэд залууст чиглэсэн үйлчилгээ юм. Зөвлөгч болон зөвлүүлэгчийн хоорондын харилцаанаас хүүхэд, залуус нийгмийн амьдралд хэрэгтэй мэдлэг, туршлага олж авдаг ба зөвлөн дэмжигч нь хүүхдийн өдөр тутмын амьдралд тохиолдох асуудлыг зохицуулах, зөрчлийг шийдэх хувилбарт аргуудыг хүүхдэд зааж өгч чадна гэж Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр үздэг байна.

Үр нөлөө

Залуучуудыг ноцтой хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд Зөвлөн дэмжих менторын хөтөлбөрийн үзүүлэх үр нөлөөг судалсан судалгаа алга байна. Харин АНУ-д хийсэн мета түвшний болон системтэй шинжилгээнүүд нь энэ төрлийн хөтөлбөр түрэмгий зан үйл, хэрэг зөрчлийн гаралтад дунд зэргийн эерэг нөлөөтэй байгааг тогтоожээ. Гэхдээ хөтөлбөрүүдийн хоорондын ялгаа их ба зарим судалгаагаар хөтөлбөрийн сөрөг үр дагаврууд илэрсэн байна. Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр нь зөвлөгч, зөвлүүлэгчийн хооронд тогтсон харилцаанаас бүрэн хамаардаг тул стандартчилах боломжгүйн дээр үйл ажиллагааг нь тайлбарлан баримтжуулахад хэцүү байдаг. Тиймээс үнэлгээ, судалгааны үр дүнг тайлбарлахдаа болгоомжтой хандах хэрэгтэй (164). Зөвлөн дэмжих зарим хөтөлбөр залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсэд нөлөөлж байгаа нь нотлогдсон байна. Жишээлбэл, АНУ-ын “Том ах, том эгч” (Big Brothers, Big Sisters) хөтөлбөр нь мансууруулах бодис хэрэглэж эхлэх явдлыг 46 хувиар, архи хэрэглэж эхлэх явдлыг 27 хувиар бууруулахын зэрэгцээ хичээлийн ирц, эцэг эх, хүүхдийн харилцаа, сургууль дээрх үйл ажиллагаанд оролцох оролцоо зэрэг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлс сайжрахад нөлөөлжээ (165).

Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр нь зорилтот бүлгээ тодорхойлохоос эхлэх ба хэрэг зөрчилд холбогдсон, сургуулиа хаясан, хүчирхийлэл гэх мэт нийгмийн хэм хэмжээний эсрэг зан үйл гаргадаг, эсвэл энэ бүхнийг хийх өндөр эрсдэлтэй залуу хүмүүст чиглэдэг. Хөтөлбөрийн оролцогчдыг тодорхойлж авсны дараа сайн дураар зөвлөн дэмжигчээр ажиллах хүмүүсийг элсүүлнэ. Зөвлөн дэмжих хөтөлбөрийн амжилт ололт нь зөвлөгч элсүүлэх үйл явц, зөвлөгчөөр ажиллах хүний нөөцийн чанар, ур чадвараас ихээхэн хамаарна. “Том ах, том эгч” хөтөлбөр нь зөвлөхөөр ажиллах хүсэлтэй хүмүүсийн мэдээллийг нягтлан шалгаж, өөрийг нь тодорхойлсон захидал авч, бас ярилцлага авдаг (166). Зөвлөгч болон зөвлүүлэгч нь ихэвчлэн ижил хүйсийн хүмүүс байна. Ихэнх хөтөлбөр нь зөвлөгчөөр ажиллах хүмүүсийг сургалтад хамруулж, хүүхэд залуучуудын хөгжлийн тухай, мөн харилцаа холбоо тогтоох, асуудал шийдвэрлэх аргууд, залуу хүмүүстэй хэрхэн харьцах зэрэг ерөнхий сэдвээс гадна архи, мансууруулах бодисын хэрэглээг зохицуулах гэх мэт илүү нарийн асуудлаар мэдлэг, мэдээлэл олгодог.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр нь сайн дурын оролцоонд тулгуурласан, оролцогчдын өргөн дэмжлэгийг хүлээсэн хөтөлбөр юм. Гэхдээ голдуу сайн дурын зөвлөгчдөөр дамжуулан үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг тул цалинтай ажил эрхлэх эрмэлзэл давамгайлдаг бага, дунд орлоготой улс орнуудад хэрэгжүүлэхэд хүндрэл гардаг. Бодлого боловсруулагчид хөтөлбөрийг хэр дэмжих нь хөтөлбөрийн зардлаас хамаардаг.

Зардал

Тодорхой хөтөлбөр бүрт багтах үйл ажиллагаа, арга хэмжээ нь бусад хөтөлбөрөөс их ялгаатай байдаг тул хөтөлбөрүүдийн дундаж зардлыг тооцоолох боломжгүй. Зарим хөтөлбөр сайн дурынханд түшиглэн ажилладаг тул зөвхөн захиргааны ба харилцаа холбооны зардал шаардах бол бусад хөтөлбөр нь захиргаа, зохион байгуулалтыг бүхлээр нь хариуцах гүйцэтгэгч байгууллага хөлсөлж авдаг. АНУ-ын “Том ах, том эгч” хөтөлбөр нь нэг зөвлүүлэгчид дунджаар 1312 доллар зарцуулдаг байна (167). Хөтөлбөрийн гол зардал нь зөвлөн дэмжигчээр ажиллах хүмүүсийг элсүүлж сургах, мөн зөвлөгч, зөвлүүлэгчийг хооронд нь тохируулан сонгохтой холбоотой гардаг.

“Том ах, том эгч” зөвлөн дэмжих хөтөлбөр

“Том ах, том эгч” хөтөлбөр нь өнөөдрийн байдлаар Бермуд, Болгар, Израиль, Оросын Холбооны Улс, Баруун Европ, Хойд Америкийн хэд хэдэн орон зэрэг 12 улсад хэрэгжиж байна. Хөтөлбөр нь зөвлөгч, зөвлүүлэгчийн хооронд дэмжин туслах чин хүсэлд суурилсан халамжит, энэрэнгүй харилцаа бий болно гэсэн хүлээлтээр насанд хүрсэн сайн дурын зөвлөгчийг өсвөр насны зөвлүүлэгч хүүхэдтэй тохируулан сонгон ажиллуулдаг. Тохируулах сонголтууд хийгдсэний дараа мэргэжлийн бэлтгэл хангасан хөтөлбөрийн ажилтан тэдний харилцаа, хамтын ажиллагаанд мониторинг хийн, хянаж ажиллана. Нэг зөвлөгч нэг л хүүхэдтэй ажиллах ба нэг жил юмуу түүнээс урт хугацааны туршид долоо хоногт 3-5 цагийн ганцаарчилсан уулзалт хийдэг. Зорилтуудаа зөвлөн дэмжих харилцаа эхлэх үед хүүхэд, түүний эцэг эх, зөвлөгч хамтран тодорхойлох ба асуудалтай зан үйл, хичээл таслалт, сурлагын амжилт, бусад хүүхэдтэй холбоо харилцаа тогтоох зэрэг асуудлаар, эсвэл шинэ ур чадварт суралцах зэрэг байх жишээтэй. Тодорхой кейсд хяналт тавих үүрэгтэй кейс менежер нь зөвлөгч, зөвлүүлэгчтэй байнгын холбоотой байж, харилцаа хэрхэн хөгжиж байгааг тогтмол ажиглаж үнэлнэ. Тус хөтөлбөр нь согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, бие махбодын хүчирхийлэл, хичээл таслалтыг бууруулах, хүүхэд, эцэг эхийн харилцааны чанарыг сайжруулах нөлөө үзүүлж байгаа нь нотлогдоод байна (94).

Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллээс сэргийлэх хөтөлбөр

Гэмт бүлэглэлийн хүчирхийлэл гэдэг нь удаан хугацааны түүхтэй, хууль бус үйл ажиллагаанд оролцдог нэр, имижтэй гудамжны/зэвсэглэсэн бүлэглэл, эсвэл ийм бүлэглэлтэй холбоотой гэж өөрийгөө тодорхойлдог хувь хүн юмуу бүлгийн зүгээс зорилготойгоор хүчирхийлэл үйлдэхийг хэлнэ. Гэмт бүлэглэлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь эн тэргүүнд залуучуудыг гэмт бүлэглэлд элсэн орохоос сэргийлэх, цаашилбал, гэмт бүлэглэлийн гишүүн залууст гэмт бүлэглэлээс хөндийрөхөд нь туслах, ер нь гэмт бүлэглэлийн аливаа үйл ажиллагааг таслан зогсоох зорилготой (168-170). Гудамжны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь гэмт бүлэглэлд элсэх явдал, гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсооход тусгайлан анхаардаггүй ч гудамжинд үйлдэгддэг буудалцаан, хүн амины хэрэг зэрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд чиглэдэг.

ХУРААНГУЙ

- Гэмт бүлэглэлийн гишүүн залуучуудын үйлдсэн гэмт хэргийн гаралт, мөн залуу хүмүүсийг гэмт бүлэглэлд элсэхээс сэргийлж, гэмт бүлэглэлээс хөндийрөхөд нь туслах, гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг бүхэлд нь таслан зогсоох чиглэлээр хөтөлбөрийн нөлөөг үнэлсэн.

- Залуучуудыг гэмт бүлэглэлд элсэхээс сэргийлэх, гэмт бүлэглэлээс хөндийрүүлэх, мөн гэмт бүлэглэлийг устгах зэрэгт хөтөлбөр нөлөөлж буй эсэхийг батлах нотолгоо хангалтгүй байна.
- Гэмт бүлэглэлд элсэхээс сэргийлэхтэй холбоотой зарим нэг нотолгоо бий болсон.
- Зөвхөн өндөр хөгжилтэй улс орнуудад хамаатай нотолгоо бүрдээд байна.
- Судалгааны ихэнх нь сул аргачлалтай

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой уялдах нь

Гэмт бүлэглэлд элссэн залуучууд хэрэг зөрчил гаргах, ноцтой гэмт хэрэгт холбогдох нь бүлэглэлийн гишүүн бус залуучуудаас илүү байгааг эрсдэлт хүчин зүйлсийн судалгаагаар тогтоожээ (168). Дэлхийн өнцөг булан бүрт янз бүрийн цар хүрээтэй оршоор байгаа гэмт бүлэглэл, түүнтэй холбоотой хүчирхийллийн асуудал улс төрчдийн анхаарлыг ихээр татдаг.

Үр нөлөө

Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн агуулга хоорондоо маш их ялгаатай байдаг тул үнэлгээ хийхэд хүндрэл гардаг. Хэд хэдэн судалгаагаар ийм төрлийн хөтөлбөр нь гэмт бүлэглэлийн үйлдэх хүчирхийллийг бууруулах эерэг нөлөө үзүүлсэн үр дүн гарсан ч судалгаануудыг нэгтгэн тоймлоход уг үр дүнг батлах нотолгоо сул байгаа нь ажиглагдана. Есөн судалгааны тайланд туссан гэмт бүлэглэлтэй холбоотой хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай мэдээллийг системтэй тоймлон, мета түвшний дүн шинжилгээ хийхэд цогц хөтөлбөрүүд нь гэмт хэргийг бууруулахад эерэг ч гэлээ статистикийн ач холбогдолтой байж чадахааргүй багахан нөлөө үзүүлж байгаа нь харагджээ (170). Кейс бүрийг хариуцах хүнтэй болгож ганцаарчилж анхаарал тавих, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд орон нутгийн иргэдийг татан оролцуулах, гэмт хэргийн шинжтэй зан үйлээ өөрчилбөл гэмт бүлэглэлийн гишүүдэд урамшуулал өгөх зэрэг арга хэмжээг багтаасан цогц хөтөлбөрүүд нь эдгээр арга хэмжээг багтаагаагүй хөтөлбөрүүдээс илүү үр нөлөөтэй байх магадлалтай байна гэж дээрх тойм судалгаанд дурджээ.

Хоёр дахь тойм шинжилгээ (171) нь хүүхэд залуучуудыг гэмт бүлэглэлд элсэхээс сэргийлэх, бүлэглэлээс гарахад нь туслах, мөн гэмт бүлгээр хүчирхийлэл үйлдэх явдлыг таслан зогсоох зорилтын хэрэгжилтэд төвлөрчээ. Энэ судалгаагаар тодорхой нэг стратеги, нэг эрсдэлт хүчин зүйлд чиглэсэн хөтөлбөртэй харьцуулахад цогц стратегиар хүүхдийг багаас нь анхаарсан хөтөлбөрүүд илүү үр дүнтэй болох нь харагджээ.

Гурав дахь системтэй тойм судалгааг 7-16 насныхныг гэмт бүлэглэлтэй холбогдохоос хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн зан үйл, танин мэдэхүйн хөтөлбөрүүдэд үнэлгээ хийхээр эхлүүлсэн боловч эдгээр нөхцөлийг хангасан судалгаа олдоогүй байна (172). Улмаар нотолгооны энэ хоосон орон зайг нөхөж, зан үйл, танин мэдэхүйн хөтөлбөрүүд

залуучуудыг гэмт бүлэглэлтэй холбогдохоос хамгаалах үр нөлөөтэй арга зам мөн үү гэдгийг судлан тогтоох шаардлагатай байна.

Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зорилго нь гэмт бүлэглэлийн үйл ажиллагааны мөн чанар, бүлэглэлийн бүтэц, зохион байгуулалт хэр бат бөх байгаагаас ихээхэн хамаарна. Нөхцөл байдлаас хамааран гэмт бүлэглэлд элсэхээс хамгаалах, эсвэл гэмт бүлэглэлээс гарахад туслах, бүлэглэлийн үйл ажиллагааг бүхэлд нь таслах, эсвэл дээрх гурван асуудалд нэгэн зэрэг анхаарсан хөтөлбөр байх уу гэдгийг шийдэх хэрэгтэй болно. Энэ орон нутаг гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллийг тэвчихгүй, тууштай тэмцэнэ гэдгийг ойлгуулахын тулд орон нутгийн иргэд, ялангуяа манлайлагчдыг хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах арга механизмууд ихэнх урьдчилан сэргийлэх хөтөлбөрт багтсан байдаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах эсэх нь тухайн хөтөлбөрөөс хамаарна. Гэмт бүлэглэл, гудамжны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ихэнх хөтөлбөр гэмт бүлэглэлийн гишүүн залууст хүчирхийллээс өөр шийдэл олоход туслах зорилгоор техник мэргэжлийн юмуу хувь хүний хөгжлийн сургалтын хөтөлбөр нэмж хэрэгжүүлдэг.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Гэмт бүлэглэлтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээг улс төрчид, олон нийт дэмжин хүлээж авдаг. Харин гэмт бүлэглэлийн гишүүд, гишүүн болох эрсдэлтэй залуучууд өөрсдөө ийм хөтөлбөрийг хэрхэн хүлээж авдаг талаар мэдээлэл тун бага байна. Хүмүүжлийн тусгай сургууль, насанд хүрээгүйчүүдийн хорих газар, цэргийн маягийн зуслан зэрэг газарт байсан 3348 залуу (үүнээс 1994 нь гэмт бүлэглэлд харьяалагддаг гэдгээ хүлээн зөвшөөрсөн)-г хамруулсан түүврийн судалгаа (173), мөн гэмт бүлэглэлд элсэх эрсдэлтэй 1000 гаруй залууг түүвэрлэн хамруулсан өөр нэг судалгааны (174) дүгнэлтийг авч үзье. АНУ-д хийсэн уг хоёр судалгаанд оролцогчдын 50 хувь нь гэмт бүлэглэлийн асуудлыг ажил хөдөлмөрт бэлдэх сургалт, хөдөлмөр эрхлэлтээр шийдэж болно гэж үзжээ. АНУ-ын Колорадо, Флорида, Охайо мужийн гэмт бүлэглэлтэй холбоотой 200 орчим залууг хамруулсан өөр нэг судалгаанд оролцогчдын ихэнх нь цагт 15 ам.доллараас бага хөлстэй ажлын төлөө мансууруулах бодис худалдаалах үйлдлээ зогсоохгүй (177) гэсэн бол 25 хувь нь хэвийн ажлын цагтай, байнгын ажлын байр байх юм бол цагийн 6-7 ам.долларын цалин хөлстэй ч хамаагүй ажил хийж, хууль бус үйл ажиллагаанаас татгалзана гэжээ.

Гэмт бүлэглэл, түүнтэй холбоотой хүчирхийлэлтэй тэмцэхэд Төв Америкт алдартай “мано дура” (mano dura буюу хатуу гар/төмөр нударга) бодлогыг ашигласан жишээ бий. Уг бодлого хэрэгжиж эхэлснээр гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдах явдал огцом нэмэгдсэн байна. Төрөөс явуулсан энэхүү хатуу ширүүн бодлогын хариуд гэмт бүлэглэлүүд харин ч улам нягтарч нэгдэх хандлага үүсэж, олон газар хүчирхийлэл нэмэгдэхэд түлхэц болсон байдаг (176).

Зардал

Гэмт бүлэглэлээр үйлдэх хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зардлын талаар мэдээлэл маш бага байна. Дээр дурдсан тойм шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан хөтөлбөрүүдийн алинд нь ч зардал, үр ашгийн тооцоо хийгдээгүй байна.

Гэмт бүлэглэлээс гарахад нь залууст туслах Никарагуа Улсын жишээ

Никарагуа Улсын Манагуа хотод хэрэгжүүлсэн “Хабитат” (Habitat буюу амьдрах орчин) төсөл нь гэмт бүлэглэлийн гишүүн залуучуудад эерэг хөгжлийн боломжуудыг гаргаж өгөх, үүн дундаа сурч боловсрох нөөц, боломжоор хангах, мэргэжлийн ажил эрхлэхэд шаардлагатай ур чадварт сургах зорилготой. Гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд өртсөн орон нутгийн удирдлагуудтай хамтран бүлэглэлийн гишүүдтэй холбоо тогтоож, хууль бус амьдралын хэв маягаасаа татгалзах амлалтыг олон нийтийн өмнө өгсний нь дараа мужаан, барилгын мэргэжлийн сургалтад хамруулжээ.

Сургалт дуусахад залуучуудад жижиг бизнес эхлүүлэх багахан зээл олгожээ. Хэрвээ тэд гэмт бүлэглэлдээ буцаж нэгдэх юм бол зээлийг хүчингүй болгож, албадан төлүүлэх арга хэмжээ авдаг байна. Хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн мэргэжил эзэмшүүлэх сургалт, боловсролын үйл ажиллагаа завсардагч нэлээд ихтэй, сургалтын дараа ч ихэнх суралцагч тогтвортой бизнес бий болгож чадаагүй байна.

Үнэлгээнд хөтөлбөрийн зорилт хангагдаагүй явдлыг хоёр шалтгаанаар тайлбарлажээ. Гэмт бүлэглэл, тэдний соёлд ихэд хүчтэй хэвшсэн “хамтач” зарчмыг хөтөлбөрийн хүмүүс төдийлөн анхаараалгүй орхисон байв. Гэтэл бүлэглэлээс гарсан залуусын дунд хувийн бизнес хөөгөөд явж байгаагаа хар амиа хичээн бүлгээсээ, хамтын нөхөрлөлөөсөө урвасан гэж бодох хүн олон байжээ. Тиймээс Никарагуад хэрэгжсэн энэ хөтөлбөр бүлэглэлд нийтээр нь ашиг тусаа өгөх үйл ажиллагаа, жишээлбэл, бүлэглэл хамтран эрхэлж болох ажил мэргэжил, бизнес санал болгох замаар хамтаараа төлөвших боломжтой стратегиар ажилласан бол илүү өгөөжтэй байх байв. Мөн 1990-ээд оны дунд үед Никарагуад ажилгүйдлийн түвшин 60 хувьд хүрээд байсан бодит нөхцөлд нэг удаагийн жижиг зээлээр бизнес эхлүүлж, тогтвортой ажиллахад хүнд байсан ажээ (177).

Орон нутаг болон нийгмийн түвшний бодлого, хөтөлбөр

Гэмт хэрэг, хүчирхийлэл гардаг “халуун цэг”-ийн цагдан сэргийлэх ажиллагаа

“Халуун цэг”-ийн цагдан сэргийлэх ажиллагаа гэж гэмт хэргийн гаралт онцгой ихтэй орон нутаг руу цагдаагийн нөөцийг төвлөрүүлэн татах агуулгатай хууль сахиулах стратеги юм. Энэ стратегийг олон нийтийн болон тулгамдсан асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх стратегитай хамтаар хэрэгжүүлдэг. Гэхдээ олон нийтийн цагдан сэргийлэх стратегитай харьцуулахад, халуун цэгийн цагдан сэргийлэх стратеги нь гэмт хэргийн халуун цэгт эргүүл хяналтыг нэмэгдүүлэх зэрэг илүү уламжлалт тактик хэрэглэдэг бол

олон нийтийн цагдан сэргийлэх стратеги (дараагийн хэсгийг үзнэ үү) нь орон нутгийн иргэдтэй идэвх, санаачилгатай хамтран ажиллахыг эрмэлздэг.

ХУРААНГУЙ

- Халуун цэгийн цагдан сэргийлэх стратегийг олон нийтийн болон асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх стратегитай хослуулан хэрэгжүүлж, үнэлсэн.
- Халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөр нь хүчирхийлэлт гэмт хэргийг бага зэргээр бууруулах нөлөөтэй байгааг хэд хэдэн үнэлгээ харуулсан бол Кардиффын загвар гэж нэрлэдэг хөтөлбөрт хийсэн үнэлгээгээр хүчирхийлэлт гэмт хэргийг нэлээд хэмжээгээр бууруулсан үр дүн гарчээ.
- Зөвхөн өндөр хөгжилтэй улс орнуудад хамаарах нотолгоо бүрдээд байна.
- Судалгааны зарим нь сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг бууруулах зорилготой уялдах нь

Судалгаагаар ихэнх гэмт хэрэг, хүчирхийлэл тодорхой газарт (жишээлбэл, тодорхой гудамж, баар, шөнийн клуб) төвлөрсөн байдаг ажээ. Тиймээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг “халуун цэг” гэж нэрлэдэг эдгээр цэгт тууштай, системтэйгээр төвлөрүүлснээр гэмт хэрэг, хүчирхийллийг бууруулах боломжтой ажээ. Ер нь, гэмт хэрэг, зөрчил тодорхой хүмүүст төвлөрсөн байдаг гэхээс илүүтэйгээр тодорхой газар, цэгт төвлөрдөг гэж үзэх нь илүү оновчтой (178). Тодорхой газар, цэгт төвлөрсөн цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэгт хамгийн ихээр өртдөг газруудад хүч, анхаарлаа төвлөрүүлэн ажиллах замаар гэмт хэрэг, зөрчийг бууруулах зорилготой.

Нотолгоо

Санамсаргүй түүврийн 10 судалгааг хамруулсан системтэй тойм үнэлгээгээр (179) халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөр нь өмчийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийлэлт гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад статистикийн ач холбогдолтой ч багахан хэмжээний нөлөөтэй байгааг тогтоожээ (180). Уг үнэлгээнд гэмт хэргийн гаралт ойролцоох газрууд руу нүүн шилжсэн тохиолдолд гарах боломжит үр дагаврыг мөн тооцсон байна. Үнэлгээ нь мөн халуун цэгийн цагдан сэргийлэх стратегийг асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаатай хамтруулан авч үзээд, уг хоёр стратегийг хослуулбал гэмт хэргийн гаралт хамгийн ихээр буурах боломжтой гэж дүгнэжээ. Гэхдээ үнэлгээний шалгуурт нийцсэн судалгаануудаас маш цөөн хэд нь л өргөн хүрээтэй олон асуудал, тэдгээрийн боломжит үр дагаврыг авч үзсэн байгаа тул дээрх дүгнэлтүүдийг ойлгож тайлбарлахдаа болгоомжтой хандах хэрэгтэй.

Үүний дараа “Кардифф загвар” гэж нэрлэгддэг, эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн мэдээг цагдаагийн байгууллагын мэдээтэй тулгах замаар гэмт хэрэг, хүчирхийллийн халуун цэгүүдийг илүү нарийвчлалтай тогтоодог хөтөлбөрийн үнэлгээ хийгджээ. Үнэлгээгээр уг хөтөлбөр нь эмнэлгийн яаралтай тусламж авахад хүргэсэн хүчирхийллээс үүдэлтэй гэмтлийн тоо, цагдаад бүртгэгдсэн хүчирхийллээс үүдэлтэй шарх гэмтлийн тоог нэлээд бууруулж чадсан дүн гарчээ (8).

Халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүчирхийлэл, гэмт хэрэгтэй холбоотой “хэн, юу, хэзээ, хаана, яаж” гэсэн асуултад хариу өгөх нэмэлт мэдээлэл шаардлагатай. Үүнд цагдаагийн байгууллагын мэдээллийг нөхөн баяжуулах зорилгоор эмнэлгийн яаралтай тусламж авсан хүчирхийллээс үүдэлтэй гэмтлийн мэдээ, эсвэл дэлгүүрийн хулгай, нийтийн өмч эвдэж гэмтээсэн танхайн үйлдэл зэргийн мэдээг хамруулж болно. Энэ мэдээллийг ашиглан халуун цэгүүдийг тодорхойлж зураглал гаргах ба үүний тулд халуун цэгийн зураглал хийх аргачлал эзэмшсэн, газар зүйн мэдээллийн баазыг ашиглан дүн шинжилгээ хийх чадвартай мэргэжилтнүүд шаардлагатай болно.

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Халуун цэгийн цагдан сэргийлэх стратеги нь зарим нөхцөлд тохиромжгүй юм. Энэ стратегийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны, хариуцлагатай, хэлмэгдүүлэлт ба авилгаас ангид цагдаагийн тогтолцоо; гэмт хэрэг, зөрчил гарсан цаг, байршил, болсон үйл явдлын талаар цаг үеийн, үнэн зөв статистик мэдээ гэх мэт зарим урьтач нөхцөл бүрдсэн байх шаардлагатай. Иргэд гэмт хэрэг, хүчирхийллийг хатуу шийтгэл, чанга арга хэмжээгээр таслан зогсоохыг шаардахын хариуд улс төрчид хуулийг чангатган, хатуу гараар хэв журмыг бий болгох шийдлийг сонгодог. Гэтэл хариуцлага сул, авлигатай орчин нөхцөлд нухчин дарах, дарангуйлан зогсоох уур амьсгалаар хийгдсэн цагдаагийн арга хэмжээ, үйл ажиллагаа нийгмийн хурцадмал байдал үүсгэн, залуучуудын хүчирхийллийг улам нэмэгдүүлж болзошгүй. Орон нутагтай хамтран ажиллах стратегийг ашиглаагүй халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөр нь орон нутагт хурцадмал байдал үүсгэж мэднэ.

Цагдаагийн албан хаагчид шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх асуудалд хойрго хандаж магадгүй. Мөн гэмт хэрэг багатай орон нутгаас цагдаагийн хүн хүчийг татаж магад хэмээн эсэргүүцэж магадгүй.

Зардал

Халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүчирхийллийн мэдээллийг нэгтгэн газарзүйн кодчилал хийж, давтамжийг нь харгалзуулан газрын зураг дээр буулгах программ хангамж хэрэгтэй болно. Мөн мэдээлэлд шинжилгээ хийж, шийдвэр гаргах, хөтөлбөрийн үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх, улмаар хөтөлбөрийн үнэлгээг хийх удирдлагын чадавх, хүний нөөц шаардлагатай болно.

Кардифф хотын загвар

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Кардиффын загвараар (8, 181) хүчирхийллээс үүдсэн гэмтлийн улмаас эмнэлгийн яаралтай тусламж үзүүлсэн тохиолдол бүрт хүний нэрээс бусад “хэн, юу, хэзээ, хаана, яаж” гэсэн мэдээллийг цуглуулж, цагдаад бүртгэгдсэн хүчирхийллийн хэргийн мэдээлэлтэй нэгтгэнэ. Эрүүл мэнд ба цагдаагийн байгууллагын мэдээллийг нэгтгэснээр ирээдүйд гарах хүчирхийллийн хэв маягийг урьдчилан таамаглаж, халуун цэгүүдийг нарийвчлал сайтай тогтоох боломжтой болж, цагдан сэргийлэх болон бусад үйл ажиллагааг чиглүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой болно. Өнөөг хүртэл халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж иржээ:

- цагдан сэргийлэх зорилтот ажиллагаа буюу тодорхой халуун цэгүүд дэх хүчирхийллийн хэргийн гарах цаг, байршилтай уялдуулан цагдаагийн бие бүрэлдэхүүнийг байршуулах;
- архи, согтууруулах ундаа худалдах зөвшөөрөлтэй, хүчирхийлэлтэй байнга холбогддог үйлчилгээний газруудыг онцгой анхаарал, хяналтдаа авах;
- архины тусгай зөвшөөрөл олгодог өргөдөл шийдвэрлэх, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэдэг байгууллагатай мэдээлэл солилцох;
- тодорхой төрлийн зэвсэгтэй холбоотой эрсдэлийг бууруулахад чиглэсэн стратеги, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх (жишээлбэл, хуванцар сав ашиглах шаардлага тавих, шилний олдцыг бууруулах, хүйтэн зэвсгийг хураах ажиллагаа);
- мансууруулах бодис, согтууруулах ундааны хяналт зэрэг нийгмийн эрүүл мэнд, нийгмийн бодлогын нийтийн хөтөлбөрүүдтэй мэдээлэл солилцох (жишээлбэл, мансууруулах бодис, архины үйлчилгээ)

Кардиффын загварын үр дүнгийн үнэлгээг хийхдээ Кардифф хотын хэмжээнд тодорхой хугацаанд эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт хандсан хүчирхийлэлтэй холбоотой гэмтэл, цагдаад бүртгэгдсэн хүчирхийллийн хэргийн гаралтыг Их Британийн ижил төстэй нөхцөлтэй ч салбар дамнасан мэдээлэл солилцооны ийм бодлого хэрэгжүүлээгүй хотуудын үзүүлэлттэй харьцуулжээ. Уг үнэлгээгээр бусад хоттой харьцуулахад Кардифф хотын хөтөлбөр нь эмнэлэгт хандалтыг 42 хувиар, цагдаад бүртгэгдсэн гэмтлийн тоог 32 хувиар бууруулж чадсан үр дүн илэрчээ. Мөн үнэлгээгээр гэмтэл учруулаагүй хүчирхийллийн хэргийг (“нийтлэг танхайн хэрэг” гэж нэрлэдэг) цагдаад бүртгүүлэх явдал 38 хувиар нэмэгдсэн дүн гарсан (8) ба үүнийг судлаачид танхайн хэрэг, түүний урьтач нөхцөл байдалд (жишээлбэл, маргаан) цагдаа илүү шуурхай бөгөөд илүү олон давтамжтайгаар хариу үзүүлдэг болж, танхайн хэргийг хохирогч, гэрчүүд мэдээлэх нь нэмэгдэж, улмаар цагдаад хэрэг бүртгэх нь нэмэгдсэнээр тайлбарлажээ. (8)

Цаашилбал, Кардиффын хөтөлбөрт зардал, үр ашгийн шинжилгээ хийж, 2007 онд уг хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй бол Кардифф хотын төсөвт хүчирхийллийн улмаас үүсэх байсан эдийн засаг, нийгмийн өртөг зардлаас 6,9 сая фунт хэмнэгдсэнийг тооцоолжээ (182). Үүнд 2007 онд эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах байсан 1,25 сая фунт, эрүүгийн шүүхийн тогтолцооноос зарцуулах байсан 1,62 сая фунт багтжээ. Үүнтэй харьцуулахад, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал бага байсан бөгөөд тухайлбал, програм хангамж, урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг бэлдэн шинэчлэхэд 107,769 фунт, хөтөлбөрийн нэг жилийн үйл ажиллагааны зардал 210,433 фунт болжээ (2003 оны үнийн түвшин). Хөтөлбөр хэрэгжүүлснээр гарсан зардал, нийгмийн өгөөжийн харьцаа 2003-2007 онд нийт дүнгээрээ хөтөлбөрт зарцуулсан нэг фунт бүрт 82 фунтийн өгөөж гарсан гэх ба задалж харвал эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой нэг фунтын зардал нь 14,80 фунтийн өгөөж, эрүүгийн эрх зүйн салбарт зарцуулсан нэг фунт бүрт 19.1 фунтийн өгөөж гарсан байна (182).

Кардиффын загварын мэдээлэл хуваалцах аргачлалыг Их Британий Засгийн газрын Хүчирхийлэлтэй тэмцэх мэдээллийн стандартад (183) оруулж, албан ёсоор хэрэглэх шийдвэр гарсан ба 2015 оны долдугаар сараас эхлэн Англи даяар эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, цагдаагийн байгууллага нь хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл бүрдүүлж, бусад хөтөлбөртэй солилцох үүрэгтэй болжээ. Олон улсын хэмжээнд, Кардиффын загварт Бразил, Нидерланд, Өмнөд Африк, АНУ анхаарлаа хандуулж, хэд хэдэн хотод хэрэгжүүлсэн ба одоо үр дүнг үнэлэхээр бэлтгэлээ хангаж байна.

Олон нийтийн ба тодорхой асуудлаарх цагдан сэргийлэх үйл ажиллагаа

Олон нийтэд түшиглэсэн ба тодорхой асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа гэдгийг ижил утгаар ашигладаг бөгөөд хүчирхийллийг бууруулахад анхаарах суурь асуудлуудыг илрүүлэх цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа, асуудал шийдэх тодорхой арга аргачлалыг системтэйгээр хослуулан хэрэглэхийг хэлдэг. Цагдаагийн байгууллага нь тодорхой орон нутагт тулгарсан асуудлыг судалж, тэдгээрийг шийдэх үр дүнтэй шийдлүүдийг эрэлхийлэн, хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа үнэлгээг гүйцэтгэнэ. Олон нийтэд түшиглэсэн болон тодорхой асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаанд орон нутаг, оршин суугчид идэвхтэй оролцдогоороо цагдаагийн уламжлалт арга хандлагаас ялгаатай.

ХУРААНГУЙ

- Олон нийтэд түшиглэсэн ба асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчлийн гаралтад хэр нөлөөлж буйг үнэлсэн.
- Олон нийтэд түшиглэсэн ба асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бага зэрэг бууруулах нөлөөтэй.
- Зөвхөн өндөр хөгжилтэй орнуудад хамаарах нотолгоо бүрдсэн.
- Судалгааны ихэнх нь сул аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд зорилготой уялдах нь

Асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь тодорхой нутагт дэвсгэрт гэмт хэрэг, хүчирхийллийн шалтгаан болж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэдэг. Асуудалд чиглэгдсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд тодорхой орон нутгийн хүчирхийллийн өгөгдөл, бусад мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх; суурь эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх зорилгоор орон нутгийн оршин суугчидтай хамтран ажиллах; эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах үйл ажиллагаа боловсруулан хэрэгжүүлэх; үр дүнг үнэлэх зэрэг багтана.

Нотолгоо

Залуучуудын дундах болон залуу хүмүүсийн үйлдсэн хүчирхийлэл, гэмт хэргийн гаралтад олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа ямар нөлөө үзүүлж байгааг тусгайлан судалсан системтэй тойм судалгаа

олдсонгүй. Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь нийт гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад цагдаагийн ердийн арга стратегиас арай илүү нөлөөтэй байгааг нэг системтэй үнэлгээнд дурджээ (184). Олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагааны тодорхой хэлбэр болох явган эргүүл (185), гэрээр явах, залуучуудтай ажиллах (186), архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг газарт зорилтот хяналт тавих зэрэг стратегийн үр нөлөөг судалсан хэд хэдэн үнэлгээний тайлан гарчээ.

Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь

Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх стратеги хэрэгжүүлэхийн тулд эхлээд хууль ёсны, хариуцлагатай, дарангуйлал ба хээл хахуулиас ангид цагдаагийн тогтолцоо бий болсон байх ёстой. Цаашилбал, олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагаас мэргэжлийн өндөр ур чадвар шаардахын зэрэгцээ цагдаагийн байгууллага нь олон нийттэй сайн харилцаа тогтоож, орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажиллах шаардлагатай болдог. Нэг талаас, цагдаагийн гол дарга нарыг нэг орон нутагт удаан хугацаагаар ажиллуулах нь цагдаагийн байгууллага, орон нутгийн хооронд эерэг харилцаа үүсгэж, тогтвортой хадгалахад нэмэртэй ч цагдаагийн албан хаагчдыг тогтмол сольж ажиллуулах нь хээл хахуулиас сэргийлэх нэг гол стратеги болдог бөгөөд энэ нь орон нутагтай сайн холбоо тогтоох стратегид саадтай байх талтай.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагааг иргэд хэр хүлээж авах нь тухай орон нутаг, улс оронд цагдаагийн байгууллага хэрхэн ажиллаж, ямар нэр хүндтэй байж ирснээс ихээхэн хамаарна. Хүчирхийллийн түвшин маш өндөртэй зарим улс оронд хүчирхийлэл, гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд бодлого, шийдвэр гаргагчид хуулиа чангатгаж, чанга гараар барих хандлага баримталж ирсэн бол одоо гэмт хэрэгтнүүдтэй “зөөлөн” аргаар ажиллахыг олон нийт, цагдаа нар хүлээн зөвшөөрөхгүй байх магадлалтай. Олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь хэдийгээр нотлогдоогүй ч эрх мэдлээ хэтрүүлэх эрсдэлийг бий болгодог гэж зарим хүн үздэг.

Нөөцийн ашиглалт

Асуудалд чиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө холбогдох өгөгдөл, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх асуудлыг хариуцсан нэгж байгуулах, эсвэл түүнийг бэхжүүлэх шаардлагатай. Судалгаа авах, өгөгдлийг боловсруулах ажилд хөрөнгө тусгайлан хуваарилах хэрэгцээ үүсэж мэднэ. Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд цагдаагийн ажилтан, мэдээллийн ажилтнуудыг нэлээн сайн бөгөөд давтамжтайгаар сурган бэлдэж, замын зардал төсөвлөх хэрэгтэй болно. Цагдаагийн уламжлалт үйл ажиллагааг төсөвлөхөд харьцангуй хялбар, харин олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэх үйл ажиллагааны өртөг зардал янз бүр байхаас гадна хөтөлбөр хэрэгжих явцад төлөвлөгдөөгүй санхүүгийн хэрэгцээ гарч мэднэ.

Бразил: Залуучуудын дундах хүн амины хэргийг бууруулах зорилготой олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэх хөтөлбөр

Бразил Улсын Минас мужид хэрэгжүүлсэн Фика Виво (Fica Vivo буюу “Амьд үлд”) хөтөлбөр нь залуучуудын дундах хүн амины хэргийг бууруулах зорилготой олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэх хөтөлбөр юм (187). АНУ-ын Бостон хотын “Гал зогсоох үйл ажиллагаа” хөтөлбөрийн жишгээр боловсруулсан Фика Виво хөтөлбөр нь залуучуудад санхүүгийн болон нийгмийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх замаар гэмт бүлэглэлээс хамааралтай байдлыг бууруулах стратегитай бөгөөд зорилтот орон нутагтай холбоо тогтоох, орон нутгаа сайтар судалж мэдэхийн тулд тусгайлан бэлтгэгдсэн цагдаа нарыг тухайн орон нутагт өдрийн 8 цагаар байршуулан ажиллуулдаг байна.

Хөтөлбөрийн үнэлгээг хийхдээ Бело Хоризонте хотын Морро дас Педрас дүүргийн 2002-2006 онуудын хүн амины хэргийн гаралтын он дараалсан мэдээлэлд шинжилгээ хийх аргыг ашигласан ба хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат тус бүрт тухайн байршлыг уг хотын хүчирхийлэл ихтэй болон багатай хөрш дүүргүүдтэй харьцуулжээ. Хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн эхний 6 сард хүн амины хэрэг 69 хувиар буурсан ба хүн амины хэргийн гаралт энэ шинэ, бага түвшиндээ хадгалагдаж үлдсэн бөгөөд дараах саруудад бусад дүүрэгт ч хүн амины хэргийн бууралт ажиглагджээ (187).

Согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах нь

Согтууруулах ундааны олдоцыг бууруулах, зохисгүй хэрэглээг багасгах стратегид архи, согтууруулах ундааны реклам сурталчилгааг хяналттай болгох, хууль бус болон гэрийн аргаар нэрсэн архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, согтууруулах ундааны олдоцыг хязгаарлах, үнийн болон татварын бодлогоор эрэлтийг бууруулах, архины хамааралтай хүмүүст боломжийн үнээр хүртээмжтэй эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх зэрэг багтана.

ХУРААНГУЙ

- Хүн амины хэрэг, хүний аминд хүрээгүй халдлагын шинжтэй хүчирхийллийн гаралтад үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулснаар хүн амины хэрэг, хүний аминд хүрээгүй хүчирхийллийн хэргийн гаралт зарим нөхцөлд буурч байна.
- Дунд ба өндөр орлоготой орнуудад хамаарах нотолгоо бүрдсэн.
- Судалгааны зарим нь маш сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Архи, согтууруулах ундаа нь залуучуудын хүчирхийлэлтэй холбоотой ноцтой эрсдэлт хүчин зүйл болоод зогсохгүй энэ төрлийн хүчирхийллийг өдөөх нөлөөтэй орчны тодорхойлогч хүчин зүйл болдог. Бага залуугаасаа архи, согтууруулах ундаа хэрэглэж ирсэн хүний уух хэмжээ, давтамж, согтолтын түвшин нэмэгдсээр байдаг бөгөөд хүчирхийлэл үйлдэх магадлал нь бусдаас илүү байдаг (188). Согтууруулах ундаа нь хүнд физиологийн түвшний нөлөө үзүүлж, нийгэм, бусдын дунд биеэ хянах хяналтыг дарангуйлж, хүчирхийлэл үйлдэхэд түлхдэг. Олон оронд өсвөр насныхны дундах архи, согтууруулах ундааны хэрэглээ өндөр байна. Бага, дунд орлоготой орнуудын архи, согтууруулах ундааны худалдааны эргэлт нь хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байгааг гэрчилж байгаа бол өндөр орлоготой улс орнуудад хэрэглээ нэг түвшинд тогтвортой байна. Одоогоор архи, согтууруулах ундааны хэрэглээ маш багатай улс орнуудад ч яваандаа архитай холбоотой хязгаарласан арга хэмжээ авах хэрэгцээ үүснэ (189).

Нотолгоо

Архи, согтууруулах ундааны хэрэглээний давтамж ба хэмжээ (ялангуяа үе үе нэг дор ихээр уух) нь залуучуудын хүчирхийлэлтэй шууд холбоотой бөгөөд архи уух хэмжээг бууруулахад чиглэсэн арга хэмжээ нь согтуудаа үйлдэх хүчирхийллийг бууруулах нөлөөтэй байдаг ажээ. Цэвэр спиртийн хэрэглээг нэг хүнд нэг жилд нэг литрээр бууруулахад Европд хүн амины хэрэг 7 хувиар буурсан тухай нэг судалгаанд дурджээ (190). Архины татвар нь архины хэрэглээний хэв маяг, архинаас үүдэлтэй хор хохиролд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх зорилгоор бага, дунд орлоготой улс орнуудад хийгдсэн 10 судалгааны дүнг нэгтгэн шинжлэхэд архины үнийг нэмэхэд архины хэрэглээ, түүнтэй холбоотой хүчирхийллээс үүдэлтэй хүн амины хэргийн тоог бууруулсан дүн гарчээ (191, 192). Архины татвар нэмэгдэхэд архины нийт хэрэглээ буурч, залуу хүмүүсийн дунд архины эрэлт багассан ба архи ууж эхлэх нас хойшилсон байна. Архины үнэ, архи согтууруулах ундааны сурталчилгааны нөлөөг судлахад (193) архины жижиглэнгийн үнийн доод босгыг тогтоож, хямд үнээр зарагдаж байгаа болон их хямдралтай архины үнийг нэмэгдүүлэх замаар архины хэрэглээг бууруулж, түүнээс үүдэлтэй хор уршгийг бууруулах боломжтой гэж дүгнэжээ. Канадын нэг мужид хийсэн судалгаагаар аливаа архи, согтууруулах ундааны үнийн доод босгыг 10 хувиар ахиулахад архины хэрэглээ 14.6-16.1 хувиар буурсан байна (194).

Архи, согтууруулах ундаа худалдаалах цагийг зохицуулах замаар архинаас үүдэлтэй хүчирхийллийг бууруулж болох эсэхийг хэд хэдэн судалгаанд авч үзжээ. Австралийн нэг мужид баар цэнгээний газрын үйлчилгээний цагийг хязгаарласнаар танхайн хэрэг 37 хувиар буурсан гэж нэг судалгааны дүгнэлтэд дурджээ (195). Мөн архи, согтууруулах ундаа борлуулах цэгүүдийн нягтралыг бууруулснаар архины хэрэглээ, архитай холбоотой хор хохирол буурна гэсэн дүгнэлтэд хүрчээ (196).

Архи, согтууруулах ундааны сурталчилгаа нь архины зохисгүй хэрэглээг нэмэгдүүлэх нөлөөтэй гэж олон судалгаа баталж байгаа ч архины сурталчилгааг хориглох бодлого нь залуучуудын дундах хүчирхийллийн хэмжээнд хэрхэн нөлөөлж байгааг хэмжсэн судалгаа олдсонгүй (197).

Архи, согтууруулах ундааны хэрэглээний боловсрол олгох сургуульд түшиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлсний дараа сурагчдын дунд архины судалгаа хийхэд сурагчдын дундах архитай холбоотой хор хохирол буурсан нөлөө илэрсэнгүй (198).

Эмнэлгийн яаралтай эмчилгээний тасагт согтолттой, хүчирхийллээс үүдсэн гэмтэлтэй ирсэн залуу хүмүүсийг хамруулсан богино хугацааны арга хэмжээ хэрэгжүүлээд, түүнийгээ үнэлжээ (199). Уг арга хэмжээ нь сэнхрүүлэн сэдэлжүүлэх ярилцлага, ур чадвар хөгжүүлэх болон дүрд тоглох дасгал, бусад үйлчилгээнд холбон зуучлах ажлаас бүрдсэн бөгөөд хөтөлбөрт хамрагдсан залуучуудын түрэмгий зан, хүчирхийлэлт зан үйл дунд хугацаандаа мэдэгдэхүйц буурсан байжээ.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Ихэнх улс оронд архи, согтууруулах ундааны олдцыг ерөнхийд нь хязгаарлах бодлого төдийлөн нийтийн дэмжлэг хүлээдэггүй. Мөн архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг бизнесийнхэн эсэргүүцэх магадлалтай. Архи, согтууруулах ундаа нь халдварт бус өвчлөл, осол гэмтлийн (жишээлбэл, автын осол) томоохон шалтгаан болдог тул эрүүл мэндийн салбарын бодлого, шийдвэр гаргагчид архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах зорилготой арга хэмжээг дэмждэг. Харин архи, согтууруулах ундааг хэт хязгаарлах бодлого нь хууль бус архины үйлдвэрлэлийг нэмэгдүүлдэг тал бий.

Архины зохисгүй хэрэглээг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын архи, согтууруулах ундааны хор хөнөөлт хэрэглээг бууруулах дэлхийн стратеги (200) нь дэлхийн улс орнуудын төр засагт хандан, архины зохисгүй хэрэглээг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэн, хянах, үр дүнг нь үнэлэх ажлыг зохион байгуулахыг зөвлөжээ. Үүнд согтууруулах ундааны сурталчилгаа, ялангуяа залуучуудад хандсан сурталчилгааг хянан зохицуулах; согтууруулах ундааны олдцыг зохицуулах, хязгаарлах; татварын болон үнийн бодлогоор эрэлтийг бууруулах; бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс олон нийтийн мэдлэг, дэмжлэгийг нэмэгдүүлэх; архины хамааралтай болсон хүмүүст хүртээмжтэй эмчилгээ, үйлчилгээг боломжийн үнээр хүргэх; архины аюултай болон хор хөнөөлтэй хэрэглээг илрүүлэн, богино хугацааны хөтөлбөрт хамруулах зэрэг үйл ажиллагаа багтсан байна (200).

Зардал, үр ашиг

Архины зохисгүй хэрэглээг бууруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийн үр өгөөж болон зардал, үр ашгийг үнэлэх судалгаагаар (201) архи, согтууруулах ундааны үнийг нэмэх, олдцыг хязгаарлах, архи, согтууруулах ундааны зар сурталчилгааг хориглох стратегиуд нь зардлын хувьд үр ашигтай байна гэж дүгнэжээ.

Бразил Улсад согтууруулах ундааны олдцыг хязгаарлах арга хэмжээг багтаасан цогц хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хүчирхийллийг урьдчилан сэргийлж байгаа нь

Бразилийн Диадема хотод архитай холбоотой хүчирхийллийг бууруулах бүх нийтийн хөтөлбөр хэрэгжүүлжээ (202). Энэ хотод шөнийн цэнгээний газруудыг 23:00 цагт хаах тухай шинэ хууль гаргаж, хотын болон мужийн түвшний цагдаагийн байгууллагууд хамтран авто машин, баар цэнгээний газар, хараа хяналтгүй орчин зэрэг өндөр эрсдэлтэй газруудыг хянах “Нэгдсэн ажиллагаа” төсөл эхлүүлжээ. Гэмт хэрэг их гардаг газруудад хяналтын камер суурилуулжээ (203). Мөн хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй залуучуудыг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах арга хэмжээ авч, сургуулийн амралтаар (үндэсний хэмжээнд залуучуудын өдөөсөн гэмт хэргийн оргил үе) төрөл бүрийн үйл ажиллагаа зохиох чөлөөт цагийн клуб байгуулж, хууль бус мансууруулах бодисын хэрэглээг бууруулах зорилгоор амьдрах ухааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлжээ. Эдгээр санал санаачилгын үр дүнд хүн амины хэрэг 1999 онд 389 байсан бол 2003 онд 167 болж, дээрмийн хэрэг 1999 онд 5192 байсан бол 2003 онд 4368 болж тус тус буурчээ (203).

Хар тамхи, мансууруулах бодисын хяналтын хөтөлбөр

Мансууруулах бодисын хяналтын хөтөлбөр гэж хууль бус мансууруулах бодис, хар тамхины эрэлт, нийлүүлэлт, хэрэглээтэй холбоотой гардаг хүчирхийллийг бууруулах стратегиуд юм. Үүнд мансууруулах бодисын хэрэглээ, түүнээс хараат байдлыг бууруулах арга хэмжээ, мансууруулах бодисын хэрэглээг санхүүжүүлэх зорилгоор үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийг бууруулах, хууль бус мансууруулах бодисын зах зээлтэй холбоотой хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зэрэг залуучуудад чиглэсэн арга хэмжээ багтана.

ХУРААНГУЙ

- Мансууруулах бодис, түүний хэрэглээтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн гаралтад үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Мансууруулах бодисын хяналтын хөтөлбөрүүд нь мансууруулах бодисын хэрэглээ, түүнтэй холбоотой хэрэг зөрчлийг мэдэгдэхүйц бууруулах нөлөөтэй.
- Орон нутгийн түвшинд хүчирхийлэл буурсан гэж зарим судалгаа дүгнэжээ.
- Зөвхөн өндөр орлоготой улс орнуудад хамаарах нотолгоо бүрдсэн.
- Ихэнх судалгаа нь сулхан аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой уялдах нь

Мансууруулах бодис, хүчирхийлэл нь хоорондоо хэд хэдэн янзаар холбогддог. Нэгдүгээрт, хүчирхийлэлт зан үйл ба мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлс нь хэсэгчлэн давхарддаг ба нийтлэг хүчин зүйлс нь сурлагаар хоцрох, сургуульдаа дургүй байх; нийгмийн эсрэг зан үйл эрт илрэх, хичээл тасалдаг хүүхдүүдтэй найзлах; эцэг эхийн хараа хяналт сул; согтууруулах ундаа, мансууруулах бодисын олдоц амархан байх; ядуурал; орон нутгийн эмх замбараагүй байдал зэрэг болно (204). Тэгэхлээр энэхүү гарын авлагад дурдагдсан хүчирхийллийг урьдчилан сэргийлэх олон стратегийг мөн мансууруулах бодис хэрэглэх, түүнээс хараат болохоос урьдчилан сэргийлэхэд ашиглаж болно (205). Хоёрдугаарт, мансууруулах бодисууд нь хүний бие организмд физиологийн түвшний нөлөө үзүүлж, зан үйлд нь нөлөөлдөг учраас хүчирхийлэлд түлхэх магадлалтай. Гуравдугаарт, мансууруулах бодисоос хараат, донтой болсон хүмүүс “эдийн засгийн шахалт”-аар хүчирхийлэл үйлдэх буюу хар тамхи, мансууруулах бодис худалдаж авах мөнгө олох зорилгоор гэмт хэрэг, үүн дунд хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэх магадлалтай. Дөрөвдүгээрт, мансууруулах бодистой холбоотой хүчирхийлэл нь системжсэн шинжтэй болсон буюу хууль бус мансууруулах бодисын зах зээл дээр хүчирхийлэл нь мансууруулах бодисын өр төлбөрийг нэхэх, хар тамхи худалдаалагчдын хоорондын өрсөлдөөнийг шийдвэрлэх, мэдээлэгчийг шийтгэх арга болсон байх магадлалтай (206).

Мансууруулах бодисууд хүчирхийлэл үйлдэх эрсдэлд өөр өөрөөр нөлөөлдөг (207). Кокаин, амфетаминууд түрэмгий, хүчирхийлэлт зан үйлтэй холбоотой байдаг бол каннабис хэрэглэгчидтэй харьцуулахад кокаин, героин хэрэглэгч нь хүчирхийллийн үйлдэгч, хохирогч, гэрч болох нь илүү байдаг байна. Бензодиапезин хэрэглэсэн хүмүүс бусад хүмүүстэй харьцуулахад түрэмгий үйлдэл илүүтэй гаргадаг ажээ.

Нотолгоо

Залуучуудыг мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зорилготой хөтөлбөрүүдийг үнэлэхдээ юуны өмнө хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээнд үзүүлсэн нөлөөг нь судлаад, хүчирхийллийг сэргийлэх үр нөлөөг нь судлалгүй үлдээх нь их. Хууль бус бодисын хэрэглээг урьдчилан сэргийлэх зорилготой “Мансууруулах бодисоостатгалзъя” зэрэг сургуульд түшиглэсэн зарим хөтөлбөр нь мөн хүчирхийллийг бууруулах, зэвсэг биедээ авч явах тохиолдлыг бууруулах нөлөө үзүүлж байгаа нь хөтөлбөрийн үнэлгээнээс харагджээ (208). Тус хөтөлбөрт хамрагдсан хөвгүүдийн дунд зэвсэг авч явах тохиолдол 21 хувиар, хүчирхийлэл үйлдэх явдал 23 хувиар буурсан байв.

Хууль бус мансууруулах бодисын хэрэглээг бууруулах, мансууралттай холбоотой нийгмийн сөрөг үр дагаврыг бууруулахад хувь хүмүүст хандсан донтолтыг эмчлэх, нөхөн сэргээх, халамж үйлчилгээнд хамруулах зэрэг эрүүл мэндийн хөтөлбөрүүд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс илүү үр дүнтэй байдгийг нотолсон баримтууд улам нэмэгдсээр байна (209, 210). Мансууралтыг эмчлэх арга хэмжээний нийгэм, эрүүл мэндийн үр дагаврыг үнэлсэн хэд хэдэн судалгаанд орлуулах эмчилгээний аргууд

(жишээлбэл, хар тамхийг метадон эсвэл бупренофинаар орлуулах) нь хүчирхийллийг богино хугацаанд бага хэмжээгээр бууруулах нөлөөтэй байгааг дурджээ (211).

Мансууруулах бодисын хууль бус зах зээл, түүний эргэн тойронд байх эрүүгийн болон хүчирхийллийн үйлдлийг устгахад чиглэсэн хэд хэдэн төрлийн хөтөлбөр байдаг. Эдгээр нь орон нутгийн иргэд, үйлчилгээ үзүүлэгчид, мөн мансууруулах бодис борлуулахад оролцсон хүмүүсийн гэр бүлтэй хамтран ажиллахад ихээхэн анхаардаг. Мансууруулах бодисын хамгийн аюултай наймаачид голдуу баригдан шийтгүүлдэг бол жижиг гэмт хэрэг үйлдсэн хүмүүст олон нийтийн хурал цуглаанаар анхааруулга өгөөд өнгөрдөг. Харин анхааруулга авсан хүмүүс мансууруулах бодисын худалдаагаа зогсоохгүй бол хуулийн хатуу шийтгэл хүлээх болно. Эдгээр хөтөлбөрт үнэлгээ хийхэд хөтөлбөр хэрэгжсэнээр мансууруулах бодистой холбоотой хэрэг зөрчил 44-56 хувиар, хүчирхийлэл нэлээд хэмжээгээр багассан дүн гарчээ (212).

Мансууруулах бодисын хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Мансууруулах бодистой холбоотой залуучуудын хүчирхийллийн хэв маяг, төрөл хэлбэрээс хамааруулан бодлого гаргагчид мансууруулах бодисын эрэлтийг хумих, нийлүүлэлтийг бууруулах, эсвэл хосолсон стратеги хэрэглэхээр шийддэг. Мансууруулах бодисыг хянах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн салбар, цагдаагийн байгууллага өндөр чадавхтай байх шаардлагатай болно.

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Бодлого боловсруулагчид, олон нийт хууль бус мансууруулах бодисын хэрэглээг таслан зогсоох хөтөлбөрүүдийг чухал асуудал гэж үздэг. Гэхдээ мансууруулах бодисыг орлуулах эмчилгээ гэх мэт зарим хөтөлбөрийг бодлого боловсруулагчид, олон нийт ихэнхдээ дэмждэггүй.

Зардал

Мансууруулах бодистой тэмцэх арга хэмжээнүүд нь өөр хоорондоо ялгаатай олон янзын нөхцөл байдалд хэрэгждэг тул эдгээр арга хэмжээний өртөг зардлыг харьцуулах боломжгүй юм. Одоогоор гараад байгаа цөөн хэдэн судалгааны дүгнэлтээс харахад хууль сахиулах арга хэмжээнүүд нь эмчилгээ, нөхөн сэргээлт, халамж үйлчилгээний хөтөлбөрүүдээс илүү үнэтэй тусдаг байна. Нэг судалгаагаар, мансууруулах бодистой холбоотой эмчилгээний хөтөлбөрийг эрүүгийн эрх зүйн арга хэмжээний зардалтай харьцуулахад зардал, үр ашгийн харьцаа нь 1:4 байна гэж тооцоолсон бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлснээр гарсан хэмнэлтийг нэмж тооцвол нийт зардал, үр ашгийн харьцаа 1:12 болжээ (213).

**Никарагуад мансууруулах бодистой холбоотой
хүчирхийллийг бууруулсан нь**

Никарагуагийн цагдаагийн Насанд хүрээгүйчүүдийн асуудал эрхлэх тасаг мансууруулах бодистой холбоотой хүчирхийллийг бууруулах зорилгоор гурван шаттай хөтөлбөр хэрэгжүүлжээ. Хөтөлбөрийн хүрээнд сургуулийн сурагч хүүхэд, залуучуудад мансууруулах бодис, согтууруулах ундаа, хүчирхийллийн талаар боловсрол олгох сургалтуудыг эрүүл мэндийн боловсролын хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлэх, мансууруулах бодисоос хамааралтай болох, хүчирхийлэлд холбогдох өндөр эрсдэлтэй хүүхэд, өсвөр насныхан, тэдний гэр бүлийнхэнд нийгмийн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, гэмт бүлэглэлийн гишүүн хүүхэд, залуучуудад туслах (жишээлбэл, албан ёсны ажлын байр олоход туслах) зэрэг арга хэмжээ багтжээ. Уг хөтөлбөрийн чанарын үнэлгээгээр боловсролын болон нийгмийн сэтгэл зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэшсэн боловсон хүчин дутагдаж, ажлын байранд зуучлуулсан гэмт бүлэглэлийн гишүүдээс цөөн хэд нь л тогтвортой ажилласан байжээ (214).

Галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг бууруулах нь

Галт зэвсгээс үүдсэн гэмтлийг урьдчилан сэргийлэхийн тулд галт зэвсгийн олдоц, нийлүүлэлт, ашиглалтыг хянах, галт зэвсгийн хоёрдогч арилжааг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээ авдаг. Энэ хүрээнд галт зэвсэг, сумны зарим төрөлд хориг тавих, гарал үүслийг шалгаж тогтоох, галт зэвсэг эзэмших тусгай зөвшөөрлийг хүлээлгийн хугацаа, бусад нэмэлт шаардлагатай болгох, галт зэвсгийг хүүхдээс хол байлгах, олон нийтийн зарим газар биедээ авч явахыг хориглосон хууль гаргах (сургуулийн байшин барилга) зэрэг багтана (2). Олон улсын хэмжээнд Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцийн Галт зэвсгийн протоколд (215) хууль ёсны галт зэвсэг, түүний эргэлтийг зохицуулах, хянах; хууль ёсны галт зэвсгийг хууль бус эргэлтэд оруулахаас сэргийлэх; холбогдох гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, шүүн таслахад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлын хүрээг тодорхойлж өгчээ (215). Эдгээр арга хэмжээнээс залуучууд, ер нь тодорхой насны бүлэгт хамаатай нь маш цөөн. Гэхдээ залуучуудын дундах хүн амины хэрэг, мөн үхэлд хүргээгүй гэмтлийн дотроос галт зэвсэгтэй холбоотой тохиолдлын хувь хэмжээ өндөр байгаа тул дээрх арга хэмжээ бүгд залуучуудын хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх асуудалд хамааралтай юм.

ХУРААНГУЙ

- Хүн амины хэрэг, буудалцаан, зэвсэглэсэн дээрмийн халдлага, зэвсэглэсэн танхайн хэрэг, галт зэвсэг биедээ авч явах зэрэгт үзүүлэх нөлөөг үнэлсэн.
- Хууль тогтоомж нь галт зэвсгийн олдоц, галт зэвсэг хэрэглэн үйлдсэн хүн амины хэргийн гаралт, буудалцаан, зэвсэглэсэн дээрмийн халдлага, зэвсэглэсэн танхайн хэрэг, галт зэвсэг биедээ авч явах зэргийг бууруулахад хувь нэмэр оруулж байгааг батлах зарим нотолгоо бүрдээд байна.
- Бага, дунд орлоготой зарим улсад хийгдсэн судалгааны мэдээлэл байна.
- Судалгааны ихэнх нь сул аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Дэлхий даяар 2012 онд гарсан бүх хүн амины хэргийн 48 хувь нь галт зэвсэгтэй холбоотой байжээ (2). Хүчирхийлэл үйлдэхдээ галт зэвсэг ашиглах нь хүний амь нас хохироох, ноцтой гэмтэл учруулах шалтгаан болдог бөгөөд хүч үзсэн сөргөөцөлдөөн, зодооны үеэр нөгөө хүнээ айлгах зорилгоор ашиглагдах нь их. Буу, галт зэвсэг олдоцтой байх нь хүн амины хэрэг гарах эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйл болох нь хэд хэдэн улсыг хамруулсан кейсийн харьцуулсан судалгаа, цаг хугацааны цувралын шинжилгээ, тархцын судалгаа зэрэг өөр өөр дизайнтай судалгаануудаар батлагдаж байна (216, 217).

Нотолгоо

Галт зэвсэг ашиглан хүчирхийлэл үйлдэх явдлыг урьдчилан сэргийлэхэд ашиглаж байгаа янз бүрийн стратегийн үр нөлөөг нэгтгэсэн хоёр тойм судалгаа, нэг мета түвшний шинжилгээ байна. Буу, галт зэвсгийн хяналтын хуулиуд нь хүчирхийллийг бууруулахад нөлөө үзүүлж байгаа эсэхийг батлах хангалттай мэдээлэл алга гэж нэгэн системтэй тойм судалгаанд дүгнэжээ (218). Харин саяхны нэгэн мета-шинжилгээнд (219) галт зэвсэгтэй холбоотой хүчирхийллийг бууруулахад галт зэвсгийн худалдааг хориглох бодлого багахан хэмжээний нөлөөтэй, хууль сахиулах стратегиуд дунд зэргийн нөлөөтэй байна гэж дүгнэжээ. Өөр нэгэн системтэй тойм судалгаагаар (220) хууль бусаар галт зэвсэг биедээ авч яваа хүмүүсийг илрүүлэх зорилготой цагдаагийн эргүүл нь зэвсэглэсэн гэмт хэргийг (хүн амины хэрэг, буудалцаан, зэвсэглэсэн дээрэм ба танхай) урьдчилан сэргийлэх, улмаар хүчирхийллийг бууруулахад нөлөөтэй байна гэж дурджээ. Эдгээр судалгаанд мөн галт зэвсэг элбэг, олж авахад хялбар нөхцөлд буу эзэмших зөвшөөрлийг батлахтай холбоотой хүлээлтийн хугацаа тогтоох, тухайн хүнийг судлах, сургуулийн орчин дахь хүчирхийлэл, галт зэвсгийг тэвчихгүй байх бодлого гаргах зэрэг арга хэмжээ нь галт зэвсгийн хэрэглээг бууруулахад нөлөөлж чадаж байгаа эсэхийг нэмэлт судалгаагаар батлах шаардлагатай байгааг дурджээ. Дээрх судалгаануудын нэгээс (218) бусад нь галт зэвсгийг хориглох, хууль бусаар галт зэвсэг эзэмших, биедээ авч явахыг хориглосон хууль батлан хэрэгжүүлэх зэрэг галт зэвсгийн олдоц, хүртээмжийг хязгаарласан бодлогууд үр нөлөөтэй байх өндөр

магадлалтай гэж дүгнэжээ. Хамгийн сүүлд хийгдсэн Өмнөд Африкийн нэгэн судалгаанд буу эзэмших зөвшөөрөл олголтыг чангатган, галт зэвсгийн худалдааг хянан багасгах бодлого нь 2001-2005 онд 5 томоохон хотод 4585 орчим хүнийг үхлээс хамгаалж чадсан гэж тооцоолжээ (221).

Галт зэвсгийн олдоц, буруугаар ашиглах явдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Галт зэвсгийн олдоц, буруугаар ашиглах явдлыг бууруулах зорилготой хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнө тухайн бодлогыг ямар орчин нөхцөлд хэрэгжүүлэх гэж байгаагаа сайтар ойлгох зорилгоор нарийвчилсан зураглал хийх хэрэгтэй. Үүнд хүн амины хэрэг болон зэвсэг ашигласан хүн амины хэргийн тоо; одоо эргэлтэд байгаа хууль ёсны болон хууль бус галт зэвсгийн тоо; төрлийн тооцоо, галт зэвсэгтэй холбоотой хууль эрх зүйн орчны мэдээлэл зэргийг багтаана.

Галт зэвсгийн олдоц, буруугаар ашиглах явдлыг бууруулах зорилготой хөтөлбөр хэрэгжүүлэхэд нөхцөл байдлаас хамаарч шинэ хууль тогтоомжийн биелэлтийг хангах нэмэлт цагдаагийн хүч, олон нийтийг мэдээлэлжүүлэх олон нийтийн харилцааны хөтөлбөр, илүү нарийн мониторингийн систем бий болгох зэрэг арга хэмжээ нэмж авах шаардлага гарч болно. Мөн хөрш улс орнуудын холбогдох хууль тогтоомжийг харгалзах хэрэгтэй. Галт зэвсгийн тодорхой төрлийг хориглосон, эсвэл тодорхой төрөл, калибрийн бууг иргэн эзэмшихийг хязгаарласан хуультай улс орон илүү “зөөлөн” хуультай хөрш орнуудаас эдгээр буу зэвсгийг хууль бусаар оруулж ирэх явдалд хяналт тавих асуудалтай тулгарч мэднэ.

Хэрэгжүүлэх болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг хязгаарлахад бодлого боловсруулагчдын тууштай хүсэл зориг, холбогдох яамдын (дотоод хэргийн, хууль зүйн, батлан хамгаалахын яамд) хүчтэй дэмжлэг шаардлагатай. Ийм бодлого, арга хэмжээг зарим орны иргэд дэмжихгүй байх магадлалтай. Галт зэвсэгтэй холбоотой хүчирхийллийн түвшин өндөртэй улс орны иргэд амь насаа хамгаалах зорилгоор буу худалдаж авах, эзэмшилдээ байлгахад илүү түвэгтэй болох, хуулийн дагуу буу эзэмшиж байгаа шударга иргэд элдэв дарамт, хардлагад өртөх хэрнээ хууль бусаар буу эзэмшиж байгаа гэмт хэрэгтнүүдэд хориг болж чадахгүй гэх үндэслэлээр эдгээр эрх зүйн арга хэмжээг эсэргүүцэж мэднэ. Бодлого боловсруулагчид галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг хязгаарлах шинэ хууль тогтоомжийн давуу талыг сайн тайлбарлан, олон нийтэд ойлгуулахад ач холбогдол өгч ажиллах шаардлагатай. Жишээлбэл, АНУ-д галт зэвсгийн хууль тогтоомжуудын ачаар санамсаргүй буу алдсаны улмаас авсан гэмтэл, шархнаас үүдэлтэй нас баралт (222), залуучуудын дундах амиа хорлолт буурсан нь нотлогдоод байна (223).

Зардал

Галт зэвсэгтэй холбоотой гэмтлийг эмчлэхэд бусад төрлийн гэмтлээс илүү их зардал гараад зогсохгүй эмчилгээний шууд зардал нь маш өндөр байдаг (224, 225). Иймээс галт зэвсэгтэй холбоотой гэмтлийг урьдчилан сэргийлэх нь илүү үр ашигтай байх болно.

Өмнөд Африкийн Галт зэвсгийн хяналтын хууль

2000 онд Өмнөд Африк Улс галт зэвсэг, ялангуяа иргэдийн эзэмшилд байгаа галт зэвсгийн тоог бууруулах зорилгоор Галт зэвсгийн хяналтын тухай хууль баталсан ба уг хуулиар зарим төрлийн галт зэвсэг өмчлөхийг хориглох, буу эзэмших зөвшөөрөл олгохоос өмнө өргөдөл гаргагч иргэн галт зэвсгийг хариуцлагатайгаар ашиглах бие махбод, сэтгэл санааны чадамжтайг баталгаажуулан шалгах болжээ. Уг хууль хүн амины хэргийн гаралтад хэрхэн нөлөөлснийг үнэлэх зорилгоор судлаач Мацополюсын баг Өмнөд Африкийн таван хотын хүн амын дунд хүн амины хэргийн гаралт, нөхцөл байдлыг эргэн санаж, өнөөгийн байдалтай харьцуулах судалгааг (221) 2001-2005 онд хийж, нийт хүн амины хэрэг, үүн дунд галт зэвсэг ашиглан үйлдэгдсэн хүн амины хэрэг буурсан дүгнэлтэд хүрчээ. Галт зэвсгийн хяналтын тухай хууль, түүний хэрэгжүүлэлт нь таван хотын нэгдсэн дүнгээр 4585 хүний амь насыг хамгаалж чадсан гэж судалгааны баг тооцоолжээ (221).

Хот төлөвлөлт, орчны тохижилт

Уг стратегид хот суурины орчныг тохижуулах, хот төлөвлөлтийг сайжруулах замаар нөхцөл байдлаас хамааралтай гэмт хэрэг, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд багтдаг. Хот төлөвлөлтийг сайжруулах арга хэмжээ нь голдуу ядуу хороолол, бага орлоготой орон нутагт чиглэдэг ба төвлөрсөн цэвэр усны хангамж, цахилгааны шугам, сургууль ба эмнэлгийн барилга барьж байгуулах, эсвэл тодорхой орон нутагт иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор жишээлбэл, амралт чөлөөт цагаа өнгөрөөх ногоон байгууламж, нийтийн талбай байгуулах зэргийг багтаадаг.

Харин орчны тохижилтыг сайжруулах замаар нөхцөл байдлаас хамааралтай хүчирхийлэл, гэмт хэргийг урьдчилан сэргийлнэ гэдэг нь хотын төлөвлөлт, орчин, дэд бүтцийг сайжруулах замаар хүчирхийлэлтэй холбоотой биет орчин, хүрээлэн буй нөхцөл байдлыг өөрчлөхийг зорино гэсэн үг юм. Ийм төрлийн стратегид гудамж талбайн хяналтыг нэмэгдүүлэх (жишээлбэл, гэрэлтүүлэг нэмэх замаар), байшин барилгыг засаж сайжруулах, гудамж талбайг хөл хөдөлгөөнтэй байлгахын тулд, жишээлбэл, олон нийтийн газар нийтийг хамарсан арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх зэрэг багтана. Орчны аюулгүй байдлыг хангах нь орон нутгийн засаг захиргааны хариуцах асуудал учраас камержуулалт энэ стратегид мөн багтах ба ер нь хяналтын камер нь хот тохижилт, барилгажуулалтын аливаа хөтөлбөрийн салшгүй нэг хэсэг болоод байна.

ХУРААНГУЙ

- Хүчирхийлэл ба хүчирхийлэлт гэмт хэрэг, үүн дунд хүн амины хэргийн гаралтын хувь хэмжээнд үзүүлэх нөлөөллийг үнэлсэн.
- Хот төлөвлөлт, орчны тохижилт нь хүчирхийлэлт гэмт хэрэг буурахад нөлөөлдөг гэсэн нотолгоо байна.
- Бага, дунд орлоготой зарим улс оронд энэ асуудлаар судалгаа хийгдсэн.
- Ихэнх судалгааны сул дизайнтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой уялдах нь

Залуучуудын дундах хүчирхийллийн үзэгдэл нь тодорхой газруудад бусдаасаа илүүтэй төвлөрөх хандлага ажиглагддаг. Олон тооны оршин суугч орон байрны муу нөхцөлд амьдардаг; ядуурал, нийгмээс тусгаарлагдмал байдал; ялгаварлан гадуурхалт, өвчлөл төвлөрсөн шинжтэй газар, эсвэл гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэж байгаад бусдад харагдах, баригдах магадлал багатай газар залуучуудын дундах хүчирхийллийн түвшин өндөр байх хандлага ажиглагддаг. Тиймээс ийм орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авснаар хүчирхийллийг бууруулах боломжтой. Хамгаалж болохуйц орон зайн онолоор (226) нийтийн зам талбайг орон нутгийн иргэд нь эзэн сууж, арчилж тордон, хараа хамгаалалттай байлгадаг болох юм бол эдгээр газарт хүчирхийлэл гарах магадлал буурна гэж үздэг байна.

Нотолгоо

Биет орчныг сайжруулах олон хөтөлбөр, арга хэмжээ байдаг ба тэдгээрийн үр нөлөөг үнэлсэн системтэй тойм судалгаагаар (227) нийтийн тээвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, барилга байшин, цагдаагийн үйлчилгээний хүртээмж, зүлэгжүүлэлт зэргийг сайжруулах, үйлдвэр үйлчилгээний төв, иргэдийн биеийн тамир, бие бялдрын санаачилгыг хөгжүүлэн дэмжих зэрэг нь бүгд залуучуудыг хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөхөөс хамгаалах үр нөлөөтэй байгаа нь харагджээ.

Хот төлөвлөлт, орчны тохижилтын тодорхой асуудал, орчин нөхцөлийн нөлөөтэй гэмт хэргийн тодорхой талд төвлөрсөн хэд хэдэн тойм судалгаа хийгджээ. Их Британид хийсэн нэг судалгаагаар (228) гудамжны гэрэлтүүлэг сайжирснаар хүчирхийлэл 29 хувиар буурсан дүн гарчээ. Өөр нэгэн системтэй судалгаагаар гудамж, талбайн камержуулалт нь зөвхөн хянах боломж өндөр буюу жижиг талбай, харагдах орчинд саад болох зүйлгүй газарт орчны тохижилтын бусад арга хэмжээтэй хослуулан хэрэглэвэл үр дүнтэй байгааг тогтоожээ (228-229).

Хот тохижилтын олон янзын хөтөлбөр, санаачилга байгаа ч эдгээрийн үр дүнгийн үнэлгээ цөөн байгаа учраас тодорхой арга хэмжээ нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд хэр нөлөөлж байгааг ул суурьтай дүгнэн хэлэх боломжгүй байна. Ерөнхийдөө, орчны тохижилт, сайжруулалтын арга хэмжээнүүд нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд үр нөлөөтэй арга болж чадна.

Мөн хот төлөвлөлт, тохижилтын арга хэмжээ нь зөвхөн хүчирхийллээс хамгаалаад зогсохгүй нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ боломжуудыг гарган өгч, эрүүл аюулгүй орчин бий болгох давхар ач холбогдолтой.

Хот төлөвлөлт, орчны тохижилтыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Орчны нөлөөтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийг хүчирхийлэл, гэмт хэргийн гаралт өндөртэй орон нутагт хэрэгжүүлдэг. Эдгээр хөтөлбөр нь аюулгүй байдлын үнэлгээ, оролцогч талуудын дүн шинжилгээ хийхээс эхлэх бөгөөд дараа нь тухайн орон нутгийн иргэдийн тогтмол оролцоотойгоор хөтөлбөрийн төлөвлөлт хийгдэнэ. Зорилтот орон нутгийн хөрш зэргэлдээ орон нутгуудад үзүүлэх нөлөөллийг үнэлэх шаардлагатай. Хот төлөвлөлт, орчны тохижилтын арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжүүлэхэд орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ залуучуудын гэмт хэрэг, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд тэр бүр ач холбогдол өгдөггүй орон сууц, нийтийн тээвэр гэх мэт орон нутагтаа чухал салбаруудыг оролцуулах шаардлагатай.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Хот төлөвлөлт, орчны тохижилтын төсөл, хөтөлбөр нь орчин хүрээллийн эрүүл, аюулгүй байдлыг нэмэгдүүлж, амьдрахад илүү таатай болгон, оршин суугчдад эерэг нөлөө үзүүлдэг тул нийтийн өргөн дэмжлэгийг хүлээдэг. Төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд орон нутгийн иргэдийг татан оролцуулснаар оршин суугчдыг өөриймсөг, эзний ёсоор хандах хандлагатай болгож, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн, үр дүнг нь тууштай хадгалахад хувь нэмэр болно.

Зардал

Хот тохижилтын хөтөлбөрүүдийн цар хүрээнээс хамааран зардал нь харилцан адилгүй байдаг. Зарим хөтөлбөр дэд бүтцийн нэлээд хөрөнгө оруулалт, мэргэшсэн боловсон хүчин, тогтмол засвар үйлчилгээ шаардаж байхад тодорхой газарт орчныг сайжруулах зорилготой (жишээлбэл, гудамжны гэрэлтүүлэг, явган хүний зам, орон сууцны байрны аюулгүй байдал, үйлчилгээний төв, нийтийн зам талбайг сайжруулах) төслийг багахан төсвөөр гүйцэтгэх боломжтой.

Колумб Улсын Меделин хотын орчны тохижилтийн төсөл

2004 онд Колумб Улсын Меделин хотын удирдлагууд хотын захын ядуу хорооллуудыг хотын төвтэй холбосон нийтийн тээврийн үйлчилгээ бий болгожээ. Орон нутгийн хөрөнгө оруулалттай зэрэгцүүлэн хотын захын хорооллуудад дамжин өнгөрөх тээвэрлэлтийн зориулалттай дэд бүтцийг сайжруулах төсөл хэрэгжсэн байна. Хөтөлбөрт хамрагдсан хорооллуудыг харьцуулах зорилгоор хамрагдаагүй хороололд хүчирхийллийн хувь хэмжээг орчны тохижилтын хөтөлбөр эхлэхээс өмнө (2003 онд) болон дараа (2008 онд) үнэлсэн бөгөөд үүнд 466 оршин суугчийн урт хугацааны мэдээлэл, Прокурорын газраас авсан хүн амины хэргийн тоо баримтыг ашиглажээ. Тохижилт хийгдсэн хорооллуудад хүн амины хэргийн гаралт бусад хорооллоос 66 хувиар буурч, оршин суугчдын үнэлгээгээр хүчирхийллийн түвшин 75 хувиар буурсан (230) байна.

Ядуурлын төвлөрлийг сааруулах нь

Ядуурлын төвлөрлийг сааруулах стратегиуд нь эдийн засгийн ядууралд өртсөн түрээсийн байрны хорооллын оршин суугчдад эрхийн бичиг, санхүүгийн бусад урамшуулал олгож, өөр хороо, дүүрэг рүү нүүхэд нь дэмжлэг үзүүлэх замаар ядуурлыг бууруулах зорилготой. Эдгээр хөтөлбөр нь нүүж байгаа хүмүүст нийгмийн хөгжлийн шинэ боломжууд нээхийн зэрэгцээ төрийн үйлчилгээг авах орчин нөхцөл сайжирснаар тэдний нийгэм, эдийн засгийн байдал сайжирна гэсэн үзэлд суурилдаг байна. Ийм хөтөлбөрийг голдуу түрээсийн орон сууц барих, нийгэм эдийн засгийн үзүүлэлтээр илүү хороолол руу нүүлгэх зэрэг аргачлал ашиглан хэрэгжүүлдэг.

ХУРААНГУЙ

- Амьдралынхаа туршид хүчирхийлэл үйлдэн баривчлагдах явдалд үзүүлэх нөлөөллийг үнэлсэн.
- Ядуурлын төвлөрлийг сааруулах стратеги нь хүчирхийлэлт гэмт хэргийн хувь хэмжээг бууруулах богино хугацааны нөлөөтэй байх магадлалтай.
- Зөвхөн өндөр хөгжилтэй цөөн хэдэн улсад хамааралтай нотолгоо бүрдээд байна.
- Ихэнх судалгаа сайн аргачлалтай.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой холбогдох нь

Залуучуудын гэмт хэрэг, хүчирхийлэл нь хот суурин газрын ядуурал ихтэй, гэмт хэргийн гаралт өндөртэй хороололд орлого багатай өрхүүдийг төвлөрүүлэх үр нөлөөтэй барилгажилтын бодлоготой тодорхой хэмжээнд холбоотой. Хүчирхийлэлтэй холбогдох өндөр эрсдэлтэй өрхүүдэд хотын ядуу хорооллоос илүү чинээлэг хороолол руу нүүх боломж олгох, амьдрах нөхцөлийг нь сайжруулах юм бол хүчирхийлэл буурна гэж үздэг.

Нотолгоо

АНУ-д хэрэгжүүлсэн орон сууцжуулалт, нөхцөл сайтай хороолол руу нүүлгэх туршилтын хоёр төсөл (“Боломж руу нүүх” хөтөлбөр гэж нэрлэгддэг) нь ядуурал ихтэй хороололд төрийн түрээсийн байранд амьдарч байсан өрхүүдэд ядуурлын түвшин хамаагүй багатай хороололд төрийн бус мэдлийн үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр байгаа орон сууцыг сонгон нүүх эрхийн бичиг олгох аргыг туршжээ. Туршилтын төсөл хэрэгжсэнээс хойш 4-7 жилийн дараа судалж үзэхэд эмэгтэйчүүдийн амьдралынхаа туршид хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэн баривчлагдах тохиолдол 33 хувиар буурсан (231) бол эрэгтэйчүүдийн хувьд өөрчлөлт гараагүй байжээ. Харин дараа дараагийн урт хугацааны өгөгдийн шинжилгээгээр (232) төслийн дараах эхний 4 жилд хүчирхийлэл, гэмт хэргийн улмаас баривчлагдах явдал туршилтын бүлгийн эрчүүдийн хувьд хяналтын бүлгээс бараг гурав дахин багассан дүн гарсан бөгөөд энэ нөлөөлөл нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр суларсан дүн гарчээ.

Хүн амыг дассан орон нутгаас нь өөр газар руу нүүлгэх нь шилжин суурьшсан хувь хүмүүс ялгаварлан гадуурхагдах, соёлын хувьд тусгаарлагдах, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл үүсэх шалтгаан болох магадлалтай. Харин эерэг нөлөө гэвэл илүү сайн боловсролын болон төрийн үйлчилгээ авах боломжтой болдог явдал юм (232).

Ядуурлын төвлөрлийг сааруулах хөтөлбөр хэрэгжүүлэх нь

Энэхүү гарын авлагад дурдсан нүүлгэн шилжүүлэх стратегиуд нь бага орлоготой өрхүүдэд эрхийн бичгээр арай чинээлэг орон нутагт байр түрээслэх боломж олгосон аргачлалтай ашигласан хөтөлбөрүүд юм. Нүүлгэн шилжүүлэлтийн бусад хөтөлбөр нь сайн дурын үндсэн дээр буюу нүүхээр шийдсэн хүмүүс очих газраа өөрсдөө сонгож, нүүлгэлтийн зардал, мөн шинэ газар байшин барихад гарсан зардлыг нөхөн төлбөрөөр эргүүлж авах загвараар, эсвэл орон нутгийн засаг захиргааны шийдвэрээр шинэ хороолол руу албадан нүүлгэх загварыг ашигладаг.

Хэрэгжих болон хүлээн зөвшөөрөгдөх боломж

Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөр нь улстөрийн болон зохион байгуулалтын бэрхшээлүүдтэй тулгардаг. Шилжиж ирсэн өрх шинэ хөршүүдтэйгээ холбоо муутай байх, шинэ орон нутгийн суурин иргэд ч эсэргүүцэх явдал гардаг. “Боломж руу нүүх нь” туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж байхад эрхийн бичгээр эмзэг, ядуу бүлгийн өрхүүд нүүж ирснээр хорооллын нөхцөл байдал муудна гэж үзсэн суурин оршин суугчид эсэргүүцэл гаргаж

байжээ. Бага, дунд орлоготой олон улс оронд төрөөс санал болгож чадах үнээр суурьшлын бүсэд худалдаж авах боломжтой сул газар олдохгүй, тогтоосон байршил нь ажлын байрнаас хэт хол, хөтөлбөрт хамрагдсан өрхүүд амьдралдаа тохиолдох аливаа асуудлыг шийдэхэд нь дэм үзүүлдэг нийгмийн дэмжлэгийн сүлжээнээсээ салж ганцаардах зэрэг шалтгаанаар нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрүүд амжилтгүй болж байсан туршлага нэлээд байдаг.

Зардал

“Боломж руу нүүх” хөтөлбөрийн зардалд байрны түрээс болон бусад төлбөрийг багтаасан эрхийн бичиг, оролцогч гэр бүлүүдэд зөвлөгөө өгөх, тохирох байр олоход нь туслах, байр түрээслүүлэх хүсэлтэй хүмүүстэй ажиллах зэрэг зардал багтаж байв. Хөтөлбөрөөс нэг өрхөд нэг жилд 7000 ам. долларын зардал гаргах болж, үүнээс 650-2800 ам. доллар нь тухайн өрхөд шууд төлөгдөх хувь болжээ. Хөтөлбөрөөс нэг жилд 7700-9600 ам. долларын тэтгэмж олгохоор төлөвлөсөн байв (232). Өндөр зардалтай учир ядуурлын төвлөрлийг сааруулах хөтөлбөр бага болон дунд орлоготой улс орнуудад тохиромжгүй бөгөөд тэдний хувьд байгаа орон сууц, байр байгууламжаа сайжруулах нь илүү үр ашигтай хувилбар байж болох юм.

“Боломж руу нүүх” хөдөлбөр

“Боломж руу нүүх” хөтөлбөрийг АНУ-ын Орон сууц, хот байгуулалтын департамент туршилтын журмаар хэрэгжүүлжээ. Таван хотын (Балтимор, Бостон, Чикаго, Лос-Анжелес, Нью-Йорк) ядуу дүүргийн нийтийн сууцанд амьдардаг гэр бүлүүдийн дундаас чинээлэг юмуу дунд түвшний амьдралтай дүүрэг рүү нүүх өрхүүдийг орон сууцны эрхийн бичгийн сугалаагаар сонгожээ. Сугалаанд хожсон өрхүүдээс туршилтын бүлэг үүсгэн, ядуурлын үзүүлэлт нь 10 хувиас хэтрэхгүй хороолол руу нүүх нөхцөлтэй эрхийн бичиг олгожээ. Энэ бүлэгт мөн тохирох хороолол, орон сууц олох талаар зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээ үзүүлжээ. Хөтөлбөрийн хоёр дахь бүлэгт суурь стандартад нийцсэн ямар ч орон сууц авах нөхцөлтэй, гэхдээ байршлын хувьд хязгаарлалтгүй буюу өөрсдөө шийдээд хаана ч авч болох нийтлэг эрхийн бичиг олгожээ. Хяналтын бүлэгт эрхийн бичиг өгөөгүй бөгөөд тэд нийгмийн нийтлэг үйлчилгээг ашиглах боломжтой байв. Хөтөлбөрийн үнэлгээгээр төсөл хэрэгжсэнээс хойших эхний 4 жилд туршилтын бүлэгт хүчирхийлэл, хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэн баривчилагдах явдал нэлээд буурсан (232) байсан боловч энэ үр дүн урт хугацаандаа тогтвортой хадгалагдаж чадаагүй байна.

Нотолгооны тойм

Энэ бүлэгт авч үзсэн залуучуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлэх стратеги, тэдний үр нөлөөний талаар бүрэлдээд байгаа нотолгоо мэдээллийг Хүснэлт 4-т тоймлон харууллаа. Эдгээр стратегийг ямар орчинд хэрэгжүүлэхээс хамааруулан дөрвөн бүлэг болгон багцлав.

Хүснэгтээс харвал, бүлэг бүрт үр дүн өндөртэй байх магадлалтай урьдчилан сэргийлэх стратеги дор хаяж нэг байгаа ч судалгааны мэдээлэл, нотолгоо дутагдсаны улмаас үр дүнтэй эсэх нь тодорхойгүй өөр олон стратеги байна. Бага насны хүүхдэд чиглэсэн хөтөлбөрүүдийн дундаас эцэг эхчүүдэд хүмүүжлийн эерэг арга барил эзэмшүүлэх хөтөлбөр, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь үр нөлөө сайтай гэж үнэлэгдсэн бол гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр нь хүүхдийг яваандаа буюу өсвөр насанд хүчирхийлэлд холбогдохоос хэр сайн хамгаалж чадаж байгааг тогтоох судалгаанууд дутагдалтай байна.

Сургуульд түшиглэсэн стратегиудаас амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх болон үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд үр дүнтэй байх боломжтой гэж үнэлэгдсэн бол сурлагын амжилтыг дэмжих, өсвөр насныханд хичээл таслахгүй байх нөхцөлтэй санхүүгийн урамшуулал олгох, чөлөөт цагийн зохион байгуулалттай арга хэмжээнд хамруулах зэрэг хөтөлбөрүүдийн үр нөлөөг нэмж сайн судлах хэрэгтэй байна. Болзооны үеийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөрүүдийн үр дүн тууштай бус байгаа бөгөөд зарим судалгаагаар үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр нь сөрөг нөлөөтэй буюу залуучуудын дундах хүчирхийллийг нэмэгдүүлэх магадлалтай байгааг тогтоожээ.

Хүчирхийлэлд холбогдох өндөр эрсдэлтэй залууст чиглэсэн стратегиудын дундаас түрэмгий зан үйл хэдийн илэрсэн залуучуудыг хамруулдаг эмчилгээ заслын хөтөлбөрүүд (жишээлбэл, танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ) залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд үр нөлөөтэй байгаа бол мэргэжлийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, зөвлөн дэмжигч менторын хөтөлбөр, гудамжны ба гэмт бүлгийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хувьд нотолгоо хангалтгүй тул үр нөлөөг нь үнэлэх боломжгүй байжээ.

Орон нутгийн болон нийгмийн түвшинд халуун цэгт төвлөрсөн, асуудалд төвлөрсөн болон олон нийтийн оролцоонд суурилсан цагдан сэргийлэх хөтөлбөрүүд, архи, согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах бодлого; мансууруулах бодисын хяналтын хөтөлбөр; галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг хязгаарлах бодлого; хот төлөвлөлт болон орчны тохижилтын арга хэмжээ, ядуурлын төвлөрлийг сааруулах бодлого зэрэг нь бүгд залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үр нөлөө сайтай гэж үнэлэгджээ.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх стратегиудын үр нөлөө

Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратегиуд	Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр	?
	Эцэг эхийн боловсролын хөтөлбөр	+
	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	+
Сургуульд түшиглэсэн хичээл сурлагын ба нийгмийн ур чадвар хөгжүүлэх стратегиуд	Амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр	+
	Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр	+
	Сурлагын амжилтыг ахиулах хөтөлбөр	?
	Болзооны үеийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр	+/-
	Өсвөр насныханд чиглэсэн хичээл таслахгүй нөхцөлтэй санхүүгийн урамшууллын хөтөлбөр	?
	Үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр	+/-
	Хичээлээс гадуурх хөтөлбөр, чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад арга хэмжээ	?
Хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй, өмнө нь хүчирхийлэл үйлдэж байсан залуучуудад чиглэсэн стратегиуд	Эмчилгээ заслын хөтөлбөр	+
	Мэргэжлийн баримжаа олгох сургалтын хөтөлбөр	?
	Зөвлөн дэмжигч менторын хөтөлбөр	?
	Гудамжны ба гэмт бүлэглэлийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр	?
Орон нутаг болон нийгмийн түвшний стратегиуд	Халуун цэгүүдэд төвлөрсөн цагдан сэргийлэлт	+
	Асуудалд төвлөрсөн болон олон нийтийн оролцоонд суурилсан цагдан сэргийлэлт	+
	Согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах бодлого	+
	Хар тамхи, мансууруулах бодисын хяналтын хөтөлбөр	+
	Галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг бууруулах бодлого	+
	Хот төлөвлөлт, орчны тохижилтын хөтөлбөр	+
	Ядуурлын төвлөрлийг сааруулах хөтөлбөр	+

Тайлбар

- +** үр дүнтэй байх өндөр магадлалтай (залуучуудын дундах хүчирхийллийг үйлдэх, түүнд өртөхөөс урьдчилан сэргийлж чадаж байгаа нь сайн аргачлалтай наад зах нь нэг үнэлгээгээр нотлогдсон, эсвэл энэ төрлийн хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт болон хамгаалагч чухал хүчин зүйлсэд эергээр нөлөөлж байгаа нь наад зах нь хоёр үнэлгээгээр нотлогдсон хөтөлбөрүүдийг багтаасан стратегиуд).
- ?** нотлох баримт дутагдалтай учраас үр нөлөөтэй эсэх нь тодорхойгүй (үр нөлөө нь тодорхойгүй нэг юмуу хэд хэдэн хөтөлбөрийг багтаасан стратегиуд)
- +/-** холимог үр дүнтэй үнэлэгдсэн тул үр нөлөө нь тодорхойгүй (үр нөлөө нь холимог буюу залуучуудын дундах хүчирхийлэлд мэдэгдэхүйц эерэг нөлөөтэй хөтөлбөрүүдийн зэрэгцээ ноцтой сөрөг нөлөөтэй хөтөлбөрүүдийг багтаасан стратегиуд)



4

Залуучуудын дундах
хүчирхийллийг урьдчилан
сэргийлэх бодлого, хөтөлбөр
хэрэгжүүлэхэд төр засаг, иргэний
нийгэм юу хийж чадах вэ?

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд ахиц дэвшил гаргахын тулд арга хэмжээ, хөтөлбөр, бодлогуудын боловсруулалт, хэрэгжүүлэлт, явц, хяналт мониторингийг дэмжсэн нэгдсэн ойлголт, удирдлага зохион байгуулалтын суурь шаардлагатай. Ийм суурь нь нийгмийн эрүүл мэндийн бусад асуудлыг шийдэхэд шаардагдах, ихэвчлэн шийдвэрлэхээр хэдийнээ ажиллаж байгаа нөөц, боломжуудад түшиглэсэн байдаг. Тиймээс залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн эрүүл мэндийн бусад асуудлыг шийдэхээр ажиллаж байгаа дэд бүтэц, системүүдэд түшиглэн хэрэгжүүлэх хэрэгтэй.

Зураг 3 дээр харуулсан хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн аргачлал нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг одоо хэрэгжиж байгаа нийгмийн эрүүл мэндийн бусад бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулах арга зүй юм. Энэхүү аргачлал нь мөн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх явцдаа үр нөлөөг нь үнэлж байх, үнэлгээний мэдээллийг эргээд хөтөлбөрөө сайжруулахад ашиглаж байхыг чухалчилдаг байна.

ЗУРАГ 3

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн хандлага



Эх сурвалж: Крюг нар (1)

Тодорхойлолт ёсоор, нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүд нь дээд зэргийн ашиг тусыг хамгийн олон хүнд хүргэх зорилго агуулдаг. Практик дээр, залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн аргачлал нь Зураг 3-т үзүүлсэн дөрвөн алхмаар хэрэгждэг. Нэгдүгээр алхам бол мэдээллийг системтэй цуглуулах үе бөгөөд энэ төрлийн хүчирхийллийн цар хүрээ, тархац, мөн чанар, үр дагаврыг тодорхойлоход тусална. Хоёрдугаар алхам бол залуучуудын дундах хүчирхийллийг нэмэгдүүлэх юмуу бууруулах нөлөө үзүүлэх эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлох үе ба үүнд арга хэмжээ авснаар өөрчлөн хувиргаж болох хүчин зүйлсийг мөн багтааж үзнэ. Гуравдугаарт хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах бүлгүүдийн хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлсэн арга хэмжээнүүд боловсруулан, үр дүнг нь үнэлэх замаар залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй зүйлсийг олж тогтооно. Дөрөвдүгээрт үр нөлөөтэй, өгөөж сайтай байх магадлалтай арга хэмжээ, хөтөлбөрүүдийг янз бүрийн орчин нөхцөлд өргөнөөр хэрэгжүүлж, ингэх явцдаа шийдэхээр зорьж буй асуудал болон эрсдэлт хүчин зүйлд тухайн арга хэмжээнүүдийн үзүүлж буй нөлөөг тогтмол хянан мониторинг хийх замаар хөтөлбөрийн үр нөлөө, үр ашгийг үнэлнэ (1).

Нийгмийн эрүүл мэндийн хандлага нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах энгийн бөгөөд ойлгомжтой аргачлал болж чадах ч төр засаг, урьдчилан сэргийлэх асуудлаар ажилладаг бусад оролцогч талуудаар энэхүү аргачлалыг хүлээн зөвшөөрүүлэхэд багагүй хүндрэл тулгардаг. Ер нь олон улс орон залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх өөрийн туршлагагүй, энэ нь тэдний хувьд шинэ ойлголт байдаг тул асуудлыг нийгмийн эрүүл мэндийн арга хандлагаар шийдэж эхлэхээсээ өмнө шаардлагатай хүний нөөц, институцийн бэлтгэлийг ханган, суурийг бий болгоход анхаарах шаардлагатай. Тиймээс энэ бүлэгт залуучуудын дундах хүчирхийллийг нийгмийн эрүүл мэндийн арга хандлагаар урьдчилан сэргийлэх бэлтгэлийг хангахад анхаарах үйл ажиллагааны 6 чиглэлийг тоймлон тайлбарлав. Эдгээр нь:

1. урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;
2. салбар хоорондын түншлэлийг хөгжүүлэх;
3. хүний аминд хүрсэн болон хүрээгүй залуучуудын хүчирхийллийн тохиолдол, тэдгээртэй холбоотой эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийн талаар мэдээлэл цуглуулахын ач холбогдлыг сурталчлан таниулах;
4. одоо хэрэгжиж байгаа урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийг үнэлэх чадавхыг нэмэгдүүлэх;
5. эрх зүйн орчныг бий болгох;
6. залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Энэхүү гарын авлага нь хязгаарлагдмал нөөц боломжтой орчин нөхцөлд залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэм болох зорилготой тул дээрх 6 чиглэл тус бүрийн хүрээнд нэмэлт нөөц шаардахгүйгээр хэрэгжүүлж болох үндсэн арга хэмжээ; нэмэлт эх үүсвэр дайчлан хэрэгжүүлэх өргөтгөсөн арга хэмжээ; мөн нэлээд хэмжээний нөөц, хөрөнгө нэмж дайчлах шаардлагатай хүсэмжит арга хэмжээ гэсэн сонголтуудыг танилцуулж байна.

1. Урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлогын суурь нь уг асуудлыг бодлого боловсруулагч, хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд таниулан ойлгуулах явдал юм. Энэ таниулах ажлыг манлайлах үүргийг залуучуудын дундах хүчирхийллийн холбогдолтой мэдээллийн ихэнхийг цуглуулж, хохирогчдын ихэнхэд хүрч ажилладаг Эрүүл мэндийн яам гүйцэтгэх нь хамгийн тохиромжтой. Ингэхдээ Эрүүл мэндийн яам дотроо, бусад салбаруудын, олон нийтийн гэсэн гурван хүрээний оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Эрүүл мэндийн салбарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх салбар дамнасан бодлогын хэрэгжилтийг нийгмийн эрүүл мэндийн аргазүйгээр удирдан, манлайлж ажиллах нь зарим орны Эрүүл мэндийн яамны хувьд шинэ зүйл болж мэднэ. Энэ тохиолдолд чухам яагаад энэ Яам залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд манлайлах үүрэгтэй байх ёстой вэ гэдгийг тайлбарлан ойлгуулах нь чухал бөгөөд үүний тулд дараах дөрвөн санааг онцолж байна.

Нэгдүгээрт, Эрүүл мэндийн яам нь өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг бүгдийг нь анхаарч ажиллах ёстой бөгөөд уг гарын авлагын 2 дугаар бүлэгт дурдсанчлан, хүчирхийлэл нь залуу хүмүүсийн нас баралт, гэмтэл, олдмол хөгжлийн бэрхшээлийн нэг үндсэн шалтгаан болоод байна. Цаашилбал, ДЭМБ-ын гишүүн орнууд нийгмийн эрүүл мэндийн арга хандлагаар хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах үүрэг амлалт авч, үүнийгээ хэд хэдэн удаагийн Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулганы тогтоол шийдвэрээр баталгаажуулаад байна (234, 235). Гуравдугаарт, залуучуудын үйлдсэн хүчирхийллээс үүдэлтэй гэмтэл, сэтгэцийн эрүүл мэндийн доройтол, зан үйлийн хямралт асуудлуудыг эмчилж, засаж сайжруулах зардал, ачааллын дийлэнхийг эрүүл мэндийн салбар үүрч байгаа тул залуучуудыг хүчирхийллээс хамгаалах нь Эрүүл мэндийн яамны хувьд зардлаа бууруулах эдийн засгийн ашиг сонирхлын асуудал юм. Дөрөвдүгээрт, Эрүүл мэндийн яам мэдээлэл цуглуулах, эрсдэлийн шинжилгээ хийх, яаралтай болон удаан хугацааны эмчилгээ асаргаа үзүүлэхийн зэрэгцээ олон салбар дамнасан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зангидан зохицуулах, улс төрийн дэмжлэгийг олж, эрх зүйн өөрчлөлтийг санаачлан эхлүүлэх боломж олгосон чухал орон зайг эзэлж байгаа байгууллага юм. Олон улс оронд залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх эдгээр үйл ажиллагааг Эрүүл мэндийн яамнаас өөр зохион байгуулах байгууллага байхгүй (233).

Бусад салбарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь

Урьдчилан сэргийлэх баримтлал, стратегиудыг залуучуудын дундах хүчирхийллийн асуудалтай холбон хэрэглэх туршлагатай улс орон цөөн. Тиймээс хүчирхийллийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад олон салбарын оролцоог хангасан хандлагаар нотолгоонд суурилсан аргачлалаар ажиллах нь нийгэм, эдийн засгийн олон талын үр өгөөжийг авчрах болно гэдгийг бусад салбарт таниулан ойлгуулахад Эрүүл мэндийн яам чухал үүрэг гүйцэтгэж чадна. Үүний тулд сургалт, семинар зохион байгуулах, мэдээллийн хуудас хэвлэж тараах, холбогдох талуудыг оролцуулан

залуучуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлын хүрээнд тус бүрийн үүрэг, хариуцлагыг хэлэлцэх зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж болно. Эрүүл мэндийн яам нь цуглуулсан мэдээлэл, өгөгдлөө ашиглан өөрийн орон дахь залуучуудын хүчирхийллийн хэлбэр, цар хүрээний талаар, мөн уг асуудлын эпидемиологийн нөхцөл байдал, шууд болон шууд бус зардал, үр нөлөөтэй болон үр нөлөөтэй байх өндөр магадлалтай урьдчилан сэргийлэх арга стратеги (жишээлбэл, энэ гарын авлагын 3 дугаар бүлэгт танилцуулсан) зэрэг асуудлаар шийдвэр гаргагч нарт мэдээлэл хийж байх хэрэгтэй.

Заримдаа Эрүүл мэндийн яам эрүүл мэндийн тодорхой асуудлаар бусад яам, НҮБ-ын төрөлжсөн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах уриалга гаргадаг. Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх төрийн үүрэг хариуцлагын тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд Эрүүл мэндийн яам нь НҮБ-аас гаргасан дэлхий нийтийн болон бүс нутгийн үйлчлэлтэй тогтоол шийдвэрүүдийг ашиглаж болох ба үүнд, тухайлбал, нийгмийн бодлого бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл гэсэн байр суурь туссан Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулганы хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлаарх шийдвэрүүд (23, 235), НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Хорооны шийдвэрүүд зэргийг нэрлэж болно (236).

Эрүүл мэндийн яамны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг дэмжих өөр нэг хүчтэй түнш бол төрийн бус байгууллага юм. Аль ч оронд хүчирхийллийг гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх ёстой гэсэн үзэл санааг хамгийн уйгагүй, хүчтэй тараан сурталчилдаг хүмүүсийн дунд хүчирхийллийн хохирогч, тэдний гэр бүлийн гишүүд багтдаг. Жишээлбэл, ийм идэвхтнүүд хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг урьдчилан сэргийлэхэд илүү анхаарал тавихыг шаардаж, нэмэлт хөрөнгө төсөвлөхийг сурталчилж ирсэн. Сургууль дээрх буудалцаан юмуу алдартай нэгний амь насанд халдах гэх мэт эмгэнэлт хэрэг явдал гарахад олон нийт маш их цочирдож, арга хэмжээ авахыг шаардах нь нэмэгддэг. Ийм нийтийн анхаарал, шаардлагыг оновчтой зохион байгуулж, чиглүүлж чадах юм бол залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудалд тавих улс төрийн анхаарал, хүчтэй дэмжлэгийг хурдан олж аваад, алдахгүй байх боломж бий. Төрийн бус ийм санаачилгыг Эрүүл мэндийн яам боломжтой бүхий л талаар дэмжиж ажиллах юм бол залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хүчин чармайлт улам бэхжин тогтворжих юм.

Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь

Төрөөс хэрэгжүүлж буй олон нийтийн мэдээллийн кампанит ажил нь залуучуудын дундах хүчирхийллийн мөн чанар, далайц, үр дагаврыг олон нийтэд таниулж, хэрхэн урьдчилан сэргийлж болох талаар мэдээлэл өгөх зорилгод чиглэх ёстой. Төр мөн энэ төрлийн хүчирхийллийн шалтгаан, урьдчилан сэргийлэх боломжтой эсэхтэй холбоотой олон нийтийн дунд тархсан эндүү ташаа ойлголтыг засаж залруулахад анхаарах ёстой. Мэдээллийн кампанит ажлыг голдуу шинэ хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр батлагдсантай уялдуулан хэрэгжүүлэхээр төлөвлөх нь зүйтэй бөгөөд ингэснээр шинэ шийдвэр гараад байгаа талаар олон нийт мэдэж авах юм. Мэдээллийн кампанит ажлыг мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үеэр тодорхой санааг онцлон хүргэх зорилгоор хэрэгжүүлж болох бөгөөд жишээлбэл, сургуулийн орчинд үе тэнгийн дарамтыг үл тэвчих, эсвэл хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд архи, согтууруулах

ундааны олдоц, зохисгүй хэрэглээг хянах бодлого чухал нөлөөтэй гэсэн санааг хүргэхээр төлөвлөн зохион байгуулж болно. Хүчирхийллийн асуудалд холбогдолтой шинэ бодлого, хөтөлбөр батлагдах, ном хэвлэгдэн гарах үеийг ашиглан Эрүүл мэндийн яам олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохиох хэрэгтэй.

Мөн олон нийтийн кампанит ажлыг Олон улсын залуучуудын өдөр (8 дугаар сарын 12) гэх мэт дэлхий нийтээр анхаарал хандуулдаг үйл явдлын хүрээнд зохион байгуулдаг. Өндөр ач холбогдолтой үйл явдлын хүрээнд зохион байгуулж буй кампанит ажилд нэр хүндтэй олон нийтийн зүтгэлтэн, орон нутгийн болон үндэсний хэвлэл мэдээллийн байгууллагыг татан оролцуулж, үр нөлөөг нь улам нэмэгдүүлэх боломжтой. Сайтар төлөвлөн, хэрэгжүүлж чадах юм бол ийм кампанит ажил нь цаашид санаа, хүчээ нэгтгэн ажиллах өргөн хүрээтэй эвсэл байгуулагдах түлхэц болдог.

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Альянс байгууллагын Ямайк Улс дахь салбар

2004 онд Ямайк Улсын Эрүүл мэндийн сайд Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх альянс олон улсын сүлжээний салбарыг өөрийн улсдаа байгуулжээ. Нээлтийн ажиллагаан дээр хэлсэн үгэндээ тэрбээр хүчирхийлэл, үүн дундаа залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд нийгмийн эрүүл мэндийн арга хандлагаар олон салбарууд хамтран ажиллахын чухлыг онцолжээ. Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх альянс нь дэлхий нийтийн хэмжээнд дараах 6 зорилтыг хангахаар ажилладаг байна:

- Хүчирхийллийг урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
- Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт мониторингийг дэмжих;
- Хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл цуглуулах чадавхыг нэмэгдүүлэх;
- Хүчирхийллийн анхан шатны урьдчилан сэргийлэлтийг сурталчлан таниулах;
- Хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулах;
- Хүчирхийллийн урьдчилан сэргийлэлтийг нийгмийн болон боловсролын бодлогод суулган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг юм.

Эдгээр зорилтыг хангахын тулд Ямайк Улсад Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажлыг удирдах Үндэсний Хороо, мөн оролцогч талуудын төлөөллийг багтаасан Ажлын хэсэг байгуулжээ (233).

Гэхдээ мэдээлэл болон сурталчилгааны кампанит ажил нь дангаараа залуучуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлж чадахгүй тул мэдээлэлжүүлэх, ойлголтыг нь нэмэгдүүлэх ийм арга хэмжээг хүчирхийллийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн урт хугацааны стратегийн хүрээнд төлөвлөж оруулах хэрэгтэй.

Мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааны сонголтууд

ҮНДСЭН	ӨРГӨТГӨСӨН	ХҮСЭМЖИТ
Төр засаг, үүн дундаа хууль зүй, боловсрол, нийгмийн хамгааллын яамны асуудал хариуцсан гол хүмүүст асуудлаа танилцуулах, тэдэнтэй зөвлөлдөх;	Салбар салбарын төлөөллийг хамруулан залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлаар үндэсний бодлогын хэлэлцүүлэг зохиох;	Сургалтын материал, брошюр, эмхэтгэл, зурагт хуудас, видео, мультимедиа, цахим хуудас, цахим мэдээллийн хуудас гаргах;
Залуучуудын дундах хүчирхийллийн цар хүрээ, хор хохирол, урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга стратегиудын тухай бодлогын тойм боловсруулж/орчуулж, түгээн дэлгэрүүлэх.	Мэдээллийн кампанит арга хэмжээ зохион байгуулж, хэвлэмэл болон цахим материал тараах;	Залуучуудын дундах хүчирхийллийн асуудлаар хурал, сургалт семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах;
	Бодлого гаргагч, хэрэгжүүлэгч нарыг хамруулан эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, цагдаа, залуучуудын дундах хүчирхийллийг сэргийлэх хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулах.	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хэвлэлийн бага хурал, телевизийн шоу, радио нэвтрүүлэг хийж хүчирхийллийн асуудлаар мэдээлэл бичих сургалтад сэтгүүлчдийг хамруулах;
		Залуучуудын дундах хүчирхийллийн урт хугацааны сөрөг үр дагаварыг баримтжуулах.

2. Салбар хоорондын түншлэлийг хөгжүүлэх нь

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн амжилтад хэд хэдэн салбар, байгууллагын оролцоо чухал бөгөөд олон салбар дамнасан хамтын ажиллагааг зангидан чиглүүлэх чухал үүргийг эрүүл мэндийн салбар гүйцэтгэх ёстой. Түншүүд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн нийтлэг зохион байгуулалтыг анхнаасаа хийх нь урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг амжилттай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх баталгааны нэг болдог. Гол гол институцийн түнш нь цагдаа, эрүүгийн шүүхийн байгууллагууд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарууд болон хүүхэд хамгааллын тогтолцоо, согтууруулах ундааны олдцыг зохицуулах үүрэг бүхий байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, залуучуудтай ажилладаг төрийн бус байгууллагууд юм.

Бусад салбаруудтай зөвлөлдөх нь

Янз бүрийн салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудтай зөвлөлдөх нь бат бэх түншлэлийг бий болгох ач холбогдолтойн дээр хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хамтын хүчээр хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд тэдний оролцоог баталгаатай хангах арга зам юм. Уг асуудалд ямар нэг байдлаар хамааралтай бүх байгууллагыг оролцуулах нь амаргүй ажил ч гэлээ гол гол бүлэг, байгууллагын саналыг авалгүй орхих нь урьдчилан сэргийлэх хүчин чармайлтад сөргөөр нөлөөлж, эцсийн дүндээ саналаа оруулж чадаагүй байгууллага хөтөлбөрт оролцохоос татгалзах нөхцөл үүсэж болзошгүй.

Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн эхэнд мэргэжилтнүүд өөрийн салбарын мэдлэг, туршлагаар оролцоогоо хязгаарлах хандлага ажиглагддаг. Жишээлбэл, сэтгэл судлаачид өөрсдийгөө хүчирхийллийн хохирогчидтой ажиллах үүрэг рольтой гэж ойлгон, цагдаа нар харин гэмт этгээдийг барих, шийтгэхэд илүү хөрөнгө нөөц

хуваарилах ёстой гэж үзэж байхад эрүүл мэндийн салбарынхан гэмтлийг эмчлэх асуудал дээр төвлөрч магад. Харин залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр амжилт гаргахын тулд мэргэжлийн чадамжид суурилсан эдгээр байр суурь, үзэл бодол, ур чадварыг ашиглахаас гадна тэдгээрийг нэгдсэн зорилго, нийтлэг стратегид суурилсан өргөн хүрээний бодлогод шигтгэн суулгах шаардлагатай.

Түншлэлийн үйл ажиллагааны сонголтууд

Үндсэн	Өргөтгөсөн	Хүсэмжит
Бусад салбарын яам, байгууллага дотор залуучуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцах хүмүүсийг томилуулж, наад зах нь хоёр өөр салбартай албан бус уулзалт зохион байгуулах;	Гол гол салбаруудтай хамтын ажиллагааг албан ёсоор бий болгох;	Хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, түнш байгууллага бүрийн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгуулах.
Одоо хэрэгжиж буй үйл ажиллагаа, хүрэхээр зорьж буй зорилтуудын талаар мэдээлэл солилцон нийтлэг ашиг сонирхлыг тодорхойлж, мэдээлэл тогтмол солилцох механизм бий болгох;	Зохицуулалтын журам, гүйцэтгэх ажлын даалгаврыг боловсруулж батлах;	
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын зураглал гаргах.	Их хэмжээний нэмэлт хөрөнгө нөөц шаардахгүйгээр хамтран хэрэгжүүлж болох хамтарсан төсөл, арга хэмжээнүүдийг судлах (мэдээлэл солилцох нэгдсэн механизм гэх мэт).	

3. Залуучуудын дундах хүний амь хохироосон болон хүний аминд хүрээгүй хүчирхийллийн талаарх өгөгдөл, эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийн тухай мэдээлэл цуглуулах хэрэгцээ, ач холбогдлыг таниулах нь

Залуучуудын дундах хүчирхийллийг шийдвэрлэх оновчтой бодлого, стратеги боловсруулахад уг үзэгдлийн цар хүрээ ямар байгааг мэдэж байх нь чухал. Нөхцөл байдлын талаар ойлголт, төсөөлөлтэй болж байж бодлого, шийдвэр гаргагчид улс орныхоо хязгаарлагдмал нөөцийг тулгамдсан олон асуудалд хэрхэн хуваарилах талаар үндэслэлтэй шийдвэр гаргах боломжтой болох юм. Олон улс орны туршлагаас харахад, залуучуудын дундах хүчирхийллийн хэмжээ, цар хүрээг үнэлж тодорхойлох нь уг асуудалд улс төрийн болон олон нийтийн дэмжлэгийг татаж, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж эхлэхэд шаардлагатай хөрөнгө мөнгийг дайчлах хөшүүрэг болдог. Цаашилбал, хөтөлбөр хэрэгжүүлэх явцад гарч байгаа ахиц дэвшил, ашиглаж байгаа урьдчилан сэргийлэх стратегийн зардал, үр ашгийг хянахын тулд энэ хүчирхийлэлтэй холбоотой үнэн зөв өгөгдөл, мэдээлэл зайлшгүй шаардлагатай.

Өгөгдөл, мэдээлэл цуглуулах нь нэлээд зардалтай ажил тул цугларсан мэдээллийг нууцлан хадгалах юмуу аль болох их мэдээлэл төвлөрүүлэх зорилгоор бус харин холбогдох хүн, байгууллагуудтай идэвхтэй хуваалцан, залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд ашиглаж байх нь чухал юм.

Залуучуудын дундах хүчирхийллийн талаарх мэдээллийн эх сурвалжууд

Залуучуудын дундах хүчирхийллийн цар хүрээ ба үр дагавар, түүнтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээллийг төрийн болон төрийн бус янз бүрийн эх сурвалжаас авч болох ба Хүснэгт 5-д боломжит эх сурвалжуудыг жагсаалаа.

Боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хууль зүйн яам, цагдаагийн газрын холбогдох хэлтэс, үндэсний статистикийн алба зэрэг нь бүгд л мэдээллийн боломжит эх сурвалж юм. Харин мэдээллийн систем бүр өөрийн сул талтай учраас хэд хэдэн системээс мэдээлэл авч, нэгтгэн боловсруулах шаардлагатай болно.

Мэдээлэл бүрдүүлэлтэд Эрүүл мэндийн яамны үүрэг роль

Эрүүл мэндийн яам нь хүмүүсийн хооронд харилцааны явцад гарсан хүчирхийллийн хохирогчидтой шууд харилцах өвөрмөц боломжтой учраас мэдээлэл бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг. Эрүүл мэндийн салбарын мэдээлэлгүйгээр үндэсний статистик мэдээнд хүчирхийллийн хувь хэмжээ бүрэн тусахгүй, улмаар байгаагаасаа хамаагүй бага харагдах эрсдэлтэй (1). Эрүүл мэндийн яам, түүний харьяа байгууллагууд хүчирхийллийн мэдээллийг дараах үзүүлэлтээр, ингэхдээ хохирогчийн нас, хүйс, гэмтэл учруулах зорилгоор ашигласан хэрэгсэл (жишээлбэл, галт зэвсэг) зэргээр задалж харах боломжтой байдлаар бүрдүүлэх хэрэгтэй. Үүнд:

- хүчирхийллээс үүдсэн нас баралт;
- хүчирхийллээс үүдсэн хүний аминд хүрээгүй гэмтэл;
- залуучуудын дундах хүчирхийллээс үүдсэн хөгжлийн бэрхшээл;
- хүчирхийллээс үүдсэн гэмтлээс бусад эрүүл мэндийн сөрөг үр дагавар;
- хүчирхийллийн газарзүйн тархалт, орчин, нөхцөл байдал;
- хүчирхийллээс үүдсэн эдийн засгийн ачаалал, үүнд эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээний зардал зэрэг болно.

Залуучуудын дундах хүчирхийллийн холбогдолтой мэдээлэл бүрдүүлэхдээ юуны өмнө хүн амын статистикийн гол үзүүлэлтүүд, үүн дотор нас баралтыг бүртгэж авдаг статистикийн системд хандахаас эхлэх нь зүйтэй. Эрүүл мэндийн яам, түүний түнш байгууллагууд нь салбар хоорондын мэдээлэл солилцоог сурталчлан манлайлж, шинжилгээний дүгнэлт, зөвлөмжүүдээ олон нийтэд мэдээлэх замаар хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажилдаа нэн хэрэгтэй дэмжлэгийг бий болгож чадна.

ХҮСНЭГТ 5

Залуучуудын дундах хүчирхийллийн талаарх мэдээллийн боломжит эх сурвалж

МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ БА ТҮҮНИЙГ ЦУГЛУУЛАХААР ХАНДАЖ БОЛОХ ЭХ СУРВАЛЖ		
МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	ЭХ СУРВАЛЖ	АВАХ МЭДЭЭЛЛИЙН ЖИШЭЭ
Нас баралт	Нас барсны гэрчилгээ, хүн амын бүртгэл, эмнэлгийн үзлэгийн/шүүх эмнэлгийн задлан шинжилгээний ба оршуулгын газрын тайлан	Талийгаачийн тухай мэдээлэл, нас барсан шалтгаан, байршил, цаг, нас баралтын ангилал (гаднын нөлөөтэй, амиа хорлолт, осол, тодорхой бус г.м.)
Өвчлөл, эрүүл мэндийн бусад өгөгдөл	Эмнэлгийн бүртгэл, өвчний түүх болон эмнэлгийн бусад мэдээлэл	Өвчин, гэмтэл, бие махбод, сэтгэц, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл
Өөрийн мэдүүлэг	Асуулга, тусгай судалгаа, фокус бүлэг, хэвлэл мэдээлэл	Хандлага, итгэл үнэмшил, зан үйл, заншил, гэмт хэрэг үйлдсэн ба түүнд өртсөн байдал, гэртээ, эсвэл орон нутагт гарсан хүчирхийллийн гэрч
Орон нутаг	Хүн амын бүртгэл, орон нутгийн засаг захиргааны бүртгэл, бусад байгууллагын бүртгэл мэдээ	Хүн амын тоо ба нягтрал, орлогын ба боловсролын түвшин, ажилгүйдлийн хувь хэмжээ, гэр бүл салалтын хувь хэмжээ
Гэмт хэрэг	Цагдаагийн бүртгэл, шүүхийн мэдээ, гэмт хэргийн лабораторийн тайлан мэдээ	Хэрэг зөрчлийн төрөл, гэмт этгээдийн тухай мэдээлэл, хохирогч болон гэмт этгээдийн хоорондын холбоо харилцаа, хэргийн нөхцөл байдал
Эдийн засгийн мэдээлэл	Хөтөлбөрийн, байгууллагын тайлан мэдээ, тусгайлсан судалгаа	Эрүүл мэнд, орон сууц, нийгмийн үйлчилгээний зардал, хүчирхийллээс үүдсэн гэмтлийг эмчлэхэд зарцуулсан зардал, үйлчилгээний зардал
Бодлого, хууль эрх зүйн холбогдолтой мэдээлэл	Засгийн газар ба хууль тогтоох байгууллагын тайлан мэдээ	Хууль тогтоомж, байгууллагын бодлого, үйл ажиллагаа

Эх сурвалж: (1), (233)

Хүчирхийлэлтэй холбоотой статистик мэдээнээс гадна Эрүүл мэндийн яам мөн хандаж болох үйлчилгээний төрөл, байршил, хүчирхийллээс үүдэлтэй асуудлын улмаас үйлчилгээ авахаар хандсан үйлчлүүлэгчийн тоо зэрэг мэдээллийг бүрдүүлэх хэрэгтэй. Тэгвэл бусад яам, агентлагууд дутагдаж байгаа үйлчилгээнүүдийг илрүүлэн тодорхойлж, асуудлыг шийдэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг гаргуулах талаар яриа хэлэлцээндээ Эрүүл мэндийн яамны бүрдүүлсэн мэдээлэл, өгөгдлийг ашиглах боломжтой болно.

Хүчирхийлэл, гэмтлийн талаарх мэдээллийн систем бий болгох нь

Хүчирхийлэл, гэмтлийн харуулдан тандах тогтолцоогүй улс орнууд ч гэсэн хүчирхийллийн цар хүрээ, мөн чанарыг шинжлэх, дунд болон урт хугацаанд гарч байгаа чиг хандлагыг судлахдаа Хүснэгт 5-д жагсаасан мэдээллийн эх сурвалжуудыг ашигладаг. Харин багахан хэмжээний нэмэлт зардал, хүчин чармайлт гаргаад эдгээр эх сурвалжид түшиглэн хүчирхийлэл, гэмтлийн харуулдан тандах байнгын ажиллагаатай мэдээллийг тогтолцоотой болох боломж бий. Залуучуудын дундах хүчирхийллийн улмаас ноцтой гэмтэл авсан хохирогч, зам тээврийн осол гэх мэт бусад шалтгааны улмаас гэмтэл авсан хүмүүс бүгдээрээ нэг л яаралтай тусламжийн тогтолцоонд хандаж үйлчилгээ авдаг тул хүчирхийлэл, гэмтлийн мэдээллийн баазууд нь гэмтлийн бүх шалтгааныг бүртгэх боломжтой байдлаар боловсруулагдсан байх ёстой.

Энэ баазад оруулах мэдээллийн гол эх сурвалж нь нас барсны гэрчилгээн дээрх мэдээлэл, хэвтэн эмчлүүлэгсдийн бүртгэл, мөн яаралтай тусламж үйлчилгээний тасгийн бүртгэл байх юм. ДЭМБ, АНУ-ын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн төв хамтран гэмтлийн мэдээллийн систем бий болгох ажлыг алхам алхмаар тайлбарласан баримт бичиг боловсруулж, “Гэмтлийн харуулдан тандалтын удирдамж” гэж нэрлэн, веб хуудастаа байршуулаад байна (237). Бусад орны туршлагаас дүгнэхэд, эмнэлгийн бүртгэлийн мэдээг ашиглахаар төлөвлөж байгаа бол мэдээллийн системээ эхлээд томоохон нэг эмнэлэг дээр туршин, үр дүнгээр нь мэдээлэл цуглуулах маягыг өөрчлөн сайжруулсны дараа мэдээллийн системдээ бусад эмнэлгийг холбон өргөжүүлэх нь оновчтой. Дэлхийн олон улс орны Эрүүл мэндийн яам гэмтлийн мэдээллийн системээ байгуулахдаа ДЭМБ-ын дээрх удирдамжийг ашиглажээ.

Одоо ашиглагдаж байгаа мэдээллийн эх сурвалжууд залуучуудын дундах хүчирхийллээс үүдэлтэй гэмтлийн давтамж, цар хүрээг дутуу мэдээлдэг ба энэ нь олон шалтгаантай. Залуучуудын дундах хүчирхийллийн олон тохиолдлыг цагдаад мэдээлэлгүй өнгөрдөг. Зарим оронд бүх нас баралтын 10-20 хувь нь л улсын бүртгэлийн албанд бүртгэгддэг ба ноцтой гэмтэл авсан ч албан ёсны эмнэлгийн тусламж авахгүй байх явдал элбэг. Эмнэлгүүд хэвтэн эмчлүүлэгч, яаралтай эмнэлгийн тусламж авсан өвчтөнүүдийн мэдээллийг гаргаж өгч чадах боловч залуу хүмүүсийн үйлдсэн хүчирхийллийн улмаас гэмтэл авсан хүмүүс тусламж авахаар хандахгүй өнгөрөх нь маш элбэг тохиолддог тул тэдний талаар мэдээ, статистикийг хэн ч гаргаж өгч чадахгүй байх магадлал өндөр байдаг. Ийм учраас өрхийн, сургуульд түшиглэсэн зэрэг хүн амын асуулга судалгааг тодорхой давтамжтай, тогтмол явуулж байх хэрэгтэй.

Залуучуудын дундах хүчирхийллийн талаар судалгаа яагаад чухал вэ?

Үе тэнгийнхний дарамт дээрэлхэлт, биедээ зэвсэг авч явах, зодолдох, гэмт бүлэглэлд элсэх, архи, мансууруулах бодис хэрэглэх зэрэг асуудлаар тогтмол явуулж хэвшсэн судалгаагаар тэр бүр илэрдэггүй залуучуудын дундах хүчирхийлэл, түүнтэй холбоотой зан үйлийн талаар илүү гүнзгий мэдлэг, ойлголттой болоход өрхийн, сургуульд түшиглэсэн гэх мэт арга зүйтэй тусгайлсан судалгаа илүү зохимжтой. Эрүүл мэндийн яам өрхийн асуулга явуулахдаа ДЭМБ-аас гаргасан “Гэмтэл, хүчирхийллийн асуудлаар орон нутгийн асуулга зохион байгуулах удирдамж” баримт бичгийг ашиглаж болох (238) бол сургуульд түшиглэсэн асуулга явуулахдаа “Сургуульд түшиглэсэн сурагчдын

эрүүл мэндийн дэлхийн судалгааны (The Global School-based Student Health survey буюу GSHS)” арга зүйг ашиглаж болно (12). Эсвэл эмнэлэг, бусад эх сурвалжид бэлэн байгаа мэдээллийг ашиглахтай зэрэгцүүлэн хүн амын эрүүл мэндийн үндэсний судалгаануудад гэмтлийн тухай асуултууд суулгах аргыг ашиглаж болно.

Судалж буй асуудлын талаар бүрэн дүүрэн ойлголттой болохын тулд асуулгаар бүрдүүлж байгаа өгөгдөл, мэдээллийг нас, хүйсээр ялган харах боломжтой байхаар төлөвлөх хэрэгтэй. Өгөгдөл, мэдээллийг мөн өндөр эрсдэлтэй дэд бүлгүүдээр (жишээлбэл, нийгэм, эдийн засгийн түвшин доогуур хүн ам гэх мэт) ангилж тэмдэглэх хэрэгтэй (улс орон бүрийн онцлогоос шалтгаалж өндөр эрсдэлтэй бүлгүүд нь өөр өөр байна).

Бэлэн байгаа мэдээллийг судалгаагаар баяжуулах нь

Ихэнх улс оронд хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлс, зан үйлийн тодорхойлогч хүчин зүйлс, олон нийтийн мэдлэг мэдээллийн түвшин, эрсдэлийн төсөөллийн түвшин, зан үйлээ өөрчлөхөд бэлэн байдал зэрэг асуудлаар мэдээлэл дутмаг байдаг. Харуулдан тандалт болон асуулга нь бас эрсдэлт хүчин зүйлсийн талаар шаардлагатай бүх мэдээллийг гаргаж өгч чадахгүйн дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөтөлбөрийн амжилт, сайн туршлагыг илрүүлж чадахгүй. Тиймээс мэдээллийн эдгээр бааз, системүүдийн хажуугаар сайтар боловсруулсан судалгаа хийгдэж байх ёстой. Эрүүл мэндийн яам судалгаа хийгээд байдаггүй ч гэлээ нийгмийн эрүүл мэндийн сургууль, эсвэл энэ ажлыг чанартай сайн гүйцэтгэж чадах бусад их дээд сургууль, судалгааны байгууллагатай хамтран ажиллах замаар судалгааг дэмжиж ажиллах ёстой.

Мэдээллийг нэгтгэх, түгээх нь

Зарим яамны өгөгдөл, мэдээлэл цуглуулах чадавх, боломж нь төсөв мөнгөний хязгаарлалтаас болж нэн хумигдмал байдаг. Гэхдээ ядаж л бусад яам, эх сурвалжаас бэлэн байгаа мэдээллийг татан авч нэгтгэх боломж хэзээд бий. Ихэнхдээ өгөгдөл, мэдээлэл цугларсан ч дүн шинжилгээ хийгдэхгүй, ямар нэг байдлаар ашиглагдахгүй байж л байдаг. Ийм мэдээлэл, ялангуяа нас баралт болон эмнэлгийн яаралтай тусламж авахад хүргэсэн гол шалтгаануудын талаарх өгөгдөл, мэдээллийг бага зардлаар цуглуулан нэгтгэж, урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг харуулсан хүчтэй нотолгоо болгон ашиглаж болно.

Мэдээлэл цуглуулах, тараан түгээх үйл ажиллагааны сонголтууд

Үндсэн	Өргөтгөсөн	Хүсэмжит
Залуучуудын дундах хүчирхийллийн тархац, үр дагавар, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх бэлэн мэдээлэл авч болох эх сурвалжуудыг тодорхойлох.	Залуучуудын дундах хүчирхийлэлтэй холбоотой бэлэн байгаа мэдээллийг нэгтгэх; Бэлэн байгаа мэдээллийг ашиглан бодлогын тойм бичиж боловсруулах.	Залуучуудын дундах хүчирхийллийн тархац, эрсдэлт хүчин зүйлсийн талаар үндэсний хэмжээний хүн амын судалгаа явуулах, тогтмол давтаж байх; Эрүүл мэндийн мэдээллийн систем, эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн гэмтлийн бүртгэл, хүн амын бүртгэлийн систем дэх нас баралтын шалтгааны бүртгэл зэрэг нь Өвчлөлийн олон улсын ангиллыг ашиглан хүчирхийллээс үүдэлтэй нас баралтын мэдээг нас, хүйсээр ялган бүртгэж байхад анхаарах.

4. Одоо хэрэгжиж байгаа урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг үнэлэх чадавхыг нэмэгдүүлэх

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үндэсний бодлого, төлөвлөгөө нь анхнаасаа л бодлого, хөтөлбөрийн үнэлгээ мониторингийг хэрхэн хийхийг тусгасан байх ёстой. Үр нөлөөг хэмжих үзүүлэлтүүд нь богино, дунд, урт хугацааг хамарсан байна. Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө үзүүлэлтүүдийн дагуу гарааны нөхцөл байдлаа үнэлэх хэрэгтэй.

Залуучуудын дундах хүчирхийлэлд хүн амын түвшний мониторинг хийх нь

ХДХВ/ДОХ, хумхаа, тамхитай холбоотой өвчлөл зэрэг нийгмийн эрүүл мэндийн асуудлуудын нэгэн адилаар, залуучуудын дундах хүчирхийлэлд хүн амын түвшний мониторинг хийхийн тулд тухайн асуудал, мөн түүнтэй холбоотой эрсдэлт хүчин зүйлсийн мөн чанар, цар хүрээнд гарч байгаа өөрчлөлтүүдийг мэдрэгээр тусгах чадвартай шалгуур үзүүлэлтүүд гаргадаг. Жишээлбэл, ХДХВ-ийн хувьд халдвар авах тохиолдлын тоо, бэлгэвчний хэрэглээний түвшинг хэмжиж болох юм. Хүн амын статистикийн мэдээ, ашиглах боломжтой эрүүл мэндийн мэдээллийн баазууд бий болчихсон улс орнуудад тогтмол цуглуулдаг мэдээллийг ашиглан үзүүлэлтүүдийг хянах боломжтой. Мэдээллийн систем сайн хөгжөөгүй бусад оронд, мөн мэдээллийн баазын тусламжтай хянах боломжгүй зан үйлийн үзүүлэлтүүдийг хэмжихдээ хүн амд суурилсан асуулга судалгааг давтамжтай явуулах замаар мониторинг хийнэ. Жишээлбэл, гэмт хэрэгт өртсөн тохиолдол, эсвэл залуучуудын дундах эрсдэлт зан үйл гэх мэт асуудлаар асуулга авах аргууд бий. Хүн амын түвшинд асуудал хэрхэн илэрч байгааг харуулах үзүүлэлтүүд боловсруулан, мониторинг хийснээр шийдэхээр зорьж буй асуудал, түүнтэй холбоотой эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийн чиг хандлагын өөрчлөлтийг илрүүлэх боломж олгосон мэдээллийн тогтмол урсгал бий болгож болно. Асуулгад өгсөн хариултауд нь, жишээлбэл, залуучуудын дундах хүчирхийлэлд урьдчилан сэргийлэх тодорхой хөтөлбөрийн үзүүлж буй нөлөөг хэмжих, залуучуудын дундах хүчирхийлэлд энэ үзэгдлийг бууруулах зорилго агуулаагүй ч түүнд

нөлөөлдөг эдийн засгийн тэгш бус байдал, ажилгүйдэл зэрэг эрсдэлт хүчин зүйлсэд чиглэсэн бусад бодлого, хөтөлбөрүүд хэрхэн нөлөөлж байгааг хэмжих боломж олгодог.

Мониторинг гэж залуучуудын дундах хүчирхийллийн цөөн хэдэн үзүүлэлтийг тодорхой урт хугацааны туршид хянах утга агуулгатай үйл ажиллагааг хэлдэг бол залуучуудын дундах хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх тодорхой хөтөлбөрийн үнэлгээ бол тухайн хөтөлбөр зорьсон үр дүндээ хүрч чадаж байгаа эсэхийг тогтоох зорилготой илүү гүн гүнзгий судалгааны үйл ажиллагаа бөгөөд үүнийг үр дүнгийн үнэлгээ гэж нэрлэдэг.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилго бүхий тодорхой хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ

Үр дүнгийн үнэлгээ бол хөтөлбөр нь төлөвлөж байсан өөрчлөлтүүдийг (жишээлбэл, эрсдэлт хүчин зүйлсийн өөрчлөлт, зан үйлийн өөрчлөлт, эсвэл хүчирхийллээс үүдсэн гэмтэл, нас баралтын түвшний өөрчлөлт) авчирч чадсан эсэхийг тогтоох маш тодорхой зорилготой. Үр дүнгийн үнэлгээ хийхэд тулгардаг гол асуудал бол ажиглагдсан өөрчлөлтүүд нь өөр бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бус үнэхээр л хөтөлбөрийн үйл ажиллагааны нөлөөгөөр бий болсон гэдэгт итгэлтэй болохын тулд уг өөрчлөлтийг үүсгэсэн байж болох хувилбарт хувьсагч, өөр тайлбар байхгүй гэдгийг баталгаажуулах явдал байдаг. Ийм үнэлгээ нь нөөц хөрөнгөө үр дүнгүй юмуу үр дүн муутай хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахаас хамгаалах баталгаа болдог. Улмаар, үр дүнгийн аливаа үнэлгээ нь хөтөлбөрт оролцсон залуучуудын дунд хүчирхийллийн түвшин цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдсөнийг ижил төстэй орчин нөхцөлд амьдарч байгаа хөтөлбөрт хамрагдаагүй залуучуудад хамаарах үзүүлэлтүүдтэй харьцуулж дүгнэдэг.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөө нь зөвхөн хөтөлбөр хэрэгжүүлсэн бүс нутагт хамаарах баримт, нотолгоонд суурилсан байдаг тул бага, дунд орлоготой улс орнуудад хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь тухайн орны онцлогт нийцсэн үнэлгээний төлөвлөгөө агуулсан байх шаардлагатай. Үр дүнгийн сайн үнэлгээ нь урьдчилан сэргийлэлтийн зорилтуудаа оновчтой сонгох, логик хүрээгээ үндэслэлтэй боловсруулах, судалгааны аргачлал, хамрагдах хүн ам, хүлээгдэх үр дүн, мэдээллийн эх сурвалж болон дүн шинжилгээний аргуудаа зөв сонгох зэрэг асуудлыг багтаах тул хөтөлбөр төлөвлөлтийн шатнаас л үнэлгээний асуудалд шинжлэх ухаанчаар хандах шаардлагатай. Тиймээс, хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ хийх туршлагатай, нэр хүнд сайтай судалгааны юмуу эрдэм шинжилгээний байгууллагатай түншлэн ажиллах зайлшгүй шаардлага үүсэх тохиолдол их гардаг.

Эцсийн дүнд, үр дүнгийн үнэлгээг ямар арга зүйгээр хийх сонголт нь уг үнэлгээгээр судалгааны ямар асуултуудад хариулт хайж байгаа, ажиглагдсан үр дүнг хөтөлбөрийн үйл ажиллагааны үрдүн мөн гэж хамааруулах хэр өндөрт түвшний баталгаа шаардлагатай зэргээс хамаарна. Судалгааны арга зүйг сонгохдоо сонирхож байгаа тодорхой аргуудын давуу талыг хөтөлбөрийн бодит боломж, санхүүгийн хязгаарлалтуудтай харьцуулж үзэх хэрэгтэй. Мөн хөтөлбөрийн өөр өөр үе шатанд үр дүнгийн үнэлгээний өөр өөр аргууд илүү нийцтэй байж болно. Жишээлбэл, урьдчилан сэргийлэх шинэ бодлого, стратеги хэрэгжүүлж байгаа бол хөтөлбөр эхлэхээс өмнө болон хэрэгжүүлж дуусангуут оролцогчдоос хэрэгжилтийг үнэлэх судалгаа авч, тухайн стратеги хэр ирээдүйтэй

байгааг тодорхойлж болно. Үнэлгээгээр уг хөтөлбөрийн үр дүнд гарсан өөрчлөлтүүд зөв чигт, хангалттай цар хүрээтэй байх шиг байна, ижил зорилготой хөтөлбөрүүдтэй адил хэмжээнд юмуу илүү байна зэрэг дүгнэлт гарвал хөтөлбөр сайн үнэлгээ авсан гэж ойлгож болно. Хэсэг хугацааны дараа уг хөтөлбөр нь хүрэхээр зорьж буй өөрчлөлт, үр дүнгээ үнэхээр гаргаж чадаж байгааг илүү сайн батлах баримт, нотолгоо бүрдүүлэх зорилгоор санамсаргүй түүвэрт суурилсан үнэлгээ юмуу хөтөлбөрийн болон хяналтын бүлгүүдийг харьцуулах үнэлгээ хийж болно. Харин бодлого, стратеги нь үр нөлөөтэй байгааг нэгэнт баталчих юм бол хөтөлбөр, арга хэмжээ нь үр дүнтэй хэвээр байгааг хянах зорилгоор явцын өгөгдөл, мэдээллийг тогтмол цуглуулахад анхаарах хэрэгтэй.

Мониторинг, үнэлгээний хүрээний арга хэмжээний сонголтууд

Үндсэн	Өргөтгөсөн	Хүсэмжит
Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийнхөө боловсруулалтын болон процессын үнэлгээг хийх;	Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэхээс өмнө ба дараа нь мэдээлэл цуглуулах замаар энгийн үр дүнгийн үнэлгээ хийх, ингэхдээ боломжтой бол хөтөлбөрт хамрагдсан бүлгийг үнэлгээ, дүгнэлтийг ижил төстэй шинж чанартай ч хөтөлбөрт хамрагдаагүй бүлгийн мэдээлэлтэй харьцуулах арга зүйг ашиглавал сайн.	Үр дүнгийн хагас туршилтын үнэлгээ юмуу санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон хөтөлбөрийн болон хяналтын бүлгийг харьцуулах судалгаа хийх. Хяналтын бүлэг нь хөтөлбөрийн бүлэгтэй шинж чанарын хувьд ижил боловч хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамрагдаагүй хүмүүсээс бүрдэнэ.
Танай хөтөлбөр, төсөл, бодлогын үр нөлөөг харуулж чадах өгөгдөл, мэдээллийн бэлэн эх сурвалжуудыг тодорхойлох (жишээлбэл, эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг);		Үнэлгээний үр дүнг эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлэх.
Наад зах нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын мэдээллийг бүрдүүлж байх (жишээлбэл, хөтөлбөрийн дундаас гарсан хүмүүсийн мэдээлэл); хөтөлбөрийн магадлалт сул, давуу талуудыг тодорхойлох зорилгоор сонирхогч талуудаас фокус бүлгийн судалгаа, гүнзгийрүүлсэн ярилцлага авч байх.		

5. Бодлогын хүрээг тодорхойлох нь

Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүд нь залуучуудыг хүчирхийлэл үйлдэх, өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, зохицуулалт, хэрэгжилтийг хангахад нэн чухал үүрэгтэй. Эдгээр бодлого, төлөвлөгөөтэй холбоотойгоор дараах хэдэн чухал асуудалд онцгой анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэндийн салбарт хамааралтай үндэсний бүх хөтөлбөрт залуучуудын хүчирхийллийг урьдчилан сэргийлэх тухай бүлэг багтсан байх ёстой;
- Эрүүл мэндийн яам залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Энэ баримт бичигт Яамнаас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй

тодорхой үйл ажиллагаа, хүрэх үр дүнг тусгахаас гадна нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд багтаах тодорхой зорилт, үр дүнг тусгасан байна;

- Боломжтой бол, салбар хоорондын хамтын ажиллагааг зангидан чиглүүлсэн нэмэлт Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй. Эрүүл мэнд, хууль зүй, боловсрол гээд холбогдох салбарын төлөөлөл оролцож, салбар тус бүрийн хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүнг тодорхойлон тусгасан энэ Төлөвлөгөө нь яамдын хамтын ажиллагааг удирдан зохицуулах баримт бичиг болох юм.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг Эрүүл мэндийн яам удирдана. Туршлагаас харахад, үндэсний юмуу орон нутгийн түвшний бодлогын баримт бичиг боловсруулах үйл явц нь эцсийн дүн болох бодлогын баримт бичгээсээ дутуугүй ач холбогдолтой. Үйл явцад төрийн ба төрийн бус байгууллага, их дээд сургууль, холбогдох салбарын төлөөлөгчдийг оролцуулах хэрэгтэй. Анхаарлын гадуур үлдсэн асуудал, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор одоо хэрэгжиж байгаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үнэлж судлах, бэлэн авч ашиглаж болох баримт, мэдээллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа гол гол бүлэг, хүмүүсийг тодорхойлохоос ажлаа эхлэх нь зүйтэй.

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж байхдаа үндсэн нэр томьёо, зорилт, үзүүлэлтүүдээ оновчтой томьёолохын тулд байнга зөвлөлдөх шаардлагатай. Зөвлөлдөхдөө мэдээлэл цуглуулах, урьдчилан сэргийлэх бодлогууд, эрх зүйн болон төлөвлөлтийн баримт бичгүүд, чадавх бэхжүүлэх болон мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа зэрэг бүхий л сэдвийг хамруулна. Ялангуяа хүүхэдтэй зүй бус харьцах, үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх, архи согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зэрэг бие даасан, тодорхой чиглэлтэй санаачилга, үйл ажиллагааг залуучуудын дундах хүчирхийллийн асуудлын хүрээнд багтаан оруулж ирэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд нь хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэх эрсдэлтэй хүүхэд, өсвөр насныхан, залуучуудын ялгаатай хэрэгцээг анхаарсан байвал зохино.

Салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө

Улс орнууд эрүүл мэндийн салбар, мөн залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг оролцоотой хууль зүй, боловсрол, хөдөлмөр, төсөв санхүү, цагдаа, нийгмийн хамгааллын салбаруудын хамтран хэрэгжүүлэх олон салбар дамнасан Үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөртэй байх ёстой. Эдгээр салбарын санаачилга, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах нь амар ажил биш бөгөөд ялангуяа салбарууд хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх туршлага багатай бол онцгой бэрх байх магадлалтай. Эрүүл мэндийн яам нь төрийн яам, агентлагийн хариуцах ажил, гүйцэтгэх үүргийг албан ёсоор тодорхойлж өгсөн Үйл ажиллагааны хамтарсан төлөвлөгөөг боловсруулах ажлын зангидан чиглүүлэх үүргийг гүйцэтгэх боломжтой.

Салбарууд хамтран ажиллах шаардлагатай байгааг нийгмийн эрүүл мэндийн бусад асуудлын хүрээнд нэлээд эртнээс ярьж эхэлсэн. Жишээлбэл, Эрүүл мэндийн яам хумхаа өвчнийг урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд намаг, тогтоол усыг хатаах ажлыг нийтийн үйлчилгээний салбарыг хариуцсан яам, агентлагтай хамтран хийдэг. Салбаруудын хамтын ажиллагааг зохион байгуулах арга зүй, нэгдсэн аргачлал гэж байхгүй тул хэнтэй хамтрах, хэрхэн хийх нь зөвхөн тухайн төслийн онцлогоос хамаарах асуудал юм. Жишээлбэл, Эрүүл мэндийн яамны хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нэгж хийж гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний тайлангаа холбогдох яам, албадад танилцуулах, бусад яамдын мэргэжилтнүүдийг урьж сургалт хийх зэрэг санаачилга гаргах замаар хамтын ажиллагааг эхлүүлж болно. Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нэгж, асуудал хариуцсан албан тушаалтнууд эхлээд хамтран ажилласнаар илүү өгөөжтэй шийдэж болох бодлогын асуудлуудыг жагсааж, эдгээр асуудлаар бусад салбарын дэмжлэгийг системтэйгээр, тууштай эрэлхийлэх стратеги баримтлах хэрэгтэй.

Эрх зүйн арга хэмжээ

Гэмт хэрэг, хүчирхийллийн эсрэг хууль тогтоомж баталж, хэрэгжилтийг хангуулах нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх болон зөвшөөрч болохгүй зан үйлийн хэм хэмжээг тогтоож улмаар аюулгүй, тайван нийгмийг цогцлооход чухал нөлөөтэй. Хувь хүмүүсийн хооронд гарсан хүчирхийллийг айх айдасгүй мэдээлэх боломж олгосон, мөн эрх зүйн хамгаалалт, дэмжлэгийг хүн бүрт ялгаварлалгүй хүргэхэд чиглэсэн бодлого, стратеги онцгой чухал юм. Заримдаа, эрүүгийн хариуцлага хүлээх айдас нь хүчирхийлэл үйлдэхээс татгалзах нөлөө үзүүлэх нь бий. Жишээлбэл, хүчирхийлэл үйлдэн ял эдэлж буй хүний ойр дотныхонд ийм нөлөө үүсэж болохоос гадна хүнд биш ч гэсэн гэсгээл шийтгэл заавал хүртэх нөхцөл нь ийм урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлэх магадлалтай. Тиймээс залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажлын нэг чухал зорилт нь хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй этгээд өөрөө энэ үйлдлээс татгалзан, үйлдэхгүй байх (ядаж л үйлдсэн хэргийнхээ төлөө хариуцлага хүлээх) магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн эрүүл мэнд болон аюулгүй байдлыг хангах үүрэгтэй эрүүгийн эрх зүй, цагдаа зэрэг салбаруудын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих явдал юм. Шаардлагатай бол хууль сахиулах үйл ажиллагааг сайжруулах үүднээс эдгээр салбарын байгууллага, агентлагуудыг бэхжүүлэх дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд онцгой чухал хуулиуд

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр боловсруулахдаа эхлээд шинэ хууль, эрх зүйн баримт бичиг батлах замаар шийдэх ёстой орхигдсон асуудлууд байгаа эсэх, батлагдсан хуулиуд нь хангалттай түвшинд хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох зорилгоор өнөөгийн эрх зүйн орчны шинжилгээг хийх шаардлагатай болдог. Мөн бусад орон, ялангуяа ижил төстэй нийгэм, соёлын нөхцөл бүхий улс орнуудын хэрэгжүүлж байгаа залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг судлах нь тустай байдаг.

Залуучуудыг хүчирхийлэлд түлхдэг эрсдэлт хүчин зүйлсийг өөрчлөхөд ашиглаж болох олон хуулийн жишээг нэрлэж болох бөгөөд үүнд согтууруулах ундааны үнэ, татвар, олдцыг хянах хуулиуд, хүүхдэд бие махбодын шийтгэл үзүүлэх, хүүхэдтэй зүй бусаар харьцахыг хориглосон хуулиуд, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой зохицуулалт, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалахтай холбоотой зохицуулалт, гэмт бүлэглэлийг хориглох хууль багтана. Харин залуучуудыг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэхэд орон байрны нөхцөл, нийгмийн хамгаалал, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах бодлого, зохицуулалтууд сайн нөлөөтэй байна.

Эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийн үйл ажиллагааны сонголтууд

Үндсэн	Өргөтгөсөн	Хүсэмжит
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажилд бодлого боловсруулах үйл явцын бүхий л үе шатууд чухал бөгөөд ямар ч нэмэлт хөрөнгө шаардахгүйгээр, эсвэл маш бага мөнгөөр хийж гүйцэтгэх боломжтой.		
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжуудыг судлах		

6. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх нь

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд мэдлэг, чадвар сайтай хүний нөөц, системтэй дэмжлэг, сайн холбоо сүлжээ шаардлагатай. Эдгээр чиглэл тус бүрээр чадавх бэхжүүлэх дэмжлэг шаардлагатай болж мэдэх ба энэ дэмжлэгийг хангахад Эрүүл мэндийн яам чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх нь

Хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэхэд сургалтад хамрагдан, зохих бэлтгэл хангасан байх нь чухал ба энэ холбогдох байгууллагуудын ажилтан, асуудал хариуцсан мэргэжилтэн, бодлого шийдвэр гаргагчид гээд бүгдэд хамаатай. Зорилго нь залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлд ажиллаж байгаа янз бүрийн салбарын мэргэжилтнүүд нэгдсэн ойлголттой болж, мэдлэг, ур чадварын нийтлэг суурьтай болох явдал юм. Хүчирхийллийг урьдчилан сэргийлэхтэй холбоотой сургалтын үйл ажиллагаа нь өнөөг хүртэл тогтмолжоогүй байна. Эрүүл мэндийн яам энэ асуудлыг шийдэхэд дараах дэмжлэг үзүүлж болох юм:

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх сургалт. Сургалтыг нийгмийн эрүүл мэнд, сувилахуйн болон анагаах ухааны сургуулийн сургалтын хөтөлбөрт суулгаж өгөхийн зэрэгцээ эрүүл мэндийн болон статистикийн албаны ажилтнууд, бусад яамдын холбогдох мэргэжилтнүүдийн давтан болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд тогтмол хэрэгжиж байх ёстой. Сургалтад ашиглаж болох нэгэн хэрэглэгдэхүүн бол гэмтэл, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх TEACH-VIP нэртэй модуль сургалтын хөтөлбөр юм. Яам агентлаг, гэмтлийн төв, төрийн бус болон боловсролын байгууллагууд амжилттай ашиглаж буй TEACH-VIP хөтөлбөрийг дэлхийн олон орны мэргэжилтний дэмжлэгтэйгээр ДЭМБ боловсруулсан юм.

Техникийн болон мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх. Энэ асуудлын хүрээнд судалгаа хийх, харуулдан тандалтын мэдээллийг систем бий болгох зэрэг техникийн ур чадвар шаардлагатай. Мөн төслийн удирдлага, хөрөнгө дайчлах, харилцаа холбоо, манлайлал зэрэг мэргэжлийн ур чадвар шаардлагатай. Эрүүл мэндийн яам нь асуудал хариуцсан гол албан тушаалтнуудыг тодорхойлж, туршлага солилцох айлчлал, хамтын ажиллагаа, зөвлөн дэмжих үйлчилгээ зохион байгуулах зэргээр сурах, чадавхаа бэхжүүлэх боломжийг хангаж өгөхөд анхаарах хэрэгтэй.

Үр нөлөөтэй сүлжээний үйл ажиллагааг дэмжих нь

Тодорхой улс дотор болон олон улсыг хамарсан хамтын ажиллагааны сүлжээнүүд хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлж чадна. Нэг улсын хүрээнд авч үзвэл урьдчилан сэргийлэх чиг үүрэг нь улсын болон хувийн хэд хэдэн салбарт таран хуваарилагдсан байдаг тул үүнд сайн зохицуулалт шаардлагатай. Эрүүл мэндийн яам нь салбаруудыг холбосон үндэсний хэмжээний сүлжээ бий болгох замаар мэдээллийн солилцоо, төлөвлөлт, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бололцоотой. Улс орнуудын хооронд бол сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг хурдасгаж, бодлого боловсруулалтад дэмжлэг болох техникийн мэдлэг, туршлага солилцоонд анхаарах нь зүйтэй.

Чадавхыг бэхжүүлэх чиглэлийн сонголтууд

Үндсэн	Өргөтгөсөн	Хүсэмжит
Эрүүл мэнд, нийгмийн ажлын мэргэжилтэн бэлдэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулга оруулах; Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцах албан тушаалтан бий болгох, нэгж байгуулах.	Бусад салбар, ТББ-тай хамтран залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх стратеги боловсруулах.	Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлаар ажиллаж байгаа мэргэжилтэн албан тушаал ахих боломжууд бий болгох; Их дээд сургуулиудад хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгаар хичээл, судалгааны чиглэл бий болгох.

Дүгнэлт

Залуучуудын дундах хүчирхийлэл нь хялбар шийдэлтэй энгийн асуудал биш юм. Гэвч урьдчилан сэргийлэх ажлыг урагшлуулж, амжилтад хүргэх боломж бий бөгөөд энэ нь бага, дунд орлоготой улс орнуудад ч хамаатай. Залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд ямар бодлого, стратеги үр нөлөөгөө өгөх, эдгээрээс аль нь бага, дунд орлоготой орнуудад амжилттай хэрэгжиж болох тухай мэдээлэл хомс байгаа нь урьдчилан сэргийлэх ажилд тулгарч ирсэн гол бэрхшээл юм. Тиймээс энэ гарын авлага нь өмнө нь хэрэгжүүлсэн ажлын туршлага, гарсан үр дүнгийн нотолгоонд түшиглэн стратеги, хөтөлбөр төлөвлөн боловсруулахад тус болохыг зорьж байгаа ба цаашдаа өнөөдрийн хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдээс гарах баримт нотолгоо нь дараа дараагийн бодлого, хөтөлбөр төлөвлөлтийн суурь болсноор ирээдүйд залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан бодлого боловсруулалт арай хялбар болно гэж найдаж байна.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх цогц арга зүй нь залуу хүнийг хүрээлэн буй орчин экологийн янз бүрийн түвшинд чиглэсэн арга хэмжээнүүд авахыг шаардана. Эдгээр арга хэмжээ нь эдийн засгийн тэгш бус байдал, хүүхэдтэй зүй бус харьцахаас авхуулаад хэт хөдөлгөөншил, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд гээд олон эрсдэлт хүчин зүйлийг анхаарсан байх шаардлагатай. Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, сургуульд түшиглэсэн амьдрах ухааны ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр, эмчилгээ заслын үйлчилгээ, согтууруулах ундааны олдоц, зохисгүй хэрэглээг бууруулах бодлого нь бүгд залуучуудын дундах хүчирхийллийг бууруулахад үр нөлөөтэй байгаа нь өндөр орлоготой улс орнууд, мөн зарим нэг бага, дунд орлоготой орны туршлагаар нотлогдоод байна. Улмаар эдгээр хөтөлбөр, арга хэмжээ нь залуу хүмүүсийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эхлүүлж байгаа улс орнуудад гарааны цэг болж болохын зэрэгцээ бодлого, стратегиудаа шинэчлэх гэж буй орнуудад мэдээлэл болох юм.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой хэд хэдэн зарчмыг энэ гарын авлагад баримталсан ба эдгээрийг тоймлон танилцуулъя:

- Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүд нь залуучуудын дундах хүчирхийллийн цар хүрээ, үр дагавар, шалтгаан, урьдчилан сэргийлэх боломж, янз бүрийн стратегийн үр нөлөөг судалсан дотоодын болон олон улсын судалгааны шинжлэх ухааны үндэстэй нотолгоонд тулгуурлан боловсруулагдах ёстой.
- Боломжтой бүхий л тохиолдолд залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, мониторингийг тухайн оронд бий болчихсон нийгмийн эрүүл мэндийн мэдлэг чадвар, дэд бүтцэд түшиглэн хэрэгжүүлэх хэрэгтэй.

- Залуучуудыг хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөхөөс амжилттай урьдчилан сэргийлэхийн тулд нотолгоонд суурилсан арга хандлагаар ажиллах зайлшгүй шаардлагатай ч энэ нь дангаараа хангалттай байж чадахгүй юм. Урт хугацаандаа үр нөлөөгөө хадгалах тогтвортой, системтэй үйл ажиллагаа бий болгохын тулд бусад салбар, сонирхогч бүлэг, хувь хүмүүсийн оролцоог хангаж, хамтран ажиллах шаардлагатай.

Дээрх зарчмуудыг баримталснаар залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа уялдаа холбоо сайтай, илүү системтэй болж, бодитой үр дүн авчирна. Залуучуудын хүчирхийллийн түвшин буурч, тэдний эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн эерэг үзүүлэлтүүд нэмэгдэн сайжирна. Залуучуудын дундах хүчирхийлэлд анхаарлаа хандуулж, энэ гарын авлагад танилцуулсан зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллах төрийн байгууллагын тоо нэмэгдэхийн хэрээр бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг үнэлсэн нотолгоо нэмэгдэнэ. Улмаар бодлого, хөтөлбөр төлөвлөх, хөрөнгө нөөцийн хуваарилалттай холбоотой шийдвэр гаргах хүмүүсийн гар дээр шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл төвөггүй очих боломж бүрдэнэ. Залуучуудын хүчирхийллийн асуудлаар ажиллахдаа нотолгоонд суурилсан хандлага баримтлах ёстой бөгөөд энэ нь урьдчилан сэргийлэлт удаан хугацаанд үр нөлөөтэй байхын баталгаа юм. Өнөөдөр бүрдээд байгаа нотолгоо, мэдээллийн бааз нь зөвхөн өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагаар хязгаарлагдаж байгаа учраас бага, дунд орлоготой орнуудын шийдвэр гаргагчдад шууд аваад итгэлтэйгээр ашиглах баримт, мэдээлэл болж чадахгүй байна. Тиймээс нотолгоо бүрдүүлэхэд анхаарсан аргачлалаар боловсруулсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр, үйл ажиллагааны тоог нэмэгдүүлэх нь цаашид ч нотолгоонд суурилсан хандлага алдагдахгүй байхын баталгаа болох юм.

Ном зүй

1. Krug E, Dahlberg L, Mercy J, Zwi A, Lozano R. World report on violence and health. Geneva: World Health Organization; 2002.
2. Global status report on violence prevention 2014. Geneva: World Health Organization; 2014.
3. Handbook for Guideline Development. 2 ed. Geneva: World Health Organization; 2014.
4. Mercy JA, Butchart A, Farrington D, Cerdá M. In: World report on violence and health 2002. Geneva: World Health Organization; 2002:23–56.
5. Mercy JA, Butchart A, Rosenberg ML, Dahlberg L, Harvey A. Preventing violence in developing countries: a framework for action. *International Journal of Injury Control and Safety Promotion*. 2008;15(4):197–208.
6. Smith PK, Shu S. What good schools can do about bullying: findings from a survey in English schools after a decade of research and action. *Childhood*. 2000;7(2):193–212.
7. Sivarajasingam V, Page N, Morgan P, Matthews K, Moore S, Shepherd J. Trends in community violence in England and Wales 2005–2009. *Injury-International Journal of the Care of the Injured*. 2014;45(3):592–8.
8. Florence C, Shepherd J, Brennan I, Simon T. Effectiveness of anonymised information sharing and use in health service, police, and local government partnership for preventing violence related injury: experimental study and time series analysis. *British Medical Journal*. 2011;342:d3313.
9. Gawryszewski VP, Silva MMA, Malta DC, Kegler SR, Mercy JA, Mascarenhas MDM, et al. Violence-related injury in emergency departments in Brazil. *Revista Panamericana De Salud Publica-Pan American Journal of Public Health*. 2008;24(6):400–8.
10. Injury Prevention & Control: Data & Statistics (WISQARSTM) [Internet]. United States Centers for Disease Control and Prevention; 2014 (<http://www.cdc.gov/injury/WISQARS/>, accessed 20 August 2014).
11. Nicol A, Knowlton LM, Schuurman N, Matzopoulos R, Zargarani E, Cinnamon J, et al. Trauma Surveillance in Cape Town, South Africa: An Analysis of 9236 Consecutive Trauma Center Admissions. *Jama Surgery*. 2014;149(6):549–56.
